
№2 Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам



Есусийн Дотор Байгтун

Есус Христ:
"Миний дотор байгтун, Би ч та нарын дотор байна."

Чунийг хэрхэн хийх вэ?

ХЭЛМУТ ХАУБЭЙЛ

Хэвлэл:
Эх хувилбар:
TOP Life Wegweiser-Verlag GmbH, Wien

Эхний хэвлэл англиар, 2016 оны 10-р сар
Хоёр дахь хэвлэл 2019 оны 1-р сар
Гурав дахь хэвлэл 2019 оны 8-р сар

Зохиолч:
Симон Эйтэнбергер, www.desim.de

Найруулагч:
Конрад Принт & Медиан, www.konrad-medien.de

Монгол хэлнээ:
Орчуулсан: Б. Ууганцэцэг
Редактор: О. Адъяахүү
Хянаж, эх бэлтгэсэн: Ж. Пүрэвдулам
Библийн эшлэлүүдийг Библийн Нийгэмлэгийн 2004, 2013 оны “Ариун Библи”-ээс авав.

Орчуулгыг захиалах, холбоо барих:
© Helmut Haubeil, Rosenheimer Str. 49
D-83043 Bad Aibling / Oberbayern – Germany
Имэйл: helmut@haubeil.net or if returned
helmut.haubeil@gmail.com
Утас: +49 (0)8061 4900 712

Орчуулгууд:
Эх хувилбар нь Герман хэл дээр бөгөөд *Этиоп-Амхарик, Индонез-Бахаса, Болгар, Хорват, Чех, Дани, Англи, Филиппин-Тагалог, Франц, Энэтхэг-Хинди, Унгар, Рванда-Киняранванда, Бурунди-Кирунди, Энэтхэг-Мизо, Энэтхэг-Одья, Польш, Португаль, Румын, Орос, Серб, Словян, Испани, Швед, Энэтхэг-Телугу, Пакистан-Урду, Ветьнам хэлүүд дээр орчуулагдсан болно. Мөн Араб, Бенгал-Бангла, Бирм, Хятад-Мандарин, Голланд, Итали, Лионе-Крио Сир, Латви, Малайз, Норвеги, Зүүн Африк-Свахили, Тонгагийн Арлууд-Тонга* хэлүүд дээр орчуулагдаж байна.

Веб хуудас:
www.steps-to-personal-revival.info ба www.schritte-zur-persönlichen-erweckung.info хэмээх сайтуудад орчуулсан хувилбарууд тавигдах бөгөөд уншиж, хэвлэж мөн найз нөхдөдөө илгээж болно.
Веб хуудасны цэсэнд: Гэрчлэлийн түүхүүд (150 гаруй), Сайжруулалт, Хэрхэн сонирхлоо төрүүлэх вэ?, Ариун Сүнсний тухай эшлэлүүд, Удирдагч, Хуваалцах, Холбоо барих гэсэн хэсгүүд бий.

Захиалгын мэдээлэл:
Илүү мэдээллийг 2-р хуудаснаас хараарай.

Бүх эшлэл болон санаануудыг Ариун Библийн NKJV, NIV хувилбаруудаас авсан болно. Зохиогчийн эрх 1973, 1978 Олон улсын Библийн нийгэмлэг. Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Олон улсын Библийн Нийгэмлэгийн зөвшөөрөлтэйгөөр ашигласан болно.

Цуврал 2

ЕСҮСИЙН ДОТОР БАЙГТУН

Чуниг хэрхэн хийх вэ?

“Жолли Пресс” Хэвлэлийн Газар
2021 он

ЗАХИАЛГЫН МЭДЭЭЛЭЛ

АНУ
Улдсэн хэвлэлүүд
649 E. Chicago Rd
Coldwater MI, 49036
Утас: 800-423-1319 or 517-279-13043 Захиалгын веб хаяг: www.remnantpublications.com

Канад
Lucas Jurek 118 G First Avenue North Williams Lake, BC V2G 1Y8
Имэйл: lucasjurek@gmail.com
Утас: 250 983 - 2650

Австрали
Colin Hone
Booklets in English colin.hone@murrayhone.com.au

Филиппин
Allan D. Faina, Имэйл: allan@lightingtheworld.org SDA church Fidela Herrera Subd Bgy. Santol, Tanza, Cavite-4108
Утас: (63) 926 054 1175

Орос
Source of Life Publishing House
Vostochanya St. 9 Zaoksky 301000 Tula Region,
Утас: +78 73 42 01 01

Европ болон Орос хэл
Christa Medien GmbH Pulverweg 6 D-21337
Luneburg (Germany)
Утас: +49 (0)4131 9835-580
www.christa-medien.eu und www.christa-shop.eu
Имэйл: info@christa-medien.eu

Герман
Wertvoll leben Im Kiesel 3, D-73635 Rudersberg www.wertvollleben.com имэйл: info@wertvollleben.com
Утас: +49 (0)7183 - 3071332
Утас: +49 (0)7183 – 3099847

Австри
TOP Life Wegweiser-Verlag Prager Str.287, A-1210 Wien/Vienna www.toplife-center.com
Имэйл: info@wegweiser-verlag.at
Утас: +43 (0)13199301-0

Австри болон Герман
Adventist Book Center Bogenhofen, A-4963 St.Peter/Hart www.adventistbookcenter.at
Имэйл: info@adventistbookcenter.at
Утас: +43 (0)2294000

Швейцар
Advent-Verlag Leissigenstr. 17, CH-3704 Krattigen www.av-buchshop.ch имэйл: info@advent-verlag.ch
Утас +41 33 654 1065
Имэйл: www.lifesource.ru

Есусийн Дотор Байгтун

Есус Христ:
"Миний дотор байгтун, Би ч та нарын дотор байна."

Чунийг хэрхэн хийх вэ?

ХЭЛМУТ ХАУБЭЙЛ

ҮР ЖИМСТЭЙ АМЬДРАЛ

Есүс хэлэхдээ:
"... Хэн Миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр хүн **ИХ ЖИМС** гаргана" Иохан 15:5.

Тэгэхээр би хэрхэн Есүсийн дотор байх вэ?
Есүс биднийг: Над руу ир! хэмээн урьдаг (Матай 11:28). Есүс дээр ирсэн хэн боловч Түүнтэй үлдэх урилгыг авдаг (Иохан 15:4). Тэгэхээр ийм зүйл хэрхэн хэрэгждэг вэ?

"Миний дотор байгтун, Би ч та нарын дотор байна."
"Христийн дотор байна" гэдэг нь:
- **Түүний Сүнсийг тасралтгүй хүлээн авах,**
- **Түүнд болон Түүний үйлчлэлд зүрх сэтгэлээрээ бүрэн бууж өгсөн амьдрал юм.** *Ye Yeийн Хүслэн,* 676.2

Энэ тайлбар үнэхээр миний нүдийг нээж, Бурхантай хамт алхах талаар тодорхой ойлголт өгсөн юм. Миний хувьд энэ бол аз жаргалтай Христэд итгэгчийн амьдралын нууц юм (Иохан 15:11). Энэ ном танд баяр хөөртэй, сэтгэл хангалуун амьдралд хүргэх олон арга замыг зааж өгөх болтугай. Энэ бол миний онцгой хүсэл бөгөөд залбирал билээ. Тиймээс эдгээр үгс нь *"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* хэмээх энэхүү цувралын үндэс суурь юм.

Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам хэмээх гурван цуврал ном маань хоорондоо ямар хамааралтай вэ?

No. 1 *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам*
Ариун Сүнсээр дүүрэх нь
Үүнийг хэрхэн мэдрэх вэ?
Түүний Сүнсийг байнга гуйж, хүлээн авах тухай ном юм.

No. 2 *Есүсийн Дотор Байгтун*
Үүнийг хэрхэн хийх вэ?
Есүс Христэд бүрэн бууж өгсөн амьдралын тухай ном юм.

No. 3 *Сүнсээр Дүүрэн Есүсийн Хамтрагчид*
Хэрхэн Сүнсээр дүүрэн хамтрагч болох вэ?
Түүний үйлчлэлд болон бүх гайхалтай үр дагаварт нь бүрэн бууж өгөх тухай ном юм.

Урмын үг
Туршлагаас харахад, энэхүү номыг хоёр хоёроороо өдөр бүр судлах нь илүү ивээлтэй байдаг. Хосууд хамтдаа судалбал бүр ч илүү ивээгдэх болно! (Бусад хүмүүстэй утсаар эсвэл Skype-аар холбогдож болно). Түүнчлэн хамт олноороо өдөр бүр эсвэл долоо хоногийн давтамжтайгаар харилцан ярилцаж, залбиралтайгаар судалбал илүү их урамтай байх болно.

ГАРЧИГ

Бүлэг 1

ЕСҮСИЙН ХАМГИЙН НАНДИН БЭЛЭГ

Хэсэг 1 *Та Есүсийн хамгийн хүчирхэг сургаалтай танилцсан уу? Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ?* 9

Хэсэг 2 *Бидний зан чанар хэрхэн өөрчлөгдөж болох вэ? Есүс Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэлээр Ариун Сүнсийг онцолдог* 21

Бүлэг 2

ЕСҮСТ БУУЖ ӨГӨХ НЬ

Хэсэг 1 *Би өөрийн хүслээ үгүйсгэдэг үү? Эсвэл бид үүнийгээ улам хүчирхэг болгодог уу?* 33

Хэсэг 2 *Биднийг Бурханд бууж өгөхөд юу саад болдог вэ? Бурханд бууж өгнө гэдэг нь өөрсдийн хүслээ хаяна гэсэн үг үү?*....43

Бүлэг 3

ТАНЫ ДОТОР БАЙХ ЕСҮС

Хэсэг 1 *"Христ таны дотор байхад" таны амьдралд ямар нөлөө үзүүлдэг вэ? Хамгийн гол ололт: Бурханы бүрэн дүүрэн байдалд нэвтрэх*.....55

Хэсэг 2 *Христ Таны дотор байхын үр нөлөө. Бид нүглийн хүчнээс хэрхэн аврагдах вэ? Бид нүгэл үйлдсэнээр эргээд "Махан биеийн мөхөс хүн" болох уу?* 69

Бүлэг 4

ЕСҮСЭЭС ИРДЭГ ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛ

Хэсэг 1 *Би хэрхэн баяр хөөртэйгөөр дуулгавартай амьдрах вэ? Баяр хөөр гэж юу вэ?* 85

Хэсэг 2 *"Миний дотор буй Есүс"-ээр дамжуулан дуулгавартай байдал хэрхэн хэрэгждэг вэ? Бурхан хүнийг Өөртэйгөө хамтрах хамааралтайгаар бүтээжээ*.....101

Бүлэг 5

ЕСҮСЭЭС ИРДЭГ СЭТГЭЛ ТАТАМ ИТГЭЛ

Хэсэг 1 Итгэгчид нэгдмэл байдалд хэрхэн хүрэх вэ?
Ямар зүйл бидний итгэлийг бусдад болон гэр бүлд маань сонирхолтой болгодог вэ?.....115
Бидний доторх ямар өөрчлөлтүүд биднийг гэрч болгодог вэ?
Хэсэг 2 Сэргэлт шинэчлэлт хэрхэн үйлчлэлийг идэвхжүүлдэг вэ?.....125

Хавсралт

Цаашид судлах зүйлсийн зөвлөмж, Холбоо барих 139

ЕСҮСИЙН ХАМГИЙН НАНДИН БЭЛЭГ

Есүс Ариун Сүнсний талаар юу гэж сургадаг вэ?

Та Есүсийн хамгийн хүчирхэг сургаалтай танилцсан уу?
Ариун Сүнс ямар үүрэгтэй вэ?
Бидний зан чанар хэрхэн өөрчлөгдөж болох вэ?

Есүсийн онцгой уриалга: Ариун Сүнсийг гуй

Есүс Библийн нэг эшлэлд Ариун Сүнсийг гуй хэмээн бидэнд маш тодорхой тушаасан байдаг. Есүс ямар нэгэн зүйлийг ингэж чин сэтгэлээсээ уриалж, биднийг аваасай хэмээн хүсэж байсныг илэрхийлсэн Библийн өөр эшлэлийг би мэдэхгүй юм байна. Эдгээр эшлэлүүд нь Лук 11 дэх залбирлын тухай Түүний сургаалд байдаг. Үүнд Ариун Сүнсийг гуйх хэрэгтэйг арван удаа онцолсон байдаг:

*"Би та нарт хэлье. **Гуй,** тэгвэл та нарт өгөгдөнө. **Хай,** тэгвэл та нар олно. **Тогш,** тэгвэл та нарт нээгдэнэ. Учир нь **гуйдаг** хүн бүр авна, эрж **хайдаг** хүн олно, **тогшдог** хүнд нээгдэнэ. Эцгүүд та нарын нэгээс чинь хүү нь талх **гуйвал** оронд нь чулуу өгөхгүй. Загас **гуйвал** оронд нь могой өгөхгүй нь лавтай. Тийм биш гэж үү? Эсвэл хүү нь өндөг **гуйвал**, эцэг нь хилэнцэт хорхой өгөхгүй биз дээ? Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь **гуйдаг** хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв"* (Лук 11:9-13).

Эдгээр эшлэлд Есүс "Гуйх" гэсэн үгийг 6 удаа ашигласан ба дараа нь "Гуйх" гэсэн үгийг "Хайх" хэмээх үйл үгээр хоёр удаа онцолсон байна. Мөн дахин "Тогших" хэмээх үйл үгээр хоёр удаа онцолжээ. Үүнээс

үзэхэд Ариун Сүнсээр дүүрэн байхын тулд үйлдэл хийх хэрэгтэйг бидэнд тодорхой зааж өгөөгүй гэж үү? Сүүлчийн "Гуйх" хэмээх үг нь Грек хэлний үргэлжилсэн цагаар бичигдсэн байдаг. Энэ нь бид зөвхөн нэг удаа гуйх биш харин байнга гуйх ёстой гэсэн үг юм.

Энд Есүс биднийг зөвхөн яаралтай асуудал гарах үед Ариун Сүнсийг гуйх биш, харин үргэлж гуйж байхыг хүссэн байдаг. Тэрээр энэхүү чин сэтгэлийн уриалгаараа бидний дотор буй Ариун Сүнсийг эрэлхийлэх чин хүслийг маань сэрээхийг хүсч байна. Энэхүү яаралтай уриалга нь Ариун Сүнсийг байнга авахгүй л бол чухал зүйлийг алдах болно гэсэн Есүсийн итгэл үнэмшлийг илэрхийлдэг. Тийнхүү Ариун Сүнс бидэнд зайлшгүй хэрэгтэй гэсэн бодит үнэн рүү бидний анхаарлыг хандуулж байна. Иймл арга замаар Есүс биднийг Ариун Сүнсний бялхам ивээлүүдийг байнга авч байгаасай гэж хүсдэг.

Йоханнес Магер Ефес 5:18-н сүүлийн хэсгийг ийнхүү тайлбарлажээ: "Христэд итгэгч хүн нэг удаа дүүргээд байнга дүүрэн байдаг савтай адилгүй юм, харин байнга дүүргэгдэж байх ёстой сав юм. Тиймээс Ефес 5:18-р эшлэлийг ийм маягаар хэлж болох юм. "Өөрийгөө Ариун Сүнсээр үргэлж шинэчлэн дүүргэ." Бид баптисм хүртэхдээ Ариун Сүнсийг хүлээн авсан, тэрхүү бялхам бэлгийг хадгалахгүй байх аваас алдагдах боломжтой. Гэхдээ алдагдсан ч гэсэн Ариун Сүнсний оршихуйг дахин хүлээн авч болно. Сүнслэг дүүргэлт нь шинэчлэгдэж байх ёстой, тэгснээр Ариун Сүнс бидний амьдралын бүхий л хэсгийг эзэлж, тийнхүү сүнслэг амьдрал маань хатаж алга болохгүй юм.

Сүнсээр дүүрнэ гэдэг нь бид Түүнээс их хэмжээгээр авна гэсэн үг биш, харин Сүнс биднийг илүү ихээр авна гэсэн үг. Тиймээс элч Паул бүх итгэгчдэд [Еф. 5:18] Сүнсээр байнга дүүрэн байхыг тушаажээ. Нэг удаа баптисм хүртэнэ, харин олон удаа дүүргэгдэнэ—гэдэг нь Христэд итгэгчдийн хэвийн төлөв байдал юм."[1]

Есүсийн сургаалууд дотроос Ариун Сүнсийг залбиран гуйх тухай хэсэг нь их онцгой байдаг. Ариун Сүнс бол өөр бусад бүх бэлгийг дагуулан ирдэг Бурханы хамгийн агуу бэлэг билээ. Энэ бол Есүсийн шавь нартаа өгсөн хамгийн агуу бэлэг бөгөөд Түүний хайрын тод илрэл юм.

Ийм үнэ цэнэтэй бэлгийг хэн нэгэнд хүчээр өгөхгүй. Энэ бэлэг зөвхөн үнэ цэнийг нь ойлгон авахыг хүсч байгаа хүмүүст өгөгдөнө. Тийм ч учраас би Иохан 7:37-той холбогдуулан Ариун Сүнсийг өдөр бүр гуйхыг дадал хэвшил болгосон: "Хэрэв цангасан хүн байвал, Над уруу ирж, уугтун." Өөрөөр хэлбэл: Эзэн минь, миний зүрх сэтгэлд Ариун Сүнсийг хүсэх хүслийг өгөөч гэсэн үг юм.

1 Johannes Mager, Auf den Spuren des heiligen Geistes (Lüneburg, Germany, Advent-Verlag, 1999), S. 101.

Ариун Сүнсийг гуйж эхэлсэн зарим хүмүүсийн жишээнээс дурдъя

“Анхны хайр” сэргэсэн: А хэмээх нэгэн эмэгтэй надад ингэж бичсэн юм: “Манай найз бид хоёр 40 өдрийн номыг *“Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам”* номтой хослуулан гурав дахь удаагаа уншиж байна. Энэ материалыг олж судлахаас өмнө бидний итгэл бишрэл болон залбирлын амьдрал маань урьдынх шигээ халуун биш болсон байлаа. Бид ‘Анхны хайраа’ сэргээхийг хүссэн юм. Бид тийнхүү сэргээж чадсан бөгөөд Бурханд чин зүрхнээсээ талархаж байна. Бидний хайртай Бурхан залбиралд маань хариулж, Сүнсээрээ дамжуулан бидний дотор мөн бидний залбирч байгаа хүмүүсийн дээр хэрхэн ажлаа хийж байгааг харах үнэхээр гайхалтай байна.” М. С.

Есүс бидний амьдралд орж ирсэн: Өөр нэг хүн эдгээр номын талаар ийнхүү бичжээ. “... Эдгээр номууд нь миний амьдралд удаан хүлээгдсэн агуу их ивээл болж байна. Бусад сүмийн олон гишүүн болон манай сүмийн нэг эгчийн адил бидний итгэлийн амьдралд ямар нэг зүйл дутагдаж байв. Харин одоо бидний амьдралд Есүс орж ирж, биднийг өөрчилж эхэлсэнийг мэдрэх гайхалтай завшаан тохиогоод байна. Тэр бидний дотор ажиллаж байгаа бөгөөд алхам алхмаар Өөртөө ойртуулсаар байна. “ С.К.

Бүрэн дүүрэн амьдралын эх сурвалж бол Ариун Сүнс

Есүс яагаад энэ дэлхий дээр ирсэн юм бэ? Тэрээр хэлэхдээ: *Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм* (Иохан 10:10). Есүс бидэнд диваажингийн амьдралыг дэлхий дээр мэдрээсэй гэж хүсдэг бөгөөд Түүнийг дахин ирэхэд, мөнхийн улс буюу огт өөр хэмжээст орчинд энэ жаргалтай амьдралаараа үүрд мөнхөд амьдраасай гэж хүсдэг.

Тэрээр бас бидэнд бүрэн дүүрэн амьдралын эх сурвалж нь Ариун Сүнс гэдгийг харуулсан: *“Цангасан хүн байвал, Над уруу ирж, уугтун. Бичээст хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно” гэв. Есүст итгэгчдийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ.* (Иохан 7:37-39).

“Амийн усны гол” гэдэг нь бүрэн дүүрэн амьдралыг илэрхийлсэн гайхалтай жишээ биш гэж үү?

Есүс энэ дэлхий дээр амьдрах хугацаандаа бидэнд тохиромжтой жишээнүүдийг харуулсан уу?

Мариа Ариун Сүнсээр дамжуулан Есүсийг төрүүлсэн гэдгийг бид мэднэ (Мат. 1:18). Түүнчлэн баптисм хүртсэнийхээ дараа Түүнийг залбирахад, "Ариун Сүнс тагтаа мэт Түүн дээр бууж ирснийг" бид мэднэ (Лук 3:22). Түүний хувьд дээрх тохиолдлуудад Ариун Сүнсийг хүлээн авах нь тийм их шаардлагатай бөгөөд чухал байсан гэж үү? Элен Уайтын хэлснээр: "Өглөө бүр Есүс тэнгэрийн Эцэгтэйгээ харилцаж, түүнээс өдөр бүр Ариун Сүнсний шинэ баптисм хүртдэг байсан."[2]

Есүс үүгээрээ бидэнд үлгэр дуурайлал болсон юм. Бид өөрсдөөсөө асуух хэрэгтэй: Хэрэв Есүс өдөр бүр Ариун Сүнсээр сэргэх шаардлагатай байсан юм бол танд болон миний хувьд хичнээн чухал вэ?

Элч Паул Есүсийн санаа зовнилыг ойлгосон байв. Тэрээр Ефес дэх чуулганд бичсэн захидалдаа тэднийг Есүст итгэх үедээ Ариун Сүнсээр тамгалагдсан гэдгийг баталдаг (Ефес 1:13). Ефес 3:16,17 дээр Паул тэднийг Сүнсээр хүчирхэг байхыг уриалдаг, харин 4:30 дээр *"Ариун Сүнсийг битгий гомдоогоорой"* гэж хэлдэг. Тэрээр 5:18 дээр эрх мэдэл бүхий элчийн хувьд Ефесчүүд болон биднийг *"Сүнсээр дүүрэн байхыг"* хүсдэг, өөрөөр хэлбэл "Өөрийгөө үргэлжлүүлэн, Сүнсээр дахин дахин дүүрэн байлгаарай" хэмээн уриалдаг.[3] Сүнслэг амьдрал болон итгэл бишрэлийн өсөлтийн хувьд өдөр бүр Ариун Сүнсээр дүүрэн байх нь зайлшгүй шаардлагатай гэдгийг бид харж байна. "Бурхан бидэнд нэг удаа гуй, тэгээд та нар авах болно гэж хэлээгүй. Тэр бидэнд Ариун Сүнсийг цуцалтгүйгээр залбиран гуйхыг тушаасан. Цуцалтгүй гуйх нь гуйж байгаа хүндээ илүү идэвхтэй хандлагыг авчирдаг бөгөөд хүссэн зүйлээ авах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлдэг."[4] "Ариун Сүнсээр баптисм хүртэнэ гэдэг нь Ариун Сүнсний нөлөөнд бүрэн орж, Түүгээр бүрэн дүүргэгдэх гэсэн үг. Энэ нь нэг удаа болдог зүйл биш бөгөөд Ефес 5:18 дээрх Паулын хэлсэн "Дүүрсэн" хэмээх Грек үйл үг нь үргэлжлүүлэн давтах нөхцөлөөр бичигдсэн байдаг.[5]

---

2 Элен Уайт, *Цаг Үеийн Шинж Тэмдгүүд,* 1895 оны 11-р сарын 21.

3 Pub. Werner E. Lange, Unser größtes Bedürfnis (Lüneburg, 2011), S. 42

4 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* (Ревью & Хералд Хэвлэлийн хороо, 2003), х. 145.3

5 *Библи Судлалын Гарын Авлага,* 2014 оны 7-р сарын 17.

Есүсийн явахдаа хэлсэн үгс ба Ариун Сүнс

Есүс явахаасаа өмнө шавь нартаа Өөрийнх нь оронд Ариун Сүнс ирнэ хэмээн хэлснээр тэдэнд итгэл найдвар, баяр хөөрийг төрүүлдэг. Тэрээр Ариун Сүнсний үүргийг Иохан 16:7–14 дээр хэлж өгсөн байдаг.

"Харин Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт хэрэгтэй. Хэрэв Би явахгүй бол Туслагч та нар уруу ирэхгүй. Харин Би явбал Өөрөө Түүнийг та нар уруу илгээнэ. Тэр ирэхдээ нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаар ертөнцийг зэмлэнэ. Нүглийн хувьд, учир нь тэд Надад итгэдэггүй. Зөвт байдлын хувьд, учир нь Би Эцэгтээ очно. Та нар Намайг дахиж харахгүй. Шүүлтийн хувьд, учир нь энэ ертөнцийн захирагч шүүгдсэн юм. Та нарт хэлэх зүйл Надад олон бий ч та нар одоо тэдгээрийг даахгүй. Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана. Учир нь Тэр Өөрийн санаагаар биш харин алив сонссон юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Намайг алдаршуулна. Яагаад гэвэл Тэр Минийхийг авч, түүнийгээ та нарт мэдүүлнэ."

Илүү дээр шийдэл

Есүс дагалдагчдадаа *"Миний явах нь та нарт дээр юм"* гэсэн гэнэтийн үгийг хэлдэг. Есүс Ариун Сүнсээр дамжуулан бидэнтэй хамт байх энэхүү шинэ шийдэл нь Өөрийн биеэр хамт байхаас илүү дээр гэсэн үг юм. Есүс ийм арга замаар хаана ч байсан гэсэн хүн нэг бүрийн дэргэд байж, Өөрийгөө хязгаарлахгүй байж чадна.

Итгэлгүй, эргэлзээтэй байдлаас Есүст итгэх итгэл рүү хөтлөх

Дэлхийн хүмүүсийн нүдийг нээх нь Ариун Сүнсний даалгавар байсан юм. Тийм ч учраас дэлхийн сүмүүд оршин тогтнож байгаа биш гэж үү? Лаодикчуудын нүдийг нээж чадах Нэгэн бол зөвхөн Ариун Сүнс юм. Зөвхөн Тэрээр дэлхийн хүмүүст Бурханыг гэх хүслийг, бүлээн итгэгчдэд Есүстэй дотно харилцах хүслийг сэрээж өгдөг. Тэрээр бидэнд бүх нүглийн үндэс болсон нүглийг харуулдаг: *"Учир нь гэвэл тэд Надад итгэдэггүй."*

Та Есүст итгэдэг үү? Итгэлийн хамгийн гол зүйл нь Есүст найдах юм. Түүнд үнэхээр итгэж найддагийг харуулах нэг шинж тэмдэг бол бид өөрсдийгөө Түүнд бүрэн зориулах явдал юм. Энэ нь бүрэн зориулах, бүх зүйлд Түүнийг дагах хүслийн тухай асуудал юм.

Ариун Сүнс Есүсийг өргөмжилдөг. Бид Ариун Сүнсээр дүүрэх үед Есүс бидний хувьд илүү үнэ цэнэтэй, агуу Нэгэн болдог. Тэгээд Есүст маш их талархсан сэтгэл бидний дотор хөгжих болно.

Итгэлээр зөвтгөгдөн аврагдах

Ариун Сүнс нь Есүсийн зөвт байдлыг харуулахын тулд бидний нүдийг нээдэг. Есүсийг тэнгэрт өргөгдөн очиход, Эцэг Бурхан Түүний золиослолыг хүлээн авсан юм. Ийнхүү боломжгүй зүйл боломжтой болж, Бурхан хайр энэрлээ үзүүлэхийн сацуу шударга байдлыг хадгалж үлддэг. Ариун Сүнс энэхүү үнэлж баршгүй золиослолыг харуулахын тулд нүдийг маань нээхийг хүсдэг: Өөрсдийгөө Түүнд даатгасан хүмүүсийн бүх гэм нүглийг Есүс Өөртөө авч, харин Өөрийнхөө зөвт байдлыг тэдэнд өгдөг. Есүст итгэх итгэлээр зөвтгөгдөж аврагдана гэдэг бол Библийн гол сургаал юм.

Ариун Сүнс бидэнд Бурханы олон талыг харуулдаг

Ариун Сүнс бидний нүдийг нээж энэ ертөнцийн ханхүү аль хэдийн яллагдсан болохыг харуулж өгдөг. Сатан тэнгэрээс хөөгдсөн бөгөөд түүний төгсгөл удахгүй ирэх болно. Бид Христийн дотор байхад дайсан үндсэндээ бидэнд хор хөнөөл учруулж чадахгүй. Хэдийгээр бид дахин дахин уруу таталтанд орж, энэ дэлхий дээр сул дорой байж болох ч тэр биднийг яаж ч чадахгүй.

1 Иохан 5:18 дээр: *"Бурханаар төрсөн хэн боловч нүгэл үйлддэггүйг бид мэднэ. Харин Бурханаар төрсөн Тэрээр түүнийг хамгаалдаг бөгөөд муу нэгэн түүнд хүрэхгүй"* гэж хэлдэг. Есүс биднийг нүглээс аварч, Сатаны довтолгооноос хамгаалахыг хүсдэг.[6]

Харин Ариун Сүнс удахгүй болох шүүлтийн бодит байдлыг ойлгуулахын тулд хүмүүсийн нүдийг нээхийг хүсдэг. Есүс Христэд бүрэн бүүн өгч, Түүн дотор хоргодон авралын бэлгийг хүлээн аваагүй бол энэ шүүлтээс хэн ч зайлсхийж чадахгүй. Шүүлтийн талаар чичилж, айдсаар Өөртөө итгүүлэх нь Бурханы санаа зорилго биш юм. Гэхдээ шүүлтийн цаг ирж буйг мэдэх нь олон хүнийг гэмшихэд түлхэц болно. Ирж буй зүйлийн талаар хүмүүст мэдүүлж сонголт хийх боломж олгохгүй байваас энэ нь шударга бус хэрэг болно. Шүүлт бол бидний шийдвэрт туслах зүйл юм.

Ариун Сүнс бидэнд үнэний тухай ойлголтыг өгдөг

Ариун Сүнс биднийг бүх үнэн рүү хөтлөх болно. Тэр биднийг хуурамч ойлголтоос, алдаа дутагдлуудаас чөлөөлдөг. Тэрээр бас бидэнд өөрсдийн минь тухай үнэнийг харуулдаг ба ингэснээр бид Бурханы туслалцаатайгаар шаардлагатай алдаагаа засах боломжтой болдог.

6 Энэхүү чухал сэдэв нь Деннис Смитийн *40 Өдөр* номын 4-р бүлэгт хамааралтай: *Бурхантай харилцаагаа сэргээх залбирал болон мөргөл,* 2-р дэвтэр (Хагерстаун, MD: Ревью & Хералд Хэвлэлийн хэлтэс, 2011)

"Тайтгаруулагч нь "Үнэний Сүнс" юм гэсэн байдаг. Түүний ажил бол үнэнийг хамгаалж, хадгалах явдал юм. Тэр эхлээд зүрх сэтгэлд үнэний Сүнс болон ирж, тийнхүү бидний Тайтгаруулагч болдог. Үнэн дотор тайтгарал, амар тайван байдаг, харин худал дотор жинхэнэ тайтгарал, амар тайван гэж байхгүй."[7]

Ариун Сүнс бидний ирээдүйн талаарх ойлголтыг нээж өгдөг

Ариун Сүнс бидэнд ирээдүйн зүйлсийг мэдүүлэх үүрэгтэй байдаг. Есүс Өөрөө Матай 24-р бүлэгт ирээдүйн талаар тодорхой ярьсан хэдий ч, бидэнд ирээдүйн талаар илүү ихийг мэдүүлэх үүрэг Ариун Сүнсэнд өгөгдсөн юм. Хэрэв бид Түүнд боломж өгвөл Тэрээр бас бидэнд зөгнөлийг ойлгуулж өгч чадна.

Илчлэлт 2, 3-р бүлэгт бичигдсэн долоон захидал бүгд Есүсийн хэлсэн дараах өгүүлбэрээр төгсдөг нь гайхалтай биш гэж үү? "Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун" (Илч. 2:7). Есүс дэлхийн сүүлч үеийн сүм болох биднийг энэхүү уриалгаар дамжуулан Сүнсийг сонсоход чиглүүлдэг. Бид үүнийг хийхэд бэлэн байна уу?

Ариун Сүнсний хүч

Есүс тэнгэр өөд явахынхаа өмнө Ариун Сүнсний ажил үүргийн талаар өгүүлсэн байдаг: *"Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно"* (Үйлс 1:8). Ариун Сүнсний өөр нэг чухал үүрэг бол бидэнд хүч чадал болон ур чадварыг өгөх явдал юм, тийнхүү бид Бурханыг гэрчилж чадах юм.

"Христ бузар муугийн бугширсан байдлыг ялахын тулд, мөн Өөрийн сүм дээр зан чанараа суулгахын тулд тэнгэрлэг хүч болох Ариун Сүнсээ өгсөн."[8]

Ариун Сүнсний хүч нь бас эрүүл мэндэд зайлшгүй хэрэгтэй байдаг. Вэймар сургуулийн эрүүл мэндээр баярт мэдээ түгээх үйлчлэлийн сургалтын захирал Дон Макинтош ийнхүү хэлжээ: "Бидэнд хэрэгтэй зүйл бол эрүүл мэндийн талаарх мэдээлэл болон түүнийгээ бодит байдал дээр хэрэгжүүлэх хоёрын холбоос юм. Үүнд л өөрчлөх хүч оршино."[9] Энэ нь сайн мэдээний хүч буюу тодорхой хэлбэл Ариун Сүнсний хүчээр хийгддэг. Ариун Сүнс өөрчлөлтийг бий болгодог. Тиймээс бид өөрчлөгдөх арга

7 Элен Уайт, *Үе Үеийн Хүслэн,* (Pacific Press Хэвлэлийн хороо, 2002), х. 671.

8 Дээрх номтой адил.,

9 Dave Fiedler, D'Sozo: *Бузар Муугийн Эсрэг,* (Coldwater, MI: Remnant, 2000)

замыг зөвхөн өөрсдөө биеэ эрүүл саруул авч явснаар бусдад харуулж чадна. Гарцаагүй нэг зүйл бол Бурханы агуу их ивээл биднийг хүлээж байна.

Сэргэлт шинэчлэлтийн хүчин зүйлсийг хэрэгжүүлэх

Бид сүм чуулганаараа өмнө нь сэргэлт шинэчлэлтийн төлөө залбирч байсан биз. "Сэргэлтийн төлөө залбирах нь чухал боловч, сэргэлтийн хүчин зүйлсийг амьдралдаа хэрэгжүүлэх нь бас чухал юм"[10] гэж Марк Финли хэлсэн байдаг.

Сүмийн сэргэлт нь сүмд явж буй хүн нэг бүрийн сэргэлтээс хамаарна. Тиймээс би таныг сэргэлт шинэчлэлтийн алхам хийхэд уриалж байна. Энэ нь таныг илүү хүчирхэг, бүрэн дүүрэн амьдрал уруу, мөн итгэлийн баяр хөөртэй жинхэнэ амьдрал уруу хөтөлнө.

Яагаад шинэ зүрх хэрэгтэй вэ?

Есүс мунхаг таван охинд хандан *"Би та нарыг мэдэхгүй"* (Матай 25:12) гэж хэлсэн. Тиймээс тэд хуриманд оролцож чадаагүй. Тэд үнэн хэрэгтээ Бурханы хаанчлалд орж чадаагүй хүмүүсийг төлөөлдөг. Шалтгаан нь гэвэл тэдэнд тос дутагдсан буюу бидний хувьд Ариун Сүнсний дутагдал, сүнслэг амьдралын доголдол гэсэн үг. "Мунхаг таван эмэгтэй" нь **Ариун Сүнсний нөлөөллөөр чин сэтгэлийн өөрчлөлтийг мэдрээгүй хүмүүсийг илэрхийлдэг.**

Бид төрөлхийн нүгэлт мөн чанартай билээ. Тиймээс бид бүгдээрээ би гэсэн үзэлтэй бөгөөд энэхүү хувиа хичээсэн мөн чанараасаа болж зовдог. Би гэсэн үзэл маань байхгүй болсон цагаас л бид Бурханы хаанчлалд багтах болно. Ийм зан чанарын өөрчлөлт зайлшгүй шаардлагатай. Бурханы үгэнд биднийг Есүс дээр байгаагаараа ирж болно гэдгийг харуулдаг. Гэхдээ бидний хэн нь ч өмнөх шигээ хэвээрээ үлддэггүй гэдгийг бас мэднэ.

Мунхаг таван охин Бурханыг мэддэггүй болохыг анзаарна уу. Учир нь тэд өөрсдийн амьдралаа Есүст болон Ариун Сүнсний үр нөлөөнд бүрэн зориулаагүй юм. "Бидний аврал бидний юу мэддэгээс шалтгаалахгүй, харин хэнийг мэддэг вэ гэдгээс шалтгаална ... (Иохан 17:3). Бидний юу мэдэж байгаа нь чухал боловч, бид Есүстэй харилцах харилцаагаа хадгалахгүй байваас сорилтонд орж

10 Марк Финли, *Биднийг Дахин Шинэчлээч* (Nampa, ID: Pacific Press Хэвлэлийн хороо, 2010), х. 26.

эцэстээ алдагдах болно."[11] Тийм учраас Есүс бидэнд Ариун Сүнсийг тасралтгүйгээр гуйгаарай хэмээн захисан юм. Та өдөр бүр Бурханы өмнө бүрэн буун өгч, Ариун Сүнсний хүр бороог итгэлээр залбиран гуйдаг уу?

11 Деннис Смит, *40 Өдөр,* 2-р боть, х. 112.

Бурханы Сунсийг хучирхэгээр
хөдөлгөж чадах
нэг хуний цр нөлөөг
хэзээ ч бүү дутуу үнэлээрэй.

Бурхан таныг
энэ цаг үеийн төлөө
дуудсан ч юм бил үү.

(Естер 4:14-16-г уншаарай)

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Есүс Ариун Сүнсний талаар таны зүрх сэтгэлд ямар сэтгэгдэл буулгаж байна вэ?*

   _____

2. *Есүс Ариун Сүнсийг гуйх тал дээр бидэнд ямар үлгэр дуурайллыг харуулсан бэ?*

   _____

3. *Есүсийн дагалдагчдадаа болон бидэнд амласан Тайтгаруулагч Сүнсэнд өөр ямар үүргүүд байдаг вэ?*

   _____

4. *Ариун Сүнс бидний дотор ямар зүйлийг гүйцэлдүүлсэн бэ?*

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Бид залбирснаараа өдөр бүр бидэнд Ариун Сүнс хэрэгтэй гэдгийг мэдэрч, Түүнийг итгэлээр хүлээн авах болно - тэгээд дараах амлалтуудыг нэхэмжлэх хэрэгтэй:*
     - *биднийг итгэлгүй байдал болон сул дорой итгэлээс хол байлгах;*
     - *итгэлээр зөвтгөгдөх нь ямар утгатай болохыг илүү тодорхой ойлгуулах;*
     - *биднийг буруу ойлголт, алдаа дутагдал болон сорилтоос чөлөөлөх;*
  2. *Есүст болон Түүний үйлчлэлд болзолгүйгээр бууж өгөхийн төлөө залбираарай.*

Бидний зан чанар
хэрхэн өөрчлөгдөж болох вэ?

Есүс Хөрөнгөний Тухай Сургаалт Зүйрлэлээр Ариун Сүнсийг Онцолдог

Есүс хөрөнгөний тухай сургаалт зүйрлэлээр дамжуулан Ариун Сүнсний амьдралыг өөрчлөхүйц хүч нөлөөний талаар ярьдаг. Та сургаалт зүйрлэлийг анх уншихдаа Ариун Сүнсний талаар ярьж байна гэж бодох ч үгүй байх: *"Тэр дахин айлдруун Бурханы хаанчлалыг Би юутай зүйрлэх вэ? Энэ нь хөрөнгө мэт юм. Эмэгтэй түүнийг авч, гурван хэмжүүр гуриланд хийхэд энэ нь бүхэлдээ исдэг юм"* (Лук 13:20,21).

Хөрөнгө эсвэл исгэгчийг янз бүрийн талх хийхэд ашигладаг. Үүнийг гурилтай холиход исгэх үйл явц явагдаж, зуурсан гурилыг илүү зөөлөн, хөнгөн болгоно. Тийнхүү илүү тааламжтай амттай болдог. Есүс энэ зүйрлэлээр дамжуулан бидэнд Бурханы хаанчлалын зарчмуудыг тодорхой болгохыг хүссэн. Исгэгч нь бидний дотор болдог гайхалтай үйл явцыг илэрхийлдэг бөгөөд маш жижигхэнээс гайхалтай үр дүнд хүрдэг. Есүс Өөрийнхөө хувиа үл хичээсэн хайрыг бидний би гэсэн үзлийн оронд бий болгохыг хүсдэг.

Есүс бас энэ сургаалт зүйрлэлээр сайн мэдээний дэлхийд нөлөөлөх нөлөөллийг харуулахыг хүссэн юм. Хэдийгээр сайн мэдээ багаас эхэлсэн боловч, эцэстээ бүх ертөнцөд нөлөөлөх учиртай. Өөр нэг талаас нь харвал Бурханы амьдралыг өөрчлөгч хүч Ариун Сүнсээр дамжуулан бидний төлөө хэрхэн ажилладгийг Есүс харуулахыг хүссэн. Тэрээр Лук 17:20,21 дээр ийнхүү хэлжээ: *"Бурханы хаанчлал хэзээ ирэхийг асуусан фарисайчуудад Тэр хариулахдаа Бурханы хаанчлал ажиглагдахуйцаар ирэхгүй. Хэн ч "Хараач, тэнд байна" гэх юмуу, эсвэл "Энд байна" гэж хэлэхгүй. Учир нь Бурханы хаанчлал нь та нарын дунд байна гэв."*

Нэгдүгээр зууны үед Бурханы хаанчлал Есүсийн дүрээр хүмүүсийн дунд байсан. Харин өнөөдрийн хувьд бид Есүсийг Аврагч Эзэнээ болгон хүлээн авах үед Бурханы хаанчлал бидний амьдралд хэрэгжиж эхэлдэг. Хэрэв бид Түүний дотор байж, Тэр бидний дотор байсаар байвал,

бид Есүсийн хоёр дахь ирэлтээр харагдахуйц Бурханы хаанчлалд орох болно. Харин одоо бид Христийн дотор байж Бурханы хаанчлал хэрхэн ирэхийг харахыг хүсдэг. Есүс бидний дотор зөвхөн Ариун Сүнсээр л дамжуулан амьдарч чадна. Энэхүү сургаалт зүйрлэлээс авч болох чухал сургамжуудыг доор харууллаа.

Өөрчлөх хүч аажмаар явагддаг

"Исгэгч хөрөнгөөр тэнгэрийн хаанчлалыг илэрхийлсэн байдаг. Энэ нь Бурханы нигүүлслийн уусган нэвчих чанарыг бэлгэддэг."[1] "Өөрчлөлтийг зөвхөн Ариун Сүнс л хийх боломжтой."[2] Энэ бол биднийг бүрэн өөрчилж чадах буюу бүх зүйлд нөлөөлөх дотоод хүч юм. Тиймээс Бурхан Ариун Сүнсээр дамжуулан бидний зан чанарыг эерэгээр өөрчлөхийг хүсдэг.

Нэгдүгээр зуунд бууж ирсэн Ариун Сүнсний хур бороо нь заримдаа сонсогдохуйц, үзэгдэхүйц шинж тэмдгүүдийг агуулдаг байсан гэж Библид бичсэн байдаг. Харин Ариун Сүнсээр дүүргэгдсэн тохиолдолд бидний дотор зан чанарын өөрчлөлт чимээгүйхнээр явагдаж байдаг. Тийнхүү дараа нь бид гэнэт өөрчлөгдсөнөө олж мэддэг.

Гуриланд нуугдсан жаахан хөрөнгө бүх гурилыг хөөж хөвсийхөд хүргэдэг. Тэгэхээр үнэний хөрөнгө нь нууцаар хүнийг өөрчлөхөөр чимээгүйхэн ажиллаж байдаг ажээ. Хэрцгий догшин хандлага зөөлөрч, шинэ бодол, шинэ мэдрэмж, шинэ сэдлүүд суулгагдаж, зан чанарын шинэ жишиг тогтоно. Оюун бодол өөрчлөгдөж, чадварууд сэргэн шинэ зарчмаар ажилладаг. Тухайн хүнд шинэ чадварууд нэмэгдэж, мөн байгаа чадварууд нь ариусгагдсан байдаг. Ухамсар ч сэргэдэг. Тийнхүү Бурханд үйлчлэх боломжтой зан чанаруудыг бидэнд суулгаж өгдөг юм."[3]

Бурхан биднийг яагаад ийм чимээгүй байдлаар өөрчилдөг юм бэ? Байгаль дэлхий өвлөөс зун руу шилжин өөрчлөгдөхөд нам гүм цаг хугацаа зайлшгүй хэрэгтэй байдаг. Нарс мэтийн хүчирхэг том модод маш удаан ургадаг. Бид Ариун Сүнсийг үнэхээр хүсч байгаа эсэхийг мэдэхийн тулд Бурхан ийм байдлаар сорьдог юм болов уу? Тэрээр бидний итгэлийг шалгадаг бол уу? Би тийм гэж бодож байна. Түүнчлэн Тэрээр бидэнд үр жимстэй амьдрал өгөхийг хүсдэг (Иохан 15:1–8; Галат 5:22-г уншина уу).

Бидний зан чанарыг өөрчилж буй хүч нь бидний дотроос биш харин гаднаас ирдэг

Нэгдүгээрт, хүн өөрийгөө хүслийнхээ дагуу өөрчилж чадахгүй гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Хүн ийм өөрчлөлтийг бий болгох ямар ч хүчгүй.

1 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 96

2 Дээрх номтой адил, х. 96, 97.

3 Дээрх номтой адил, х. 98, 99.

Исгэгч хөрөнгө нь гаднаас орж ирдэг зүйл бөгөөд хүссэн өөрчлөлтийг бий болгохын тулд урьдаас тухайн хүнсэнд хийдэг."[4] Тиймээс зан авирыг өөрчлөхөд, бидэнд гаднаас ирэх хүч хэрэгтэй гэдгийг Есүс харуулжээ.

Иймч чухал асуудлын талаар хэлсэн Есүсийн үгийг бид анхаарч үзэхгүй гэж үү? *"Та нар Надгүйгээр юу ч хийж чадахгүй!"* (Иохан 15:5). "Христийн зөвт байдлыг олохын тулд бид өдөр бүр Сүнсний нөлөөгөөр өөрчлөгдөж, бурханлаг мөн чанарын нэг хэсэг болох хэрэгтэй. Зүрх сэтгэлийг ариусгаж, хүнийг бүрэн бүтэн болгодог нь Ариун Сүнсний ажил билээ."[5]

Есүсийн энэхүү чухал зөвлөгөө нь өнөө үед заадаг зүйлсээс тэс өөр юм. Шинжлэх ухаан, гүн ухаан эсвэл сурган хүмүүжүүлэх ухааны зарим чиглэлийнхний үзэж байгаагаар хүнийг өөрчлөх хүч нь бидний дотор байдаг. Ихэвчлэн "Өөрийгөө таньж мэдэх" талаар ярьдаг. Элч Паул өөрийнхөө талаар *"Миний дотор ... сайн зүйл байдаггүйг би мэднэ"* гэж хэлсэн нь бидэнд ч бас хамаатай билээ (Ром 7:18). Ийм байдалтай байгаа бид өөрийгөө танин мэдлээ гээд ямар үр дүнтэй байх бол? Бид энэ талаар 2 Тимот 3:1-с уншиж болно: *"Сүүлийн өдрүүдэд аймшигтай цаг үе ирэх болно."* Эгоизм буюу БИ хэмээх үзэл ноёлох болно. Бидний хувьд өөрийгөө таних гэхээсээ илүү Христийг танин мэдэх хэрэгтэй. Нэг хүн надад: "Би Христийн дотор өөрийгөө олж харсан" гэж билээ. Хамгийн гол нь Ариун Сүнс бидний дотор амьдарч, биднийг эрэгээр өөрчлөх явдал юм.

Бидэнд өөрсдийнхөө зан чанарыг өөрчлөх хүч байхгүй. Энэ нь гаднаас ирэх ёстой. Тийм ч учраас Есүс биднийг Лук 11:9–13 дээрх үргэлж Ариун Сүнсийг гуйж байх ёстой гэсэн уриалга уруу анхаарлыг маань хандуулдаг. Есүс энэ дэлхий дээр байх хугацаандаа өдөр бүр Ариун Сүнсээр дүүрч байсан. Тиймээс бидний хувьд энэ нь бүр ч илүү чухал юм. Бурхан бидэнд өдөр бүр Ариун Сүнсээр дамжуулан юу өгөхийг хүсдэг талаар бодох үед надад гайхамшигтай санагддаг. Бурхан биднийг өглөө бүр гэрлэсэн хос шиг тэврэхийг хүсдэг гэж би боддог.

Элен Уайт энэ сургаалт зүйрлэлийн талаар хэлэхдээ: "Дэлхий ертөнцийн өгч чадах бүх соёл, боловсрол нь нүгэлд доройтсон хүүхдүүдийг тэнгэрийн хүүхэд болгож чадахгүй. Сэргээн шинэчлэх хүч нь Бурханаас ирдэг. Өөрчлөлтийг зөвхөн Ариун Сүнсээр дамжуулан хийх боломжтой. Аврагдахыг хүсч байгаа хэн ч бай, өндөрт эсвэл нам дор байгаа, баян эсвэл ядуу хүмүүс энэ хүчинд захирагдах ёстой."[6]

---

4 Дээрх номтой адил, х. 96. 12.13

5 Элен Уайт, *Сонгомол Мэдээнүүд,* ном. 1 (Хагерстаун, MD: Review and Herald Хэвлэлийн холбоо, 2007), х. 374.

6 Элен Уайт, *Христ Гол Хичээлүүд,* х. 96, 97.

Дэлхийн II дайны үед Их Британийн ерөнхий сайд байсан Уинстон Черчиль хэлэхдээ: Бид хүмүүс гэх нэг зүйлээс бусад бүх зүйлийг хяналтандаа авсан: Хүмүүс зөвхөн хүний нөлөөллөөр өөрчлөгддөггүй. Хүнийг өөрчлөхөд энэ ертөнцөөс давсан хүч зайлшгүй шаардлагатай. Энэ хүч бол зөвхөн Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор үйлчилдэг Бурханы хүч юм.

Бидний доторх хүн өдрөөс өдөрт шинэчлэгдэж байдаг гэж Бурханы Үгэнд хэлсэн байдаг (2 Кор. 4:16). Өдөр бүр өглөө босоод хамгийн эхэнд итгэлээр Ариун Сүнсийг гуйх нь маш чухал юм.

Ариун Сүнс эхлээд бидний зүрх сэтгэл дотор ажлаа хийдэг, дараа нь гадагш нөлөөлдөг

Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэлд заадаг Есүсийн дараагийн чухал сургамж бол Ариун Сүнсний нөлөөнд ороход бид аливаа зүйлсийг дотроосоо гадагшаа арай өөрөөр хийж эхэлдэг. Хөрөнгө гурилтай холилдсоноороо дотроос нь гадагш ажилладаг шиг Бурханы нигүүлсэл бидний зүрх сэтгэлийг шинэчлэн амьдралыг өөрчлөхөөр ажилладаг. Тиймээс гадна талын өөрчлөлт биднийг Бурхантай эв нэгдэлтэй байлгахад хангалттай биш юм. Муу зуршлаа залруулах замаар өөрчлөгдөх гэж оролддог олон хүн байдаг бөгөөд тэд энэ аргаар Христэд итгэгчид болно гэж найддаг, гэвч тэдгээр хүмүүс буруу талаасаа эхэлж байна. Бидний хийх эхний ажил бол зүрх сэтгэл юм."

Цаашилбал: "Өнгөц итгэл үнэмшил болон үнэнийг зүрх сэтгэлдээ оруулах нь ялгаатай хоёр зүйл юм. Зүгээр л үнэнийг мэддэг байх нь хангалттай биш. Бидэнд мэдлэг байж болох ч, бидний бодол санаа өөрчлөгдөхгүй байж болно. Бидний зүрх сэтгэл өөрчлөгдөж, ариусгагдах ёстой.

Бурханы зарлигуудыг зөвхөн хийх ёстой үүрэг мэтээр дагахыг оролддог хүн дуулгавартай байдлын баяр баясгаланд хэзээ ч орохгүй. Тэр хүн дуулгавартай байгаа юм биш. Бурханы шаардлагууд нь хүний хүсэл тэмүүллийг дийлдэг учраас дарамт байдлаар хүлээн авбал энэ нь Христэд итгэгчийн амьдрал биш юм. Жинхэнэ дуулгавартай байдал нь дотоод зарчмын нөлөөлөл байдаг."[7]

Энэ сэргэлт гүнзгийрэх үед бидний бодох, ярих, хийх зүйлс маань Ариун Сүнснээс улбаалдаг. Харин бусад хүмүүс бидний хэрхэн амьдарч байгаа ялгааг л олж хардаг. Ральф Лютер: "Есүс итгэл үнэмшлийг шашинлаг хандлага хэмээн үзэхийг хатуу эсэргүүцсэн бөгөөд энэ хандлага нь бодит амьдралыг үндсээр нь өөрчилж чадахгүй"[8] хэмээн хэлжээ.

7 Дээрх номтой адил., х. 97.

8 Ralph Luther, Neutestamentliches Wörterbuch, S. 71, quoted in O. S. von Bibra, Der

Ye Yeийн Хүслэн номоос бид дараах зүйлийг олж уншдаг: "Ариун Сүнс бол сүнслэг амьдралын амьсгал юм. Сүнсний нөлөөлөл нь Христийн амьдралын илэрхийлэл байдаг. Энэ нь хүлээн авч буй хүнийг Христийн шинж чанаруудтай холбодог. Ийм маягаар зөвхөн Бурханаас суралцаж, зүрх сэтгэлд нь Ариун Сүнс ажлаа хийсэн, мөн амьдралд нь Христийн амьдрал илэрхийлэгддэг хүмүүс л сүмийн төлөө үйлчлэх төлөөлөгчид болдог."[9]

Дүгнээд хэлэхэд Есүс Ариун Сүнсний талаар дараах зүйлсийг заажээ.

- Амьдралыг өөрчлөхүйц Ариун Сүнсний хүч бидний дотор үл анзаарагдам байдлаар ажилладаг. Бид ихэвчлэн үр дүнг нь анзаардаг.
- Бидний амьдралыг өөрчлөх хүч нь өөрсдөөс биш гаднаас ирэх ёстой.
- Өөрчлөгч хүч нь эхлээд бидний зүрх сэтгэлд ажиллаж, дараа нь гадагш нөлөөлдөг.

Та хөрөнгөний тухай сургаалт зүйрлэлийн талаар *"Христийн Гол Хичээлүүд"* номоос олж уншихыг зөвлөж байна.

Есүсийн сүүлчийн үгс: Ариун Сүнсийг сонс

Дэлхийн төгсгөлийн үеийн сүмд хэлсэн Есүсийн сүүлчийн үгсийг та мэдэх үү? *"Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь сонсогтун"* (Илчлэлт 3:22). Есүс хүн нэг бүрийг Ариун Сүнсийг сонсоосой хэмээн дуудсан. Энэ л бидний хийх ёстой зүйл юм.

Намайг өөрчлөөч!

Есүс намайг үнэхээр өөрчилж чадах уу? Жишээ болгон нэгэн сайхан зургийг авч үзье. Зурагны үнэ цэнэ нь ашигласан материалын чанараас хамаардаггүй. Заримдаа чанар муутайхан будаг мэргэжилтний гарт орохоороо үнэ цэнэтэй уран зураг болж хувирдаг. Үүний нэгэн адил, бид нүгэлт мөн чанартай. Яг л "Чанар муутай" материал шиг. Хамгийн гол нь энэ "Материал" агуу зураачийн гарт ашиглагдаж байгаа нь л чухал юм. Есүс ийм зүйл хийхийг хүсдэг бөгөөд хийх ч чадвартай. Тэрээр таныг болон намайг аваад Бурханы хүндэтгэдэг нэгэн болгож чадна. Өдөр бүр өөрийгөө Түүний гарт даатгаж, итгэлээрээ Ариун Сүнсийг гуйгаарай. Тэрээр таны төлөө, таны дотор, бас танаар дамжуулан юу хийж чадахыг та хараад гайхах болно.

Name Jesus (Wuppertal, 1964), S. 98.

9 Элен Г. Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 805.

Нэгэн настай өвгөн Лондонгийн гүүрэн дээр суугаад хийл тоглож байв. Түүний малгайд хэдхэн зоос хийсэн байлаа. Нэг эр түүний хажуугаар өнгөрөн явж байснаа буцаж ирээд: Түр зуур хийлээ өгөөч хэмээн гуйв. Тэр эр маш сайхан тоглож эхэлсэн тул олон хүн сонсохоор ирлээ. Тэгээд бүр тэр хавийн замын хөдөлгөөнд түгжрэл үүсгэсэн байна. Түүний нэрийг Никольто Паганини гэдэг бөгөөд алдартай хийлч байжээ. Та амьдралдаа хийлээ өөрөө тоглох эсвэл амьдралаа агуу Багшийн гарт даатгах нь таны сонголт юм шүү.

Багш шавь хоёрын гэрчлэл

Жилийн өмнө *"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* номыг манай гэр сүмд тараах өгөхөд нь би тэр номыг хурдан гүйлгэж уншсан юм. Гэхдээ уншиж байх явцдаа Бурханыг урьд өмнө хэзээ ч мэдэрч байгаагүйгээрээ мэдэрсэн. Энэ нь намайг гайхшруулж, урам зориг өгсөн юм. Номын хавсралт дээр бичсэний дагуу 'Судалгаанаас үзэхэд чухал сэдвийг 6-10 удаа унших эсвэл сонсоход бүрэн ойлгогддог' гэсэн байв. Тэгээд ядаж нэг удаа туршаад үз, үр дүн нь гайхалтай байх болно гэсэн уриалгын үгс нь миний анхаарлыг ихэд татав.

Би энэ аргыг туршиж үзэхийг хүслээ. Тэгээд гурав дахь удаагаа уншиж байхдаа бүх амьдралынхаа туршид хүсч байсан Аврагчийн агуу их хайрыг мэдэрсэн юм. Би хоёр сарын хугацаанд уг номыг 6 удаа уншсан бөгөөд үр дүн нь үнэхээр үнэ цэнэтэй байлаа. Энэ нь яг л Есүс бидэнд ойртоход Түүний цэвэр ариун, эелдэг сайхан, хайраар дүүрэн нүд рүү харж байгаа мэт мэдрэмж төрүүлж байв. Тэр цагаас хойш би Аврагчаас мэдрэх энэ баяр хөөргүйгээр амьдрахыг хүсээгүй юм.

Би өглөө сэрэхдээ Бурхантай дахин нөхөрлөхийн тулд өглөөний мөргөлийн цагийг ихэд хүсэмжлэн босч ирдэг бөгөөд өдрийн турш Ариун Сүнс миний бодлууд, хүмүүстэй харилцах харилцаа болон багшлах явцад маань туслаасай хэмээн чимээгүйхэн залбирдаг.

Хүүхдүүд сахилгагүйтэн садаа болох үед Бурхан надад хэрхэн зохицуулах мэргэн ухаан болоод хүчийг өгдөг. Үүнээс хойш миний ажлын өдрүүд Бүтээгчийн оршихуйгаар дүүрэн байдаг болов. Тэрээр миний өдөр тутмын амьдралд маш их тусалдаг. Түүнээс хойш би өглөө болон бусад цагуудад Ариун Сүнсээр дүүрэн байхын төлөө залбирдаг. Энэ нь хүн диваажинд ойртох тусам тэнд ямар байхыг амталж чадахтай адил юм.

Энэ номыг уншаад сургуулийнхаа сурагчдад бас энэ туршлагаасаа хуваалцах хэрэгтэй гэсэн бодол төрлөө. Би Австри улсын Ворарлберг дэх Елиша Адвентист сургуульд 10-15 насны хүүхдүүдэд хичээл заадаг. Тэгээд надад боломж өгөөч хэмээн Бурханд залбирлаа. Тун удалгүй Ариун Сүнс залуу хүмүүсийн зүрх сэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг би мэдэрч эхэлсэн юм."

13 настай Руфиан болон Ариун Сүнс

Энэ зүйл Ариун Сүнсний талаарх номыг уншихаас нэг жилийн өмнө эхэлсэн. Манай сургуульд нэг шинэ сурагч шилжин ирсэн бөгөөд хэдхэн өдрийн дотор манай сургуулийн амар тайван орчин зодоон нүдээнтэй шуугисан орчин болж хувирав. Хүү 13 настай бөгөөд бусад хүүхдүүдээс том биетэй, биедээ таарсан хүч чадалтай байлаа. Нэг жилийн турш зааж сургасан, мөн үр дүнгээ өгч байсан зүйл хормын дотор алга болох шиг л санагдав.

Тэр хүүгээр өөрөөр нь яриулъя: "Энэ сургуульд шилжиж ирэхэд, намайг юу хүлээж байсныг би мэдээгүй. Хичээлийн хоёр дахь өдөр зүгээр баймааргүй санагдаж, ангийнхаа нэг хүүхдийг өдөж, түүнтэй зодолдсон. Тэрээр надаас сул дорой байсан ч би түүнийг цохиж, хэл амаар доромжлон дахин харахыг хүсээгүй юм. Дараа нь би хийж заншсанаараа алдаагаа ухаарч түүнээс уучлалт гуйлаа. Тэр явдлын дараа би сургуулийн захиралтайгаа ярилцсан юм. Дараагийн саруудад миний дотор өөрчлөлтүүд гарч эхлэв. Энэ үйл явц намайг пасторын хүү болох тэр үеэс биш харин одоо эхэлж байгаа нь гайхалтай. Тэгээд би Есүстэй цагийг илүү их өнгөрөөдөг болсон юм."

Энэ залуу хүүд онцгой халамж хэрэгтэй гэж би бодов. Тэрээр алдаагаа ойлгож үүндээ гэмшсэн ч дахиад л түүнийгээ хийдэг байлаа. Тэр өөрийн хүч чадлаар амжилтанд хүрэхгүй байв. Анхандаа түүнд зодоон хийхгүй байх нь хэцүү байсан ч аажмаар илүү дээр боллоо. Зургаан сарын дараа тэрээр Бурхантай ойртсон явдал нь залбирлын хариу байсан гэж бодож байгаагаа хэлсэн юм. Тэрээр өглөө бүр хүч чадал гуйн залбирч эхэлсэн байжээ. Тийнхүү түүний уур уцаар, зодоон нүдээн нь багассан байна.

Түүнийг манай сургуульд ирснээс хойш 11 сар өнгөрчээ. Бид түүний илүү их сайжирч байгааг одоо ч гэсэн харж байна. Гэхдээ түүний уур уцаар, хараал хэлэх, нударга зангидах нь бүрэн арилаагүй л байгаа. Тэр хүүхэд өөрийн хүч чадал, ойлголтоороо ялахыг хичээж байгаа нь ойлгомжтой. Түүний энэ арга зарим үед амжилттай байдаг ч, өөр бусад тохиолдолд хэрэгжих боломжгүй. Бидний залбирал түүнд тодорхой хэмжээнд нөлөөлсөн боловч түүний санаа бодол бүрэн зүгшрээгүй бөгөөд Ариун Сүнсний шинэчлэгч хүч дутмаг байна.

Хүн өөрийнхөө алдааг олж хараад аяш авираа хянахыг оролдсон хэдий ч бүтэлгүйтэх тэр мөчид ямар сайхан байх вэ дээ. Намайг яг тийм байдалтай, өөрөө юу ч хийж чадахгүй байх тэр мөчид энэ ном миний гарт ирсэн юм. Энэ ном яг л хэрэгтэй цагтаа над дээр ирсэн. Тэгээд би надад юу дутагдаад байгааг ойлгосон, тэр бол Ариун Сүнсний хүч. Бид Түүнээс тусламж үзүүлэхийг ч гуйж байгаагүй билээ!

"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам" хэмээх энэ ном надад ухаарал хайрласан учраас би зориг гарган тэр хүүгээс Ариун Сүнсийг гуйн залбирч байсан эсэхийг асуух санаа төрөв. Тэр хүү, Үгүй - хэзээ ч асууж байгаагүй гэж хариуллаа. Тэгэхээр нь би түүний анхаарлыг энэ ном уруу хандуулсан юм. Гэхдээ би түүнд номоо шууд өгөөгүй. Учир нь тэрээр энэ номыг маш их хүсэх хэрэгтэй гэж би бодов. Тэгээд тун удалгүй хүү надаас номыг асуусан юм.

Тэр хүүгийн өөрийнх нь хэлснээр: "2012 оны 11 сард багш надад *"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* гэдэг номыг өгөв. Би үүнийг идэвхтэй гэгч нь уншиж эхэлсэн. Тэр үед би Ариун Сүнс хэрхэн ажилладгийг тийм ч сайн мэддэггүй байсан юм."

Эхний өдөр тэрээр бараг хоёр бүлэг уншсан ба би хэдэн удаа унших хэрэгтэй вэ хэмээн надаас асуусан юм. Товхимолд 6-10 удаа унших хэрэгтэй гэснийг нь биелүүлэх хэрэгтэй гэхэд, тэрээр бүлгүүдийг дахин уншиж эхэлжээ.

Түүнээс хойш маш олон зүйлс өөрчлөгдөв. 2012 оны 12 сараас хойш ямар ч зодоон нүдээн болоогүй ба би ийм зүйл болсонд арай ядан итгэж байлаа. Өдөр бүр зодуулдаг байсан хөвгүүд түүний найзууд болж, тэд эв найрамдалтай болсон юм.

Тэрээр бүрэн өөрчлөгдөж, элдэг, тусч, амар тайван болж, түүний түрэмгий зан чанар ор мөргүй алга болсон байв. Ангийн сурагчид нь түүний дотор Бурхан ажилласан гэдгийг баталж чадна. Та бүхэн ийм үр жимсийг өдөр бүр харж болно. Бурханы алдрын төлөө тэр хүү 2013 оны 6 сард усан баталгаанд орохоор шийдвэр гаргасныг би дурдмаар байна. Хэрэв Ариун Сүнс байгаагүй бол ийм зүйл боломжгүй байсан. ...

Би өөрийгөө хүүхдүүдтэй ажиллаж, тэднийг учир ойлгодог болгож чадна хэмээн үргэлж боддог байлаа. Тэвчээр, анхаарал халамж болон маш их ярилцсаны үндсэн дээр амжилттай болно, харин энэ хүүгийн хувьд удаан үргэлжилсэнгүй. Бурхан Өөрийн Сүнсээр дамжуулан боломжгүйг боломжтой болгодог гэдгийг надад ойлгуулсан юм. Хэзээ нэгэн өдөр энэ хүү диваажинд байваас Бурхан түүнийг авч ирсэн гэдгийг би мэдэх болно. Намайг аргаа барж, энэ хүүг өөрчилж чадахгүй юм байна гэдгээ ухаарах үед Бурхан түүний төлөө ажиллаж эхэлсэн. Бурханы хувьд ямар ч найдваргүй зүйл гэж байдаггүй болохыг би хараад урам орсон билээ. - С.Р.

Залбирал: Тэнгэрийн Эцэг минь, Ариун Сүнсийг яаралтай гуй хэмээн Есүс биднийг уриалсанд талархаж байна. Ариун Сүнсийг үл ойшоож байсныг минь уучлаач. Надад Ариун Сүнсэнд өндөр ач холбогдол өгөхөд, өдөр тутмын амьдралыг минь шинэ түвшинд өргөж өгөөч. Намайг өдөр бүр Ариун Сүнсийг гүйдаг болгож өгөөч. Есүс өдөр бүр Ариун Сүнсийг гуйж байсан. Түүний үлгэр жишээг дагахад минь туслаач. Амен.

Та нарын яриа ургэлж
нигуулсэнгүй бүгөөд давсаар
амт оруулсан мэт байг.
Ингэснээр та нар хүн болгонд яаж
хариулах ёстойгоо мэдэх юм.
Колоссай 4:6

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэлээс бид Ариун Сүнсний үйлчлэлийн талаар ямар сургамжийг авч болох вэ?*
   а) Бидний зан чанарын өөрчлөлт хэрхэн явагддаг вэ?

   _____

   б) "Надгүйгээр та нар юу ч хийж чадахгүй" гэсэн Есүсийн үг нь бидний зан чанарын өөрчлөлтөд юу ойлгуулж өгч байна вэ?

   _____

   в) Бидний зан чанарын өөрчлөлтөнд Ариун Сүнс хэрхэн ажилладаг талаар бид юуг ойлгосон бэ?

   _____

2. *Есүс бол Зураач, бид бол Түүний уран зураг. Энэ санаанаас бид ямар сургамж авч болох вэ?*

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Бурханы нигүүлслээр бид тогтмол өсөлтийг мэдрэх болно.*
  2. *Бид хичнээн хүчтэй байхаас үл хамааран өөрчлөх хүч нь бидний дотроос биш гаднаас ирдэг гэдгийг бид үргэлжлүүлэн мэдсээр байх болно.*
  3. *Ариун Сүнсний өөрчлөгч хүч бидний амьдралд улам бүр тодорхой мэдрэгдэх болно.*
  4. *Бурханы өөрчлөгч хүч бусдад нөлөөлж байгааг бид ялгаж таньдаг болно.*
  5. *Бурхан биднийг тусламжийн гар болгон ашиглахыг хүсэхэд бид хүмүүст тусалж чадна.*

ЕСҮСТ БУУЖ ӨГӨХ НЬ

Би өөрийн хуслээ үгүйсгэх үү?
Эсвэл би илүү хүчтэй болох уу?
Есүст бууж өгөхөд минь надад юу саад болж байна вэ?
Бурханд бууж өгнө гэдэг нь
өөрсдийн хуслээсээ татгалзана гэсэн үг үү?

Бид итгэлээр аврагдсан хэмээх энэхүү урамтай мэдээг дахин дахин онцлоод ч баршгүй билээ. (Иохан 3:16; Үйлс 16:31, бусад). Библийн итгэлийн гол шинж чанар нь итгэж найдах юм. Есүст итгэж найддаг хэн боловч өөрсдийгөө Түүнд даатгах болно. Бид өөрсдийгөө Есүс Христээр дамжуулан Бурханд даатгасан учраас аврагдсан гэсэн үг. Есүст найдан бууж өгнө гэдэг нь жинхэнэ итгэлийн бодит илэрхийлэл юм.

Бүрэн бууж өгнө гэдэг нь аврал, дахин төрөлт, нүгэлт уруу таталтыг ялан дийлэх мөн Ариун Сүнсээр дүүрэн байхын гол түлхүүр юм.[1]

"Христийн үгийг хүлээн авч, зүрх сэтгэлээ Түүнд даатгаж, тушаалаар нь амьдарч байгаа хүмүүс амар тайван байх болно. Есүс Өөрийн оршихуйгаар тэднийг баярлуулахад дэлхийн юу ч тэднийг уйтгар гунигтай болгож чадахгүй. Төгс төгөлдөр байдалд төгс төгөлдөр амралт байдаг юм."[2] Ариун Сүнс бол Есүсийн шавь нартаа өгсөн гайхалтай бэлэг билээ. Бурхан үүнээс илүүг өгч чадахгүй. Ариун Сүнс бол бусад бүх бэлгийг авчирдаг бэлэг юм. "Гэхдээ бусад бүх амлалтын нэгэн адил үүнийг болзолтойгоор өгдөг. Эзэний амлалтыг нэхэмжлэн шаарддаг итгэгч хүмүүс олон байдаг. Тэд Христийн тухай, Ариун Сүнсний тухай ярьдаг ч ямар ч ашиг хүртдэггүй. Учир нь тэд бурханлаг хүчнүүдэд сэтгэлээсээ бүүн өгч, удирдуулдаггүй."[3]

1 Гарри Ф. Уильямс, *Ариун Сүнсээр дүүргэгдэх нь,* Герман хувилбар (Люнебург, 2007), х. 78.

2 Элен Г. Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 331.

3 Дээрх номтой адил., х. 672

Энэ бэлгийг хүлээн авахад болзол бий. Бид Христийн талаар, Ариун Сүнсний талаар олонтаа ярьдаг боловч ивээл хүртээгүй л байдаг. Яагаад?

Бид Есүсээр удирдуулан чиглэл баримжаа авахын тулд Түүнд бүрэн бууж өгдөггүй билээ. Ихэнхдээ олон хүн мэдэхгүй байдлаасаа болж Бурханд бууж өгдөггүй ба амьдралаа өөрсдийн гарт авсан байдаг. Энэ нь Ариун Сүнсний дутмаг байдлын шалтгаан байж болно. "Жижиг зүйлд итгэлтэй байх нь илүү том зүйлд хариуцлагатай байхын баталгаа болдог. ...

"... Хэрэв жижиг зүйлээ ч хийхгүй байвал, Бурханд бууж өгөх байдлаас ирдэг зан чанарын өөрчлөлт, хүч чадал, ивээл ерөөлийг авч чадахгүй."[4]

Миний бууж өгсөн түүх

Нэгэн пастор найз маань гэнэт нас барахад би гучин зургаан настай бизнесмэн залуу байлаа. Энэ үйл явдлаас болж толгойд минь хэрэв Бурхан намайг пастор бол хэмээн дуудвал би яах вэ? гэсэн асуулт төрсөн юм: Би пастор болохыг огт хүсэхгүй байлаа. Би бүтэн долоо хоногийн турш маш их тэмцэлдсэн. Би өглөө, өдөр, оройн цагаар байнга Бурхантай ярилцаж байв. Би залбирах бүртээ яагаад үйлчлэх хүсэлгүй байгаагаа тайлбарлаж, харин оронд нь юу хийж чадахаа хэлж байв. Тийнхүү долоо хоногийн дараа би, миний үгийг Бурхан сонсохгүй байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Цаашдаа Бурхантай маргах хүсэлгүй болсон би орныхоо дэргэд сөхрөн суух үед, "Бурхан чамд хайртай!" гэсэн намуухан бодол толгойд минь орж ирэв. Тэгээд би: Тийм ээ, би үүнд итгэж байна хэмээн бодлоо.

Хэдэн минутын дараа Бурханы хайранд итгэх итгэл маань намайг Эзэнд бүрэн бууж өгөхөд хүргэсэн юм. Үүний дараа би маш их тайвшралыг мэдэрч билээ. Энэ үйл явдлаас хойш Эзэн намайг нэг жил хагасын дараа пастор болгохоор дуудсан. Өнөөдөр би Түүнд маш их талархаж байна. Энэ бол миний бодож байснаас тэс өөр замыг харуулсан Түүний хязгааргүй хайр, мэргэн ухаан байсан юм. Эргээд харахад, тэр үед Бурханд бууж өгсөн явдал маань миний амьдралд асар их ивээл буулгасан гэдгийг би тодорхой олж хардаг. Бурхан намайг миний амьдралд байж болох хамгийн шилдэг замаар хөтөлсөн билээ.

Яагаад бууж өгөх гэж?

Бууж өгөх гэдэг үгийг *"Христэд Хүрэх Зам"* номонд тодорхой тайлбарласан байдаг. "Бурхан биднийг эдгээхийг, биднийг чөлөөлөхийг хүсдэг. Гэвч энэ нь бүрэн өөрчлөлт болон мөс чанараа өөрчлөхийг

4 Элен Уайт, *Эш Үзүүлэгчид ба Хаад,* х. 218,219

шаарддаг тул бид бүхэлдээ Түүнд бууж өгсөн байх ёстой. ... Тэрээр нигүүлслийнхээ улмаас бидний өмнө агуу их ивээл ерөөлийг тавьдаг.

Тэр биднээс өөрсдийгөө Түүнд өгөхийг уриалдаг ба ингэснээр Түүний хүсэл бидний дотор ажиллаж чадах юм. Энэ нь бидэнд нүглийн боолчлолоос ангижрах эсвэл Бурханы хөвгүүдийн алдар сууг хуваалцах сонголтыг бидэнд өгдөг."[5]

Бурханд бууж өгөх нь асар их ивээлийг авчирдаг. Тэр биднийг эдгээж, чөлөөлөхийг хүсдэг тул өөрсдийгөө Түүнд даатгахыг уриалдаг. Юунаас чөлөөлөхийг хүсдэг вэ?

Өөрийгөө Бурханд өгөхөөс татгалзсан хүн бүр өөр хүчний мэдэлд байдаг. Тухайн хүн өөрийгөө эзэмшдэггүй билээ. Тийм хүн эрх чөлөөний тухай ярьж болох ч, хахир боолчлолд байдаг. Түүнд үнэний гоо үзэсгэлэнг харахыг зөвшөөрдөггүй, учир нь түүний оюун ухаан Сатаны хяналтанд байдаг. Шийдвэрийг өөрөө гаргадаг хэмээн өөртөө бахдаж буй тухайн хүн үнэндээ харанхуйн хунтайжийн хүслийг дагадаг. Христ бидний сэтгэлээс нүглийн боолчлолыг зайлуулахаар ирсэн *"Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ"* (Ром 8:2).[6]

"Сүнслэг амьдралын хууль бол Ариун Сүнсний амьд хүч юм. ... Нүгэл зөвхөн үхэл ба бурууталыг бий болгодог, харин Сүнс амьдрал ба эрх чөлөөг авчирдаг."[7]

Есүст амьдралаа удирдуулахыг зөвшөөрөх үед, Тэрээр биднийг өөрсдийн маань (харгис хэрцгий, атаархал, гомдол, хэрүүл маргаан, шунал, донтолт, уур хилэн, бардам зан, сэтгэл гутрал, сэтгэл хангалуун бус гэх мэт) мөхөс зан чанаруудаас чөлөөлөх чадвартай. Тийнхүү хүн Христэд бууж өгөхөд өөрчлөлт эхэлдэг ба энэ нь эрх чөлөөний хамгийн дээд мэдрэмж юм."[8] Санаж яв: Хүн бүр өөрийнхөө хамгийн том асуудал нь байдаг. Та бол хамгийн том асуудал. Зөвхөн Бурхан биднийг жинхэнэ эрх чөлөөнд хөтлөх чадвартай.

Гэхдээ ваарчин хүн зөвхөн гартаа байгаа шавраар л ажиллаж чадна. Тиймээс бид Бурханд бууж өгдөг билээ. Бурхан ийм замаар биднийг нүглийн хүчнээс чөлөөлж, бурханлаг удирдамж, хамгаалалтыг өгөхийг хүсдэг.

---

5 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* (Нампа, ID: Pacific Press Хэвлэлийн газар, 1999), х. 43, 44.

6 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 466.

7 *Долоо дахь өдрийн Адвентист Библийн тайлбар,* 6-р бүлэг, х. 560. Ром. 8,2

8 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 466.

"Бурхан биднийг эдгээж, чөлөөлөхийг хүсдэг. Гэхдээ ингэхийн тулд биднээс бүхэлдээ өөрчлөгдөж, мөн чанараа шинэчлэхийг шаарддаг тул бид өөрсдийгөө Түүнд бүрэн зориулах ёстой."[9] "Бүх эрх мэдлээ Бурханд даатган өгөх нь амьдралын асуудлыг ихэд хялбаршуулдаг. Энэ нь зүрх сэтгэлийн мянга мянган хүсэл тачаалыг үгүй хийж, сулруулдаг."[10]

Бүрэн бууж өгөх талаар Библи юу гэж хэлдэг вэ?

Ром 6:13-т *"Биеийнхээ эрхтнүүдийг зөвт бус байдлын зэвсэг болгон нүгэлд бүү өргө. Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсод мэт, мөн биеийнхээ эрхтнүүдийг зөвт байдлын зэвсэг болгон Бурханд өргө"* хэмээн бичжээ. Энэ бичээсээс үзвэл, бууж өгөх гэдэг нь өөрийгөө Бурханд даатгаж, өөрийгөө Түүний эрхшээлд оруулах гэсэн үг юм.

Христэд итгэдэг зохиолч Ханна В. Смит энэхүү бичээсийг дараах байдлаар тайлбарлажээ: "Бууж өгөх гэдэг нь тухайн зүйлдээ ямар нэг зүйлийг өгөх буюу эзэмшил, захиргаанд нь орох гэсэн үг юм. Эзэнд өөрсдийгөө даатгана гэдэг нь үүнтэй адил зүйл. Тийнхүү Эзэн биднийг удирдах, эзэмших бүрэн эрхтэй болно. Энэ нь Өөрийгөө үгүйсгэж, бууж өгөх гэсэн үг юм."[11]

Ром 12:1-д *"Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн"* гэж хэлжээ. Энэ бичээс биднийг Бурханд бууж өгөх ямар шалтгаан өгч байна вэ? "Бурханы нигүүлсэл." Бууж өгнө гэдэг нь хайр, нигүүлслийн Бурханд барьж буй бидний хариу юм.

Бүрэн бууж өгөх гэдэг нь Бурханы гарт өөрийгөө бүрэн өгч, өөрсдийн амьдралаа түүнд золиос болгон өгөх гэсэн үг. Гэхдээ Хуучин Гэрээний шатаалт тахил шиг болно гэсэн үг биш, харин Түүний төлөө амьдарч байгаа амьд тахил байхыг хэлж байгаа юм. Амьдралаа эргэн харваас Бурханд бууж өгсөн явдал маань тухайн үедээ золиос мэт санагдаж байв. Харин одоо бол энэ нь золиос биш, харин дуусашгүй их ивээл байсан гэдгийг би ойлгосон юм.

Йоханнес Магер ийн хэлсэн байна: "Бууж өгөх, эрхээсээ татгалзах, зориулалт гаргах, Бурханы мэдэлд байх гэдэг нь чухал хэдий ч эдгээр нь үйл явц юм. Бууж өгөх нь сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй ямар ч холбоогүй. Энэ нь Бурханд өөрсдийгөө өгөх гэсэн үг юм."[12]

9 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 43.

10 Элен Уайт, *Миний Өнөөгийн Амьдрал* (Хагерстаун, MD: Review and Herald Хэвлэлийн хороо, 1999),

11 Ханна В. Смит, *"Өдөр бүр Христэд Итгэгч Байх нь"* (Аслар, 1994), х. 38.

12 Johannes Mager, Unser größtes Bedürfnis (Our Greatest Need) (Lüneburg, 2011), S.

2 Коринт 5:15-д *"Тэр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой"* гэжээ. Бууж өгнө гэдэг нь Есүсийн төлөө амьдрах гэсэн үг юм.

Есүсийн төлөө амьдарна гэдэг нь Түүнд бүтэн цагаар үйлчилнэ гэсэн үг биш, харин илүү чухал зүйл юм: *"Та нар үг ба үйлсээрээ юу ч хийсэн, Түүгээр дамжуулан Эцэг Бурханд талархал өргөн, бүгдийг Эзэн Есүсийн нэрээр хийгтүн"* (Колоссай 3:17).

Чарльз Т. Стад хэлэхдээ "Хэрэв Есүс Христ Бурхан хэрнээ миний төлөө амиа өгсөн юм бол Түүнд өгөх ямар ч том зүйл надад байхгүй."[13] Энэ хүн хэлсэн үгэндээ эзэн болжээ. Тэрээр Англиин шилдэг тамирчин байсан бөгөөд Христэд итгэгч болсноосоо хойш карьераа орхиж, сая сая долларын хандивыг миссионерийн нийгэмлэгт өгч, Хятадад миссионер болон очиж, дараа нь Энэтхэгт, эцэст нь Африкт очжээ. Түүний байгуулсан сайн мэдээний төв нь дэлхий даяар 1800 миссионертэй үйл ажиллагаагаа явуулсан хэвээр байна. Тэрээр Есүсийн төлөө амьдралаа өргөсөн юм.

Есүс Өөрийгөө бидний төлөө өргөсөн

Чухал нэг баримтыг анзаарахгүй өнгөрч болохгүй. Бууж өгөх нь нэг талын зүйл биш юм. Есүс эхлээд Өөрийгөө бидэнд өгсөн. Тэрээр бидэнд Бурханы өгч чадах бүх зүйлийг өгсөн бөгөөд биднээс өгч чадах бүх зүйлээ өгөхийг уриалдаг. Энэ бол бүх зүйлийн тухай асуудал. Гэхдээ Бурханы бүх зүйл болон бидний бүх зүйлийн хооронд ертөнцийн ялгаа бий. Тэгсэн ч гэсэн, хэн ч бүх зүйлээсээ илүү эсвэл багыг өгч болохгүй.

- Бүрэн бууж өгснөөр Есүс болон Эцэгтэй гайхалтай харилцаатай болдог. (Та Түүний дотор байх болно. Иохан 14:23; тийнхүү Есүс танд Өөрийгөө харуулах болно. Иохан 14:21).
- Бууж өгснөөр бид үнэний мэдлэгт хүрнэ. (Иохан 7:17 - Хэрэв хэн нэгэн нь Бурханы хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр ... мэдэх болно.)
- Бид бүрэн бууж өгснөөр залбирал дотор маш их хүчийг олж авдаг. (1 Иохан 3:22 - Бид юу ч асуусан түүнийгээ хүлээн авах болно.)
- Бууж өгөх нь төгс баяр хөөрийг олж авах зам юм. (Иохан 15:11 - Таны баяр хөөр дүүрэн байх болно.)
- Бууж өгөх нь элбэг хангалуун амьдралын түлхүүр юм. (Иохан 10:10; Ефес 3:19.)
- Бууж өгөх нь Бурхан миний амьдралаар дамжуулан ажиллах үндэс суурь болдог. (Иохан 7:38 – амийн усны голууд; Иохан 14:12 - агуу ажил; Иохан 15:4, 5 - их үр жимс.)

47, 48.

13 Norman B. Grubb, Charles Studd, Kein Opfer zu groß (No Sacrifice Is Too Great), "Introduction.

- Бурханд бууж өгсөн хүмүүст Сатан халдаж чадахгүй болдог. (1 Иохан 5:18 - хорон муу хүн түүнд хүрэхгүй. Иовын тухайд бол Бурханы тусгай зөвшөөрлөөр түүнд хүрсэн. Бүх зүйл бидний сайн сайхны төлөө ажилладаг бөгөөд бидний тэсвэрлэж чадахаас илүүг бидэнд хэзээ ч үүрүүлдэггүй.)

Бууж өгөх таван түвшин

Нэг зохиолч бууж өгөх таван түвшний талаар бичжээ:

- Мөнгө өгөх нь бүрэн бууж өгөхийн хамгийн доод түвшин юм.
- Дараагийн бууж өгөх түвшин нь цагаа зориулах юм.
- Дараагийнх нь хүч чадал, авьяас чадвараа ашиглах буюу үйлчлэх юм.
- Дараа нь бүхий л айдас болон итгэл найдваруудаа Бурханд өгөх буюу энэ нь дээрх бүх түвшнийг багтаана.
- Эцэст нь бүх оршихуйгаараа бууж өгөх буюу бүх хүсэл таллаа үгүйсгэж, Есүсийн төлөө амьдрах.[14] Энэхүү сүүлийн түвшин нь жинхэнэ бууж өгөх явдлыг тодорхойлдог.

Тэнгэрлэг Эцэгтээ өөрсдийгөө зориулах нь гайхамшиггай, учир нь бид түүний хайранд итгэдэг бөгөөд үрэлгэн хүүгийн сургаалт зүйрлэлд гардаг шиг хэтэрхий хол явахыг зөвшөөрөхгүй. Тэр хүү амьдралаа тартагтаа тулах хүртэл нь явж, эцэстээ бууж өгч, гэртээ харихаар шийдсэн юм. Эцгийнхээ гэрт ойртоход аав нь түүний өмнөөс ирж, тэврэн авдаг. Яг тэр мөчид хүү нь эцгийнхээ хайрыг маш тодорхой ойлгодог. Энэ үйл явдал түүнийг эцгийнхээ хайранд бууж өгөхөд хүргэсэн юм.

Эмгэнэлт үйл явдал

Дараах үйл явдал Францад болсон бөгөөд үүнийг жишээ болгон тайлбарлая: Баян Франц залуугийн эхнэр хэн нэгэнд нууцаа хэлжээ. Тэрээр гартаа жижигхэн шилтэй хор барьсан байв. Учир нь тэр эмэгтэй гэрлэлтийнхээ асуудлаас болж амиа хорлохоор төлөвлөсөн байлаа. Тэрээр хэлэхдээ, "Өчигдөр би нөхөртөө гомдоллосон юм, гэтэл тэр гайхсан байдлаар чи дахиад юу хүсээд байгаа юм бэ? Чамд миний банкны дэвтэр байгаа шүү дээ [түүний мөнгө эхнэрийнх нь мэдэлд байсан гэсэн үг], чи миний гэрээс хооллодог. Миний өмч хөрөнгө, эрх мэдэл бүгд чамд хамаардаг. Гэтэл чи гомдоллоод байгаа юм уу? гэхээр нь би түүнд "Надад чиний зүрх сэтгэл хэрэгтэй байна, чамайг намайг хайрлаасай

14 Дин М.Келли, *"Адвентизм Хэрхэн Хөгжихөө Болих вэ?"*, 1983 оны 2-р сарын үйлчлэл, х. 4.

гэж хүсч байна" гэлээ. Хариуд нь тэр: "Чи миний сэтгэлийг авч чадахгүй. Миний зүрх сэтгэл өөр эмэгтэйнх болсон гэдгийг чи мэднэ. Миний бүх зүйл чинийх, гэхдээ миний зүрх сэтгэл, миний хайрыг чи надаас шаардаж чадахгүй" гэж хэлжээ.[15]

Хэн нэгнийг хайрладаг хүн ийм хариулт сонсоод лав баярлахгүй. Нөхөр нь хэр их зүйл эзэмшдэг нь эмэгтэйн хувьд хамаагүй байлаа. Харин юу чухал байсан бэ гэхээр нөхөр нь чухал байсан юм.

"Бидний агуу Бурхан надаас ямар нэгэн юм хүсдэггүй. Харин Тэр намайг л хүсдэг. Есүс миний цаг зав, хөрөнгө мөнгө эсвэл авьяас чадварын тодорхой хэсгийг хүсдэггүй."[16] Харин Тэр намайг л хүсдэг. Учир нь Тэрээр надад хайртай бас намайг аз жаргалтай болгохыг хүсдэг.

Бид өөрсдийгөө зориулах ёстой, өөрсдийгөө байгаа бүхэнтэй нь өгөх ёстой. Бид өөрсдийгөө Бурханы халамж, удирдамж, чиглүүлэг болон хүсэлд даатган зориулах ёстой. Энэ бол Ром 12:1 дээр уриалсан бидний сүнслэг мөргөл юм.

Бурханд бүрэн бууж өгөх талаар Библид "Энэ бол таны ухаалаг мөргөл юм" гэсэн утгатай зүйл бичсэн байна. Тэгэхээр Бурханд бууж өгөх нь бидний хийж чадах хамгийн ухаалаг зүйл гэсэн үг юм. Өвдсөн үедээ бид өөрсдийгөө чадварлаг эмчийн гарт даатгахаас илүү ухаалаг зүйл гэж юу билээ? Төөрсөн үедээ өөрсдийгөө туршлагатай хөтөчид даатгахаас илүү ухаалаг зүйл гэж юу байх билээ?

Бүрэн бууж өгөх нь алдагдал биш, харин асар их хөрөнгө юм. Бурхантай өөрийгөө харьцуулбал би бол ядуу, тэнэг, арчаагүй нэгэн юм. Бурханы гарт өөрийгөө даатгах нь ухаалаг биш гэж үү? Намайг бүтээсэн, намайг өөрчилдөг, намайг хайрладаг, миний бүх хэрэгцээг хангадаг Нэгэнд би итгэх ёстой. Бид бууж өгснөөр Бурханы хязгааргүй хайр ба хүч бидний талд ордог. Энэ бол Бурханаар удирдуулсан амьдрал уруу орж байгаа хэрэг юм.

Бүрэн бууж өгөх нь Есүсийн бидэнд өгөхийг хүсч байгаа элбэг дэлбэг амьдралын эхлэл юм (Иохан 10:10). Түүнчлэн энэхүү буулт нь бузар мууг ялахад хүргэдэг. Илчлэлт 12:11-д ийнхүү хэлжээ: *"Тэд түүнийг [1] Хурганы цусаар, [2] тэдний гэрчлэлийн үгээр даван туулсан, [3] тэд өөрсдийгөө ч хайрлаагүй юм."* Нүгэл болон Сатаныг ялан дийлэхийн тулд бүрэн бууж өгөх шаардлагатай бөгөөд энэ нь бидний хийж чадах хамгийн сайн зүйл гэдгийг харуулж байна.

---

15 Освальд Смит, *Бурханы Ашигладаг Хүн,* (Нью Йорк: Христиан Альянс Хэвлэлийн компани, 1925), х. 26.

16 Йоханнес Магер, Unser größtes Bedürfnis (Бидний агуу хэрэгцээ) (Lüneburg, Werner E. Lange, 2011), S. 48.

"Христийн Гол Хичээлүүд" номоос бид дараах зүйлсийг уншиж болно: "Зан авирын алдаа дутагдлаа арилгаж чадахгүй гэж хэн ч битгий хэлээсэй. Хэрэв та ийм шийдвэрт хүрвэл мөнхийн амийг олж авахдаа бүтэлгүйтэх нь тодорхой. Боломжгүй гэдэг зүйл таны хүслийг хуурна. Та хүсэхгүй бол тийнхүү ялж чадахгүй. Жинхэнэ асуудал нь зүрх сэтгэлийн ариусаагүй байдал болон Бурханд захирагдахыг хүсэхгүй байхаас үүддэг."[17] "Алдагдсан хүн төрөлхтнийг аврахын тулд Өөрийгөө хоосолсон Есүст Ариун Сүнс хэмжээлшгүйгээр өгөгдсөн юм. Тиймээс бүх зүрхээрээ Түүний оршихуйд бууж өгснөөр Христийн дагалдагч болгонд Ариун Сүнс өгөгдөнө."[18]

- Ариун Сүнс Есүсийн дотор хэмжээлшгүй их байсан.
- Ариун Сүнс бидний дотор яг тэр хэмжээгээр амьдарч чаддаг байхын тулд биднийг Бурханд бүрэн бууж өгөөсэй гэж хүсдэг.
- Ийм учраас Есүс: «Сүнсээр дүүрэн бай» хэмээх тушаалыг өгсөн. Энэ тушаал Грек эх хэл дээрээ: "Ариун Сүнсээр үргэлжлүүлэн, дахин дахин дүүрэн байлга" гэсэн утгаар бичигджээ.
- Түүний зорилго бол биднийг илүү элбэг хангалуун байлгах юм (Иохан 10:10; Колоссай 2:10).

17 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 331.

18 Элен Уайт, *Ерөөлийн Уулан Дээрх Сургаал* (Нампа, ID: Pacific Press Хэвлэлийн хороо, 1999), х. 20.

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Ариун Сүнсийг хүлээн авахад ямар бурханлаг нөхцөл байдаг вэ?*

   _____

2. *Бурханд бүрэн бууж өгнө гэдэг нь юу гэсэн үг вэ? Мөн ямар үр нөлөөтэй байдаг вэ?*

   _____

3. *Бүрэн бууж өгөх нь гол түлхүүр үү? Энэ зүйлийг хийснээр ямар ивээлүүд ирдэг вэ?*

   _____

4. *Бууж өгөхөд ямар таван түвшин байдаг вэ? Эндээс зөвхөн нэг түвшин нь жинхэнэ бууж өгөх явдал билээ. Аль нь вэ? Өөрийнхөө хэрхэн бууж өгдөг талаар бодоорой.*

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Итгэлээр аврагдах гэдэг нь юу гэсэн үг болохыг илүү сайн ойлгохын тулд залбираарай.*
  2. *Бурханд бууж өгснөөр танд ирсэн ивээлүүдийн төлөө Бурханд талархаарай.*
  3. *Ариун Сүнс таны амьдралын замналыг, мөн бүхий л шийдвэрүүдийг тань удирдахын төлөө залбираарай.*

Бидний буруу өгөхөд юу саад болдог вэ? Бурханд буруу өгнө гэдэг нь бид өөрсдийн хуслээс татгалзана гэсэн үг үү?

Миний хувьд Бурханд буруу өгөхөд саад болсон зүйл бол ажлын талаарх асуудал байв. Үнэнийг хэлэхэд, хэрэв би буруу өгвөл Бурхан намайг пастор бол хэмээн дуудна гэдэгт санаа зовж байсан юм.

Едвин Орр залуу байхдаа янз бүрийн саад бэрхшээлтэй тулгарч явсан нэгэн юм. Тэрээр хэлэхдээ:

Би Эзэнд бүрэн буруу өгөх ёстой байв. Амьдралдаа би анх удаа Бурхан надтай ярьж байгааг мэдэрсэн юм. Ариун Сүнс миний зүрх рүү ярьж байв. Тэгээд би Эзэнд бүхлээрээ буруу өгөхөд бэлэн байна гэдгээ хэлсэн. Зүрх сэтгэлд минь нэгэн дуу хоолой ... чиний хийх дуртай гэм нүглүүд яах болж байна? хэмээн асуув. Би тэдгээр гэмдээ гэмшиж, дахин давтахгүй гэдгээ амлалаа. Дотоод дуу хоолой минь дахин надаас харин чиний хүслүүд яах вэ? хэмээн үргэлжлүүлэн асуув. Энэ хэсэг намайг ихэд гайхшруулав. Би Эзэнд: Та намайг хаашаа ч хамаагүй оч гэвэл, эсвэл гэртээ үлд гэвэл би алийг нь ч хийхэд бэлэн байна гэлээ. ... Дараа нь Бурханы Сүнс миний амьдралдаа хайрлаж байсан нэгэн шүтээний тухай надад хэллээ. Энэ нь миний ихэд хайрладаг байсан охины талаар байв. Эзэн надаас энэ охиноос татгалзаж чадах уу гэж асуулаа. Гэнэт миний дотор үүнийг хийж чадахгүй гэсэн бодол орж ирэв. Би ийм золиос хийхийг хүссэнгүй. Энэ үед Ариун Сүнс надтай ярихаа болив. Гэнэт зүрх минь түгшин, хоосон мэт боллоо. Би үүний тухай удалгүй ойлгож, дараа нь Сүнсээр дүүрэхийг хүсч буйгаа мэдэв. Энэ удаад би өөрийгөө Эзэнд бүрэн даатгасан юм. Би амьдралынхаа энэ хэсгийг (эмэгтэйг) хүртэл түүнд даатгахад бэлэн боллоо. ... Миний зүрх сэтгэл төсөөлшгүй хайр, баяр баясгалан хүч чадлаар дүүрэн болов. Амьдралдаа анх удаа би Бурханыг, Аврагчийг, мөн Христийн шашныг зүгээр нэг сургаал эсвэл гүн ухаанаас илүү гэдгийг мэдэрсэн юм.[1]

1 J. Edwin Orr, Volle Hingabe (Full Surrender) (Kassel, 1965), S. 108ff., богиносгов.

Бурхан Едвин Оррын амьдралаар дамжуулан агуу зүйл хийсэн.

Миний хувьд ажлын талбар маань саад бэрхшээл байсан бол, Едвин Оррын хувьд хайртай охин нь байсан юм. Харин таны хувьд ямар саад байх нь хамаагүй, Эзэнд бүрэн бууж өгч амжаагүй байгаа бол өөрийгөө болон асуудлаа Түүний гарт өгөөрэй. Эзэн таныг агуу ихээр ивээх болно.

Бурхан бидний шийдвэрийг хүндэтгэдэг

Хэрэв та бүх зүйлсийг мэддэг байсан бол Бурханы удирдан дагуулахыг хүсч байгаа тэр л замаар явахыг сонгох байсан. Хязгааргүй хайрын Бурханд бид бүхлээрээ бууж өгөхөд өөрсдийн айдас, шалтаг бүхнээсээ салж чадна.

Бурхан хэзээ ч хүний чөлөөт хүслийн эсрэг үйлдэл хийхгүй. Бидний гайхалтай Бурхан бидний хувь хүнийг хүндэтгэдэг. Эрх чөлөө бол Бурханы өгсөн гайхалтай бэлэг юм. Тиймээс Бурхан бидний зөвшөөрлийг хүлээж, зөвхөн биднийг гуйсан үед үйлддэг. Эрх чөлөө бол бурханлаг өгөгдөл юм. Хайр зөвхөн эрх чөлөөний дор хөгжиж чадна.

Бурханд бууж өгнө гэдэг нь өөрийн хүслээс татгалзана гэсэн үг үү?

Бурханд бууж өгөхдөө бид өөрсдийн бүх хүсэл зоригоосоо татгалздаг уу? Бид хүүхэлдэй мэт болж, Бурханд удирдуулдаг уу? ҮГҮЙ ЭЭ!

Яагаад үгүй гэж? Учир нь бид өөрсдийгөө Бурханд бүрэн дүүрэн эзэмшүүлснээр Бурханы төгс, сүр жавхлант, ухаалаг хүсэл зоригоор өөрийн мунхаг, төөрөлдсөн, үл хайхарсан, төлөвшөөгүй хүслээ орлуулдаг. Бид өөрсдийгөө тэнгэрлэг удирдамжин дор оруулж байна гэсэн үг.

Бид хүсэл зоригоосоо татгалзах хэрэггүй, харин буруугаар ашиглахгүй байх хэрэгтэй. Татгалзах ёстой хүсэл гэдэг нь Бурханы хүсэлтэй зөрчилдөж байгаа тэр хүсэл юм. Энэ нь биднийг зөрүүд зангаа засан залруулахад дадлагажуулж байдаг.

Элен Уайт: "Хэн нэгэн би өөрийнхөө замаар явж, өөрийнхөөрөө үйлдэж болохгүй гэж үү? хэмээн асууж болно - гэхдээ үгүй ээ, та өөрийн замаар явбал Тэнгэрийн хаанчлалд орж чадахгүй. Тэнд "Миний зам" гэж байхгүй. Тэнгэрийн хаанчлалд хүний арга замд зориулсан зай байхгүй. Бидний зам Бурханы замд уусах ёстой"[2] хэмээн хэлжээ. (Исаиа 53:6-г үзнэ үү.)

Бурхан ба Түүний үгийн чиглүүлгээс татгалзсан хүн "Бурханлаг чиглүүлэг"-ийг дагалгүй харин өөрийн хязгаарлагдмал оюун ухаанд түшиглэн амьдарч байдаг. "Бидний хүсэл Бурханы хүсэлтэй нийцсэн

2 Элен Уайт, Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо, 1892 оны 2-р сарын 23.

тохиолдолд өөрчлөх хэрэггүй бөгөөд харин ч өөрчлөх юм бол бурууд ах болно."[3]

"Хүний хүсэл сонирхол Бурханы хүсэлтэй хамтарваас маш хүчтэй болно. Тэгэхээр аливаа зүйл Бурханы тушаалаар хийгдэж байгаа бол Түүний хүчээр хийгдэнэ гэсэн үг. Түүний бүх уриалга боломж олгодог."[4]

"Ариун Сүнсээр удирдуулахыг зөвшөөрвөл бид хязгаарлагдмал болохгүй. Харин ч бид хамгийн их эрх чөлөөтэй амьдарна. 2 Коринт 3:17 дээр: *"... Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байна"* хэмээн бичжээ.[5]

Бууж өгөхөд ирдэг бусад ивээлүүд

Бурханд өөрийгөө бүрэн зориулдаг хүн бурханлаг мутраар удирдуулна. Тухайн хүн дорой, авьяас билэг муутай байсан ч гэсэн, хэрэв Бурханы хүслийг итгэмжтэйгээр, чин зүрхнээсээ итгэн дагавал түүний хүч ариусгагдаж, урам зоригоор дүүрч, чадварууд нь нэмэгдэх болно. Тэрээр бурханлаг мэргэн ухааныг эрхэмлэн дээдлэхийн хэрээр ариун үүрэг даалгавар түүнд даалгагдах бөгөөд өөрийнхөө амьдралыг Бурханд хүндэтгэлтэй, бусдад ивээлтэй болгох боломжтой. *"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг. Тэдгээр нь энгийн хүмүүст ухаарлыг хайрладаг"* (Дуулал 119:130).

Ефес хотын итгэгчдийн адил Ариун Сүнсний ажлыг сэтгэлдээ үл тоомсорлодог хүмүүс өнөөдөр олон байна. Гэтэл Библид үнэний талаар маш тодорхой тайлбарласан байдаг."[6]

Бурханлаг чиглүүлэг доорх амьдрал

Сургаалт үгс 3:5,6 дээр *"Бүх зүрх сэтгэлээрээ Эзэнд итгэ, мөн өөрийн ухаанд бүү найд. Бүх замаараа Түүнийг дага, тэгвэл тэр чиний замыг шулуун болгоно"* гэж хэлсэн нь дараах үзэл бодолтой зөрчилдөх үү?

Олон хүн энд хэлсэн зүйлийг оюун ухаанаа ажиллуулахгүй байх хэмээн ойлгодог. Гэтэл тийм биш ээ. Бурхан биднийг сэтгэхүйгээ ашиглаасай гэж хүсдэг. Бурхан биднийг сэтгэхүйгээ Түүний хязгааргүй сэтгэхүйтэй холбохыг хүсэн уриалдаг.

---

3 H. W. Smith, Christsein tgglich (Өдөр бүр Христэд итгэгч байх нь), S. 73.

4 Элен Уайт, *Христэд Итгэгчдийн Үйлчлэл,* ((Hagerstown, MD: Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо, 1999), х. 258.

5 Дэвид Волквитц, *Сэргэлт Шинэчлэлтийн Зам,* (NRW холбоо), 25-р хэсэг.

6 Элен Уайт, *Элч Нарын Үйлс,* (Nampa, ID: Pacific Press Publishing Хэвлэлийн холбоо, 2002), х. 283, 284-р зүйл.

Бурхан жижиг болон том зүйлд итгэмжтэй байсан Даниел болон түүний найзуудад арав дахин илүү мэргэн ухаан өгөөгүй гэж үү? Бурхан биднийг оюун ухаанаа хамгийн дээдээрээ ажиллуулж мөн үүнийгээ Бурханы хязгааргүй оюун ухаантай холбоосой гэж хүсдэг.

Энэ нь яг л GPS-тэй машин унаж байгаатай адилхан юм. Би жолоо барихдаа бүх сэтгэхүйгээ ашиглах шаардлагатай болдог, гэхдээ зорьсон зорилгодоо хүрэхийн тулд хэр хугацаа хэрэгтэйг, аль зам нь хамгийн тохиромжтойг, хаана түгжрэл саад байгааг, хэр хурдлахыг болон хаашаа эргэхээ мэдэхэд надад GPS хэрэгтэй. Би нэгэн оршуулгад оролцохын тулд мэдэхгүй газраар явах учраас хүнээс зам заагч төхөөрөмж зээлж байснаа сайн санаж байна. Тэр GPS сайн ажилласан бөгөөд би ямар ч асуудалгүйгээр зорьсон газраа хүрч чадсан юм.

Тиймээс Бурханд, Түүний заавart, Түүний зарчим, зөвлөгөөнд итгэн найдаж, бурханлаг чиглүүлгийн дор зам мөрөө авч яваарай.

Багаж хэрэгсэлдээ эргэлзсэн нь

Дэлхийн II дайны үед Британийн онгоц Сицилээс хөөрч Хойд Африк руу нисэв. Бүх нисэх буудлын цахилгаан салж холбоо тасарсан тул нисгэгчид өөрсдийн багаж хэрэгсэлд бүрэн найдах ёстой болсон юм. Тэднийг хүрэх цагаа тооцоолж амжаагүй байхад, багаж нь зорьсон газраа хүрсэн хэмээн зааж байв.

Нисгэгчид ийм байх боломжгүй гэж үзээд ниссээр байжээ. Тийнхүү тэд Сахарын цөлд ойртон ирэх хүртэл өөрсдийн алдааг ойлгосонгүй. Тэгээд онгоцны шатахуун дуусч, цөлд яаралтай газардах шаардлагатай болжээ. Онгоцонд хангалттай ус байгаагүй учраас бүх багийнхан эцэстээ цангаж үхсэн байна. Хожим нь аврагчид онгоцыг илрүүлэн судлахад бүх багаж хэрэгсэл хэвийн ажиллаж байсныг олж тогтоожээ. Агаарын урсгал хүчтэй байсан тул онгоц ердийнхөөсөө илүү хурдан хүрэх газраа хүрсэн байв. Ийнхүү нисгэгчид өөрсдийн багцаанд багаж хэрэгслээсээ илүү итгэсэн нь тэднийг сүйрэлд хүргэжээ. Тэд өөрсдөө шийдвэрээ гаргасан бөгөөд энэ нь буруу шийдвэр байв.[7] Харин бид Бурханы удирдлагад найдаж болно. Бурханы үгэнд найдах нь бидний ойлголтоос илүү дээр юм.

Ноён нуруутай хүмүүс

Бид Есүс Христэд бууж өгснөөр сул дорой, хүсэл зориггүй болох юм биш; харин ч өөрсдийн байр сууриа илүү ухаалаг бөгөөд эелдэгээр хамгаалж чаддаг ноён нуруутай хүмүүс болох болно.

---

7 Aller Diener (Bern, Euro-Africa Division, 1983) II/III, S. 142

Даниел болон түүний найзуудын талаар дахин бодоод үзээрэй. Даниел 1-р бүлэгт гардаг хоол ундны сорилт дээр тэд залуу хүмүүс атлаа ноён нуруутай байж, Бурханд үнэнч гэдгээ нотолсон байдаг. Эсвэл 3-р бүлэгт тэдний дунд эргэм настай байхдаа галт зуухны өмнө хийсэн гайхалтай шийдвэрийнх нь тухай бодоорой. Мөн 6-р бүлэгт гарч буй арслангийн нүхний өмнө байсан ахимаг насны Даниелын хандлагын талаар тунгаан бодоорой.

Өөрийгөө үнэлэх эсвэл Христээр дамжуулан өөрийгөө үнэлэх

Өөрийгөө Христэд даатгасан хэн боловч өөрийгөө үнэлэх тал дээр санаа зовох хэрэггүй болно. Учир нь тэд Христээр дамжуулан илүү үнэ цэнэтэй билээ.

Анагаахуйн Үйлчлэл номонд: "Илүү гайхалтай ажил хийх чадвар заяасан хүмүүс ихэнхдээ багахан зүйл хийдэг, учир нь тэд багаханыг хийх гэж л оролддог. Мянга мянган хүн өндөр жишиг, том зорилгогүйгээр амьдралаа дуусгаж байна. Үүний нэг шалтгаан нь өөрсдийгөө доогуур үнэлсэнд байдаг. Христ бидний төлөө хязгааргүй үнэ төлсөн бөгөөд энэ үнийн дагуу Тэр биднийг өөрсдийгөө үнэлээсэй гэж хүсдэг."[8] Нэг эмэгтэй Ариун Сүнсэн дотор амьдарч эхэлснээсээ хойш "Өөрийгөө үнэлэх үнэлэмжээ Христээс олсон" хэмээн надад хэлж билээ.

Бурханд бууж өгөх асуудлаар зөвлөгөө өгсөн нь

Нэгэн залуу Ариун Сүнсээр дүүрэхийг хүсч, ихэд тэмцэлдэж байсан тул пастораас зөвлөгөө авчээ. Пастор түүнээс "Чи өөрийн хүслээ Бурханд бүрэн даатгасан уу?" гэж асуув.

"Бүрэн биш гэж би айж байна" хэмээн хариуллаа.

Пастор хариуд нь "За тэгэхээр, чи өөрийн хүслээ Бурханд бүрэн өгөхөөс нааш Ариун Сүнсийг гуйн залбирах нь утгагүй хэрэг юм. Чи яг одоо Эзэнд бууж өгөхийг хүсэж байна уу?"

"Би чадахгүй" гэж залуу хариулав.

"Тэгвэл Бурхан чиний өмнөөс үүнийг хийгээсэй гэж хүсч байна уу?"

"Тиймээ" гэж залуу хэлэв.

"Тэгвэл одоо Эзэнээс гуй" хэмээн пастор хэллээ.

Залуу ийн залбирав:

"Өө, Эзэн минь, өөрийн хүслийг үгүйсгэн Таны хүсэлд бүрэн бууж өгөхөд минь туслаач. Есүсийн нэр дээр гуйж байна."

---

8 Элен Уайт, *Анагаахуйн Үйлчлэл,* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2003), х. 498.

Дараа нь пастор түүнээс: "За хэлснээр чинь болж чадсан болов уу?" гэж асуухад,

"Тэгсэн байх ёстой, учир нь би Бурханаас Түүний хүслийн дагуух зүйлийг гуйсан. Миний залбирал сонсогдож, би хүссэн зүйлээ хүлээн авсан" (1 Иохан 5:14,15) гэдэг эшлэл байдаг тиймээс би хариултаа авсан. Миний хүсэл ингээд энд ялагдлаа" хэмээжээ.[9] Дараа нь тэр залуу Ариун Сүнсний төлөө залбирч, Түүнийг хүлээн авав. Хэрэв бид хайрын Бурханаас гуйвал Тэрээр биднийг асуудлаас хэлтрүүлж эсвэл боломжийг өгөхөд бэлэн байдаг нь гайхалтай юм.

Энэ хүний залбирлаас бид хоёр зүйлийг сурч болно. Нэгдүгээрт, тэр залуу амлалтаар залбирах нь их чухал гэдгийг аль хэдийн мэддэг байжээ. Залбиралдаа хэлэхдээ, Бурханы хүслийн дагуу залбирсан залбирлууд нь хэлсэн даруйдаа хариулагддаг гэсэн Эзэний амлалтад найдсан байна. Хоёрдугаарт, тэр залуу бууж өгөхийн тулд Бурханы тусламжийг авахаар шийдсэн юм.

Шийдвэрүүдээр амьдралаа удирдах нь

Чөлөөт сонголт хийх чадвар нь бидний амьдралаа чиглүүлэх эрх мэдэл гэдгийг бид мэдэж байх ёстой. Энэ чадварын бүрэн утгыг илүү сайн тайлбарлахын тулд танд нэгэн жишээ хэлье.

"Queen Elizabeth" хэмээх зорчигч тээвэрлэдэг хөлөг онгоцны их бие нь залууранасаа 1300 дахин илүү жинтэй ажээ. Энэ залуур өөрөөсөө 1300 дахин том хэмжээтэй зүйлийг жолоодох чадвартай гэсэн үг юм. Тэгэхээр бидний амьдралын жолоодлого бол шийдвэр гаргах чадвар юм. Хэрэв бид Бурханы хүсэлд өөрсдийгөө нийцүүлэхээр шийдсэн бол Тэрээр шаардлагатай бүх тусламжийг бидний мэдэлд өгдөг.

Сорилт бэрхшээлүүд

Христэд бууж өгнө гэдэг нь өөрсдийнхөө төлөө амьдрах эсвэл Бурханы төлөө амьдрах эсэхээ шийдэж байгаа юм. Хүн бүр, ялангуяа залуу хүмүүс амьдралаа өөрсдийн аминч үзлээр удирдах уу эсвэл Бурханд үйлчлэхийг хүсч байна уу гэдгийг өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Материаллаг эд зүйл, таашаал мэдрэмж нь аз жаргалын хуурмаг байдлыг бий болгодог ба эдгээр нь жинхэнэ сэтгэл ханамжийг авчирдаггүй - бид үргэлж илүү их зүйлийг хүсдэг. Германы алдартай зүйр үгэнд их зүйлтэй болох тусам илүү ихийг хүсч, гомдоллох нь хэзээ ч зогсдоггүй хэмээн хэлжээ.

Эцэст нь, тэдгээр зүйл биднийг эзэмдэж байсныг ойлгодог.

---

9 R. A. Torrey, Der Heilige Geist—Sein Wesen und Wirken (Frankfurt: 1966), S. 151; (The Holy Spirit— His Nature and Ministry).

Цаашлаад анхаарах ёстой асуудал бол бидний амьдралд тодорхой эрх мэдэлтэй байдаг хүмүүс юм. Жишээлбэл гэр бүл, сургууль, сүм, ажил болоод нийгэм дэх хүмүүс биднээс Бурханы хүсэлд харшлах зүйлсийг хүсч байдаг. Бид Есүст бууж өгөх үедээ Бурханы хүслийг хамгийн чухал үүргээ хэмээн үзэж, хүч чадалтай зоригтой болж, байр сууриндаа бат зогсож, мэргэн ухаан, элдэг байдлаар хандах чадвартай болдог. Даниел 1, Даниел 8-р бүлгийг уншина уу. эшлэл. 9, 14, 15, 17, 20).

Бурханд нэг удаа бууж өгөх нь хангалттай юу?

Бид анх Есүс Христэд итгэх үеэсээ бууж өгөх үндсэн алхмыг эхлүүлдэг. Энэхүү бууж өгөх явдал нь залбирал үйлдэж, зохистой Библи судлал авч итгэл үнэмшил төрөх үед явагддаг ба тийнхүү баптисмаар баталгаажиж, мөнхөд хүчин төгөлдөр болдог. Есүст анхлан бууж өгч буй энэ явдлыг Бурханы Үгэнд нэрлэхдээ Бурхантай тогтоосон бидний гэрээ хэмээдэг.

Харин өдөр бүр бууж өгнө гэдэг нь өөр зүйл билээ. Ихэвчлэн үүнийг зориулалт, өөрчлөлт, шинэчлэлт хэмээн нэрийддэг боловч, эдгээр илэрхийлэл нь эргэлзээг төрүүлдэг. Тийм учраас тодорхой болгохын тулд би үүнийг зориулалт гэж нэрлэе. Өдөр бүр зориулах (эсвэл бууж өгөх буюу өөрчлөгдөх) гэдэг нь өнөөдөр би Бурхантай хийсэн гэрээнийхээ заалтыг биелүүлэхийг хүснэ гэсэн үг. Тийм учраас өдөр бүр "Эзэн минь, би өнөөдөр бүхий л зүйлээрээ Танд бууж өгөхийг хүсч байна. Би өнөөдөр гэрээгээ дагахыг хүсч байна" хэмээн залбирах нь маш чухал юм.

Библид Христтэй хийсэн гэрээг гэрлэлттэй зүйрлэсэн байдаг. Хэрэв би гэрлэлтийн тангаргаа зөрчихгүй байвал санаа зовох хэрэг байхгүй. Бурхан Өөрөөсөө хамаарах бүх зүйлээ хамгаалах чадвартай. Тэр Өөрийн үгийг үргэлж дагадаг. Тэрээр салах өргөдөл гаргахгүй.

Моррис Венден: "Мэдээж гэрлэлт гэдэг нь гэрлэлтээ хадгалж үлдэхээр төлөвлөөгүй байж гэрлэнэ гэсэн үг биш. Хэрэв та гэрлээгүй бол гэрлэлтээ хадгалж үлдэнэ гэсэн ойлголт байхгүй."[10]

Бид Бурханд бууж өгсөн эерэг үр дагаврыг хадгалахын тулд Есүсийн дотор үлдэх шаардлагатай. Тийм ч учраас Есүс Иохан 15 дээр "Дотор байх" тухай 9 удаа дурдсан байдаг. Тухайлбал 5, 7-р эшлэлд "Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй." "Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарын төлөө биелэх болно" гэсэн байдаг.

10 Morris Venden, 95 Theses on Righteousness by Faith (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2003), p. 133.

Хангалуун амьдрал нь Есүсийн дотор байснаар ирнэ. Бид Түүнтэй нөхөрлөснөөр үр бүтээлтэй амьдрах буюу баяр хөөртэй, хүч чадалтай, ялгуулсан амьдралаар амьдарна. Бурхан бидний амьдралд агуу зүйлсийг хийж чадна. Бид энэ үнэнийг хэрэгжүүлж чадваас амьдралыг маань өөрчлөн шинэчлэх болно.

Галын дөлийг асаа: Би Адвентист гэр бүлээс гаралтай учраас үргэлж шашинтай ойр байсаар ирсэн. Тэгээд би 13 настайдаа баптисм хүртэхээр шийдсэн билээ. Гэсэн хэдий ч миний сүнслэг амьдрал нэг л уйтгар гунигтай хэвээр байв. Миний дотор ямар нэгэн гал асахгүй байлаа. Тэгтэл Бурхан надад нэг жилийн хугацаатай АНУ уруу явах боломжийг олгосон юм. Миний хувьд би Англи хэл сурч, цагийг зугаатай өнгөрөөхийн тулд тийшээ явлаа. Гэтэл нэг орой Ариун Сүнс надаас "Мael, чи зөв газраа байгаа гэдэгтээ итгэлтэй байна уу?" хэмээн асуув.

Би АНУ-аас буцаж ирснийхээ дараа Швед рүү явахыг хүссэн юм. Гэхдээ бүх боломж хаалттай байв. Би яг л хадны завсар хавчуулагдсан халиуны зулзалга шиг амьдралдаа юу хийхээ мэдэхгүй байлаа. Гэтэл нэг өдөр дотны найз маань надад Хелмут Хаубэйлийн "Есүс дотор байгтун" хэмээх номыг өгсөн юм. Номыг аваад эхний өдрөө уншаад л шимтэн оров. Тэр үед Бурханы дуу хоолой эргэн ирсэн юм. Орой бүр унших болгонд миний доторх дөл асч байлаа. Би унших тусам Ариун Сүнсний дутагдалтай байгаа алдаагаа илүү ихээр ойлгосон! Энэ номыг би хэд хэдэн удаа уншсан ба хэрхэн яаж өөрчлөгдөхөө ч гадарлаагүй байлаа. Бурхан хариултыг мэдэж байсан бөгөөд намайг анзаараа ч үгүй байтал миний үг яриа, үзэл бодол, чиг хандлага маань өөрчлөгдсөн юм. Энэ бол надад нөлөөлсөн Ариун Сүнсний ажил байв. Тэгж байтал гэнэт Францад ажил мэргэжлийн холбоотой хаалга нээгдэв. Миний хувьд Франц явах нь Бурханы төлөвлөгөө байсан ч, Швед яваагүйдээ сэтгэл гонсойж байлаа. Галын дөл асч байсан ч дүрэлзэхгүй байв. Тэгтэл Парисын Даммари хотод Хелмут Хаубэйл ирэв. Би түүний семинарт Баасан гарагийн орой, Бямба гарагийн өглөө, үдээс хойш очсон ч ... хариултаа аваагүй байлаа. Галын дөлийг хэрхэн яаж асаах вэ?

Харин сүүлийн өдөр болох Ням гарагийн өглөө хариугаа олсон юм. Миний гол асуудал бол Бурханы хүслийг бүрэн дагаагүй явдал байжээ. Ариун Сүнсний дуу хоолой байнга ярьж байдаг ба үүнийг хүлээж авсныхаа дараа Түүний хүсэлд захирагдаж, өөрийгөө үгүйсгэх шаардлагатай болдог гэдгийг ойлгосон юм. Үүнийг хийгээгүйгээс болж Матай 6:33-т хэлсэн шиг Бурхан биднээр дамжуулан ажиллах боломжгүй юм. Бурхантай харилцах харилцаанд өөрийгөө мартан Түүний хүслийг дагах нь нэн чухал болохыг би тэр үеэс хойш ойлгосон. Зөвхөн ингэсний дараа л дөл дүрэлзэх болно. Мael (Л. Р.)

Залбирцгаая:

“Бурхан Аавaа, биднийг ивээхийн тулд биднийг Танд бууж өгөөсэй хэмээн хүсч байдагт тань маш их баярлалаа. Та биднийг шинэ бүтээл болгож, өөрчлөгдсөн амьдралаар амьдрахад минь туслаач. Амьдралдаа өдөр бүр Танд бууж өгч, бүх зүйл дээр Таныг дагаж амьдрахад минь надад туслаач. Амен. ”

Ариун Сүнсээр дамжуулан ирдэг аз жаргал

"Эзэн Есүс Ариун Сүнсээр дамжуулан ажилладаг; Ариун Сүнс бол Түүний төлөөлөгч юм. Түүгээр дамжуулан хүмүүсийн сэтгэлд сүнслэг амьдралыг шингээдэг ... Бурханы Сүнсээр сургагдан төлөвшүүлэгдэх хүртлээ хүний зүрх сэтгэл аз жаргалыг хэзээ ч мэдэхгүй." Элен Уайт, РХ 8 сарын 25, 1896, хэсэг 6.

Залуучууд ба Ариун Сүнс

Чуулган дахь Залуучуудын хэлтсийн үр дүн үнэхээр гайхалтай байсан тухай

Би бол Өмнөд Квийнслэндийн чуулганы Залуучуудын Хэлтсийн нарийн бичгийн дарга билээ [12,200 гишүүнтэй]. Нэгэн эмэгтэй надад *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номыг өгсөн юм. Номын агуулга нь намайг алмайруулсан юм. Би энэ товхимлоос ойлгосон олон зүйлийг хуваалцаж чадна. Бид энэ номоос маш их ивээлийг авсан. Бид чуулганы хурлын үеэр 300 гаруй номыг залуу удирдагчдад тараасан юм. Үр дүн нь үнэхээр гайхалтай байсан. A.v.R. товчилсон хэлбэр, # 138

Донтолтыг даван туулсан 14 настай хүү

Миний 14 настай хүү Ариун Сүнсийг гүйн залбирч эхэлсэн мөчөөс тэс өөр хүү болон хувирсан юм. Тэрээр донтолтоо ялан дийлсэн юм. Тэр одоо ялалтын амьдралаар амьдарч байна. Бурхан хүүгийн маань амьдралд энэ номыг ашигласан явдалд бид маш их талархаж байна. Пастор А., №77

Баптисмын асуудлыг шийдсэн нь

Нэгэн эмэгтэйн бага хүү сүмд явах тал дээр олон асуудалтай байв. Тиймээс тэр эмэгтэй залбирлын хамтрагчтайгаа 40 өдрийн залбирлын үеэр хүүгийнхээ төлөө залбирчээ. Үр дүнд нь түүний хүү амьдралаа өөрчилж, одоо баптисм хийлгэхээр бэлдэж эхэлсэн ажээ. I.G., № 16

18 настай хүүгийн амьдрал өөрчлөгдсөн нь

Манай чуулганы дарга нарын нэг нь 18 настай хүүдээ энэ товхимлыг өгсөн юм. Тэгтэл энэ ном түүний амьдралыг өөрчилжээ. Тиймээс аав нь хүүгийнхээ сургуулийнханд энэ номоос 200 гаруй ширхэгийг тараасан билээ. С.Н.#133

Бос, гэрэлт, учир нь гэрэл чинь ирж байна.
Ис. 60:1

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Бурханлаг уриалгыг хүлээн авч амьдралаараа бууж өгөхөд ямар бэрхшээл тулгарч байна вэ?*

_____

2. *Хүмүүс Бурханд бууж өгөхөд юу саад болдог вэ? Харин таны хувьд юу саад болж байна вэ?*

_____

3. *Тэнгэрийн чиглүүлэгчийн (GPS) дагуу амьдрах нь ямар давуу талтай вэ?*

_____

4. *Христтэй тогтоосон харилцаагаа дотно байлгахад юу чухал вэ?*

_____

5. *Бидний амьдралыг удирдаж байгаа гол хүчин зүйл юу байна вэ?*

_____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Бүрэн бууж өгөхөд саад болж болох зүйлийг Бурхан бидэнд харуулахын төлөө*
  2. *Өөрсдийн хүслээ зөв зохистой ашиглах мөн юу нь чухал гэдгийг ялгаж, мэргэн ухаан, хүч чадлыг Бурхан бидэнд өгөхийн төлөө*
  3. *Бурхан бидэнд илүү их ухаарлыг өгч, үүнд бидний өөрсдийн арга зам саад болохгүй байхын төлөө*
  4. *Бурхан бидэнд уруу таталт болон нүглийг ялан дийлэх боломжийг өгөхийн төлөө залбираарай.*

ТАНЫ ДОТОР БАЙХ ЕСҮС

"Христ миний дотор байх нь"
амьдралд ямар үр нөлөөтэй вэ?
Хамгийн эцсийн хүрэх зогсоол бол:
Бурханы бүрэн дүүрэн байдлаар дүүрэх юм

Христийн дотор бай

"Христийн шашин гэдэг нь Христийг зүрх сэтгэлдээ байлгах гэсэн үг юм."[1]
"Христ бидний дотор Сүнсээр дамжуулан амьдардаг ба тэр Сүнс нь Бурханы Сүнс юм; Сүнс нь зүрх сэтгэлд итгэлээр ирдэг ба мөнх амийн эхлэл ажээ."[2]
Дараах зүйлийг анхаарна уу.

- Ариун Сүнсээр дамжуулан Христ бидний дотор амьдардаг.
- Бид Ариун Сүнсийг итгэлээр хүлээн авдаг.
- Энэ бол мөнх амьдралын эхлэл юм.

Есүс Ариун Сүнсээр дамжуулан миний дотор байхыг хүсдэг ба Ариун Сүнсээр дүүрэн байх нь бидний хувьд маш үнэ цэнэтэй зүйл билээ. Энэ бол гайхалтай Библийн үнэн юм.

Есүс бидэнтэй Ариун Сүнсний тусламжтайгаар зөвхөн дотно харилцаатай байхыг хүсээд зогсохгүй, бидний Бурхантай харилцах харилцааг тууштай, улам илүү гүнзгий болгохыг хүсдэг. Тэрээр хэлэхдээ: *"Миний дотор байгтун, Би ч та нарын дотор байна"* гэж хэлсэн (Иохан 15:4). Энэ бол гайхалтай уриалга бөгөөд тушаал билээ. Христэд тууштай итгэн амьдрах нь Бурханы хүчээр хэрэгжих боломжтой гэсэн үг юм.

---

1 Элен Уайт, Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо, Хэсэг 4, 1892 оны 5-р сарын 24

2 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 388.

Иохан 15:1–17 дээр Есүс 11 удаа дотор байх гэдэг үгийг онцолсон байна. Тэр биднийг Түүнтэй удаан хугацааны харилцаа холбоотой байхыг хүсдэг юм. Тэрээр энэ санаагаа гайхамшигтай, итгэмээргүй Библийн бусад амлалтуудтай холбож өгчээ. *"Хэрэв чи Миний дотор байж, Миний үгс чиний дотор байвал чи юу хүссэнээ гуй, энэ нь чиний төлөө биелэх болно"* (Эшлэл 7).

"Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв" (Эшлэл 11).

"Миний дотор байгтун, Би ч та нарын дотор байна" гэсэн Есүсийн уриалгыг Элен Уайт дараах байдлаар сийрүүлжээ: **"Христийн дотор байна гэдэг нь** [1-рт] **түүний Сүнсийг байнга хүлээн авах,** [2-рт] **Түүнд бүрэн бууж өгөх явдал юм."**[3] Тэрээр бас өөр нэг тайлбартаа ийнхүү хэлжээ, "Бурханлаг хүчтэй байнга холбоотой байх нь бидний хөгжил дэвшилд чухал ач холбогдолтой юм. Бид магадгүй тодорхой хэмжээний Бурханы Сүнстэй байж болох ч залбирал хийгээд итгэлээрээ бид Сүнсийг улам ихээр олж болно."[4]

"[Есүс] тэдгээр хүмүүсийн дотор амьдарч, тэдэнд ариусгагч Сүнсний урам зоригийг өгч, тэдэнд Өөрийгөө өгсөөр байх болно."[5] Бид Давидын үйлдсэн залбирлыг бидэнд зориулж өгсөн амлалт хэмээн ойлгож болно: "Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, Миний дотор зөв сүнсийг шинэчлээч" (Дуулал 51:10).

Бурханы хүчээс зуурах нь

Ихэнх хүмүүс Бурханы хүчийг хэрхэн ашиглахаа мэддэггүй. Тиймээс тэд сүнслэг ядууралд амьдардаг. "Өөрийнхөө алдар ба давуу чанараар биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний бурханлаг хүч бидэнд амь болоод сүсэглэлд хамаатай бүхнийг соёрхсон" (2 Петр1:3).

Техаст Ятесийн цөөрөм хэмээх нэгэн алдартай газрын тосны талбай байдаг. Америкийн эдийн засгийн хямралын үеэр Ятес хэмээх нэгэн хоньчин байжээ. Тэрээр хонины аж ахуйгаараа өр төлбөрөө төлөх хангалттай мөнгө олж чадахгүй байв. Тэгтэл нэгэн газрын тосны компаний хүмүүс ирж, түүний газар дээр газрын тосны орд олсноо мэдэгджээ. Компани туршилтын өрөмдлөг хийхийг санал болгосон тул Ятес тэдэнтэй гэрээ байгуулав.

Өрөмдлөгийн үеэр 1200 метрийн гүнд асар том газрын тосны орд олдсон байна. Энэ бүхэн ноён Ятесийн мэдэлд байсан юм! Тэрээр газрыг

3 Дээрх номтой адил., х. 676.

4 Элен Уайт, *Та Нар Хүчийг Авна* (Hagerstown, MD: Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо, 2012 оны 10 сарын 24 х. 306.

5 Дээрх номтой адил., 10 сарын 23; х. 305.

худалдаж авсан өдөртөө газрын тос болон бусад байгалийн баялгийг эзэмших эрхээ авсан байв. Тэр өөрийгөө ядуу амьдарч буй тэрбумтан гэдгээ мэдээгүй байжээ. Асуудал нь юу байсан бэ? Тэр тосны талаар огт мэдээгүй байсан юм.[6]

Та 2 Петр 1:3,4 дээр юу гэж бичигдсэнийг мэдэх үү? "Түүний бурханлаг хүч бидэнд амьдрал ба бурханлаг чанартай холбоотой бүхий л зүйлийг бидэнд өгсөн." Эшлэлийн үлдсэн хэсгийг би өөрийн үгээр хэлж өгье: Есүстэй дотно харьцаатай байж, "Агуу амлалтуудыг нэхэмжлэн залбирч бай."

Бид Христэд итгэснээр Бурханы хүүхдүүд буюу Түүний өв залгамжлагчид болдог ба Түүний бүх нөөц бололцоо бидний мэдэлд ордог. Бурханы ард түмэн буюу Христийн нөлөө бүхий гэрчүүд болоход шаардлагатай мэргэн ухаан, хайр, хүч чадал зэрэг нь бидэнд өгөгдсөн. Гэвч олон итгэгч сүнсээр ядуу амьдардаг. Учир нь тэд Бурханы хэдийнээ өгсөн сүнслэг баялгийг хэрхэн ашиглахаа мэдэхгүй байгаа юм! Ноён Ятес өөрийнх нь өмчилсөн газар нутгаас газрын тос илрүүлэхээс өмнө хязгааргүй эд хөрөнгөө үл тоомсорлон амьдардаг байлаа.

Энэ ямар утгатай вэ? "Христ хэмээх холбоосгүйгээр хэн ч аврагдахгүй. Бид Христгүйгээр уруу таталтын шуургыг тэсвэрлэж чадахгүй. Бидний мөнхийн аюулгүй байдал маань бат бөх суурин дээр тулгуурласан эсэхээс шалтгаалдаг. Өнөөдөр олон хүн баталгаагүй суурин дээр амьдралаа босгон байгуулж байна. Бороо орж, хүчтэй шуурга шуурч, үер болох үед тэдний байшин нуран унах болно, учир нь тэд мөнхийн хад буюу булангийн чулуу болох Есүс Христ дээр суурилаагүй юм."[7]

Ариун Сүнсийг залбиран гуй

Библийн номонд Эзэн Есүс биднийг Ариун Сүнсний төлөө гуйн залбирахыг 10 удаа уриалсан өвөрмөц эшлэл байдаг. Өөрийнх нь дотор байхыг уриалсан шиг ийм нухацтайгаар бидний анхаарлыг хандуулахыг хичээж буй өөр ямар нэгэн эшлэл байдгийг би мэдэхгүй юм байна. Энэ эшлэл бол залбирлын тухай сургамж юм. Ариун Сүнсний төлөө гуйн залбирах тухай энэхүү эшлэл Лук 11:9–13 дээр байдаг. Бид зөвхөн энэ гол эшлэлийг чухалчлан авч үзэхээс гадна энэ бүлгээр дараах зүйлсэд анхаарал хандуулах болно: *"Түүн дотор та нар төгс болгогдсон"* (Кол. 2:10).

Элен Уайт хэлэхдээ: "Есүст ... Ариун Сүнс хэмжээлшгүйгээр [өдөр бүр] өгөгддөг байсан. Тиймээс бүх зүрх сэтгэлээрээ бууж өгсөн Христийн

6 Dr. William R. Bright, Erfüllt mit dem Heiligen Geist—Wie erfährt man das? (Neuhausen, 1971), S. 27.

7 Элен Уайт, *Үе Үеийн Хүслэн,* х. 599, 600.

дагалдагчдад бас өгөгдөх болно (Ариун Сүнсийг өдөр бүр Эзэнээс гуйдаг бол). Бидний Эзэн Өөрөө 'Сүнсээр дүүрэн бай' хэмээн тушаасан (Ефес 5:18) бөгөөд энэ тушаал нь бас амлалт юм. Христ дотор «Бүгд дүүрэн амьдарч» мөн «Түүний дотор бүрэн бүтэн» байх нь Эцэгийн хүсэл юм (Колоссай 1:19, 2:10).[8]

Эндээс бид дараах зүйлийг суралцдаг:

- Ариун Сүнс Есүсийн дотор хэмжээлшгүйгээр оршдог байв.
- Ариун Сүнс бидний дотор яг ийм хэмжээгээр оршин байхын тулд биднийг бүрэн бууж өгсөн амьдралаар амьдраасай гэж Есүс хүсдэг.
- Тийм учраас Есүс бидэнд: «Сүнсээр дүүрэн бай» гэсэн тушаалыг өгсөн (Ефес 5:18).
- Түүний зорилго бол биднийг энэ дэлхий дээр илүү хангалуун амьдралтай байлгах (Иохан 10:10; Кол. 2:10) мөн мөнхийн улсад оруулах юм (Иохан 3:16).
- Тиймээс бид Түүний дотор байх шаардлагатай. Бидний дотор Есүс орших нь маш сайн бөгөөд үнэхээр үнэ цэнэтэй үр дагавартай байдаг.

Итгэлээр залбирах нь

Бид итгэлээр залбирдаг *"Ингэснээр бид итгэлээрээ Сүнсний амлалтыг хүлээн авах юм"* Галат 3:14. *"Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм."* (Еврей 11:6). *"Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглана. ..."* (Ефес 3:17).

Ариун Сүнсийг гуйн залбирсаныхаа дараа Түүнийг үнэхээр хүлээж авсан гэдгээ мэдэх шаардлагатай. Бидний гайхамшигтай Бурхан Өөрт нь хэрхэн амархан итгэж болох аргыг бидэнд харуулсан. Энэ нь амлалтаар залбирах арга юм. (*"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* номын 5-р бүлгээс дэлгэрэнгүй уншаарай.)

Элен Уайтын хэлснээр, "Ариун Сүнс бидний "Шаардлага" болоод зөвшөөрлийг хүлээж байдаг."[9] Мөн Дэвид Волквитц ийнхүү нэмж хэлжээ.

Бурханаас та ямар нэгэн зүйл "Шаардана" гээд төсөөлөөд үздээ. Энэ удаад Ариун Сүнсний онцгой бэлгийг шаардана гэсэн үг. Ийм бодол нь айдас төрүүлмээр байгаа биз. Ийм зүйлийг бодох нь хүртэл хүндэтгэлгүй, доромжилж байгаа мэт сонсогдож байна. Гэхдээ энэ тухай бичээст олон удаа дурдсан байдаг. Юу гэсэн үг вэ гэхээр нэгдүгээрт, Бурхан бидэнд ийм бэлэг өгөхдөө дэндүү баяртай байдаг гэдгийг бид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй, учир нь Тэр бидэнд хайртай бөгөөд энэ Түүний өгөх зүйл нь

8 Элен Уайт, *Ерөөлийн Уулан Дээрх Сургаал,* х. 21.

9 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 121.

бидэнд маш их хэрэгтэй юм. Хоёрдугаарт, энэ бэлэг нь бидний хувьд туйлын чухал юм. Энэ бэлэг нь бидний шаардан хүсэхийг хүлээж байдаг. Бид амьдралаа удирдуулахын тулд Христийн оршихуйгаар үргэлж дүүрэн байхыг хүсэж, тийнхүү Бурханд бүрэн бууж өгсөн гэдгээ мэдэж байгаа бол энэхүү шаардлагыг тавихдаа итгэлтэй байж болно. Бид үүнийг нухацтай авч үзэх хэрэгтэй.[10]

Ямар нэгэн зүйлийг шаардах нь тухайн зүйл танд үнэхээр хэрэгтэй эсвэл хүсч байгааг тань илтгэдэг буюу тухайн хүн хэр нухацтай хандаж байгааг илэрхийлдэг. Бид хувийн хүсэлт шаардлагаа хойш тавих хэрэгтэй. "Хүмүүс Бурханы нэрийг алдаршуулахын тулд Түүнээс өндөр шаардлагуудыг тавихад Тэр [Бурхан] маш их баяртай байдаг."[11]

Бид өдөр бүр бүхий л зүрх сэтгэлээрээ Есүст бууж өгснөөр итгэлийнхээ дагуу Бурханы агуу бэлэг болох Ариун Сүнсийг хүлээж авдаг.

Элч Паулын гайхалтай зуучлан залбирал

Энэ сэдвийн дагуу бид Ефес 3:14-21-р эшлэлийг үзэх болно. Элч Паулын Ефес дэх чуулганд өгсөн гайхалтай зуучлан залбирлыг эндээс бид харж болно. Санааг нь доор өгүүлэв:

1. Паул тэдний төлөө Ариун Сүнсний хүч чадлыг гуйн залбирсан.
2. Тэдний зүрх сэтгэлд Христ нутаглахын төлөө
3. Бурханы хайрыг бүрэн дүүрэн мэдэрч, тэрхүү хайр нь тэдний зүрхэнд үндэс суурь болохын төлөө
4. Бурханы бүрэн дүүрэн байдлаар дүүрэхийн төлөө
5. Бурхан бидэнтэй хамт байхад ямар байдгийг эндээс харна: Ариун Сүнсээр дүүрч, Христ бидний дотор амьдарсанаар бидний зан чанар эерэгээр өөрчлөгдөж байдаг - Сүнсний үр жимс.

"Иймд би Эцэгийн өмнө өвдөг сөгдөж, тэнгэр болон газар дахь бүхэл гэр бүлийг нэрлэдэг Түүнд залбирч байна. **Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай.** Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг **Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай"** (Ефес 3:14–19, KJV).

---

10 David Wolkwitz, Der Weg zu einer kraftvollen Erweckung (The Way to a Powerful Revival) (NRW, Abt. Heimatmission), S. 205.

11 Элен Уайт, *Ye Yeийн Хуслэн,* х. 668.

Дотоод хүчийг хэрхэн мэдрэх вэ?

Ефес 3:16 дээр бурханлаг амьдралын үндэс суурийг харуулсан байдаг: *"Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай."* (KJV)

Бидэнд өдөр бүр хүч чадал хэрэгтэй байдаг. Хүч чадлаар дүүрэн амьдрал бидэнд баяр хөөрийг авчирдаг. Бидний гайхалтай Эзэн биднийг амьдралдаа хангалттай хүчтэй байгаасай гэж хүсдэг. Дотоод хүний энэхүү хүч нь Ариун Сүнснээс ирдэг. *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номын 60-р хуудсанд яагаад өдөр бүр өөрсдийгөө Есүст зориулж, өдөр бүр Ариун Сүнсийг залбиран гуйх нь чухал болохыг харуулсан байгаа. Амлалтуудыг барин залбирсанаар бид асуусан даруйдаа Ариун Сүнсийг авна гэдэгтээ итгэлтэй байж болно. Энэ номыг унших нь их чухал гэдгийг би та нарт дахин сануулъя.

Христ бидний дотор байх нь

Дараа нь 17-р эшлэл дээр ямар санааг илэрхийлж байна вэ? **"Христ та нарын зүрх сэтгэлд итгэлээр оршино."**

Бид энэ гайхалтай үнэнийг хангалттай мэддэг бил үү? Ариун Сүнстэй амьдрах үед Христ бидний дотор амьдардаг гэсэн үг. Бид үүнийг мэдэрч эсвэл хэмжиж чадахгүй. Бид зүгээр л итгэх хэрэгтэй. Хэрэв та үүнд итгэж байвал одоо Түүнд "Эзэн Есүсээ миний зүрх сэтгэлд оршин байгаад баярлалаа" эсвэл "Эзэн минь Та миний дотор амьдардагт би үнэхээр их баярлаж байна" гэж хэлээрэй.

Андрю Мюрэй ийн хэлжээ: "Энэ л арга замаар Есүс таныг Өөртэйгөө нөхөрлүүлэх нөхцөлд оруулдаг ба Түүний амьдрал таны амьдралын нэг хэсэг болдог."[12]

Мөн Элен Уайт хэлжээ: "Ариун Сүнсний нөлөө нь таны зүрх сэтгэлд буй Христийн нөлөө юм."[13] "Хүмүүсийг бурханлаг шинж төрхтэй болгох төлөвлөгөөнд Ариун Сүнс хүний оюун ухааныг сэнхрүүлж, Христийн оршихуйг мэдрүүлж мөн зан чанарыг төлөвшүүлэх үүрэг хүлээсэн юм."[14] "Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн. [Колоссай 1:27]."[15]

Энэ эшлэлийн дагуу Христ бидний зүрх сэтгэлд **итгэлээр** оршдог ажээ. Итгэл бишрэлийн үндэс суурь бол итгэх юм. Энэ бол бүхий л

12 Andrew Murray, Bleibe in Jesus (Remain in Jesus) (Leun, 2012), S. 149.

13 Francis D. Nichol, ed., Конкорданс, ботьl. 6 (Hagerstown, MD: Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо, 2001), х. 1112.

14 Элен Уайт, *Та Тар Хүчийг Авна,* 2 сарын 8; х. 47.

15 Дээрх номтой адил., 2 сарын 4; х. 43.

амьдралаа Есүст даатгах тухай асуудал юм. Бид эхлээд Түүнд бууж өгөх шийдвэр гаргах шаардлагатай бөгөөд дараа нь Христэд өдөр бүр бууж өгөх хэрэгтэй.

Итгэл болон мэдрэмж хоёр хоорондоо ямар уялдаа холбоотой вэ?

Бурханы үгэнд ийн хэлжээ: *"Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу* ***Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай.*** *Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад ..."* (Ефес 3:16,17). Бид зүрх сэтгэлдээ Христийг оршин байлгахын тулд Ариун Сүнсээр дүүргэгддэг ба энэ нь *итгэлээр* гүйцэлддэг зүйл юм.

Есүс хэлэхдээ *"Бичвэрт хэлсэнчлэн* ***Надад итгэгчийн дотроос*** *амийн усны гол урсах болно гэв"* (Иохан 7:38). Бид энэ зүйлд анхаарлаа үргэлж нухацтайгаар хандуулах хэрэгтэй. Итгэл бишрэлийн цэм нь итгэх юм. Би Есүсийн хэлсэнд итгэдэг. Тэрээр Эцэгийнхээ талаар хэлэхдээ, *"Таны үг бол үнэн юм"* (Иохан 17:17) гэж хэлсэн. Элен Уайт хэлэхдээ: "Итгэл гэдэг нь Бурханы үг дээр өсөж ургадаг ба Бурханыг амласныхаа дагуу үйлдэхийг нэхэмжлэн шаарддаг зүйл юм."[16]

Бурханд итгэнэ гэдэг нь Түүний үгэнд итгэн найдахыг хэлнэ. Би Бурханы үгэнд итгэдэг. Харин мэдрэмжиндээ хөтлөгдөн амьдрах нь ямар байдаг вэ? Тэгэхээр би өөрийнхөө доторх ямар нэгэн зүйлд итгэж байна гэсэн үг. Бурхан Рожер Ж. Морнэйг Сатаны сүмээс явтал нь бидний нүдийг нээж өгдөг: Чөтгөрийн сүнс нь хүмүүсийг Бурханы эш үзүүлэгчид болон Христийн үгийг сонсохоос илүүтэйгээр мэдрэмжээ дагахад уриалдаг. Хүмүүс юу болж байгааг ухаарч амжаагүй байхад чөтгөрийн сүнснүүд хүмүүсийн амьдралыг хяналтандаа авсан байдаг.[17] Бид сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж эсвэл ямар нэгэн нууцлаг увидастай мэдрэмжийг эрэлхийлэх хэрэггүй.

Итгэл гэдэг нь Бурханд болон Түүний үгэнд итгэн найдах буюу Библийг зүгээр нэг хэрэгсэл эсвэл хачир байдлаар хүлээн авах бус, харин амьдралынхаа чиглүүлэгч болгохыг хэлнэ. Бид өөрсдийн хүчээр Бурханы үгийг дагаж чадахгүй гэж олон хүн маргадаг. Энэ нь махан биеэр амьдардаг итгэгч хүмүүсийн хувьд үнэн юм. Харин Ариун Сүнстэй амьдардаг хэний ч зүрх сэтгэлд Христ оршдог ба Бурханы үгийг сахихад бэлтгэгдсэн байдаг юм. Ром 8:4-д хэлдэг: "Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх

16 Элен Уайт, *Цаг Үеийн Шинж Тэмдгүүд,* 5 сарын 22, 1884, хэсэг. 3.

17 Roger J. Morneau, A Trip Into the Supernatural, (Hagerstown, MD: Review and Herald Publishing Association, 1999), p. 43.

болно." (Энэ сэдвийн талаар дэлгэрэнгүйг 4-р бүлэгт Есүст дуулгавартай байх нь сэдвээр ярих болно).

Бурханд найдаж, Түүний амлалтууд бидний амьдралд хэрхэн биелж байгааг мэдэрсэнээр Бурханд итгэх итгэл маань, мөн Түүний хайранд гүн суурилах байдал маань хүчирхэгждэг. Эцэст нь Бурханы энэ хайр бидний зүрх сэтгэлийн гүн хэрэгцээг хангаж өгдөг. Энэ нь яг л жаахан хүүхэд аавынхаа гарт тэврүүлж тав тух, аюулгүй байгаагаа мэдрэхтэй адил юм.

Гэхдээ хүүхдийн сэтгэл хөдлөл өөрчлөгдөхөд, аавын хайрлах сэтгэл шууд өөрчлөгддөггүй шүү дээ. Бурханы хайранд төлөвших тусам бидний өнгөц мэдрэмжүүд Бурхантай харилцах харилцаанд сэв суулгаж чадахгүй гэдгийг бид ухаардаг. Бидний мэдрэмжүүд найдваргүй. Учир нь эдгээр нь тогтворгүй юм. Харин бидний баталгаа Бурханд итгэх итгэл болон Түүний ганхашгүй үгнээс ирдэг.

Бид мэдрэмжний хойноос хөөцөлдөх хэрэггүй билээ. Христ бидний дотор Ариун Сүнсээр дамжуулан амьдрах үед, Сүнсний үр жимс бидний дотор урган хөгждөг. Эдгээр нь Ариун Сүнсээс ирэх гүн мэдрэмжийн бэлэг юм. Энд баяр хөөр том байр суурийг эзэлдэг. *"Эзэний баяр хөөр бол чиний хүч юм"* (Нехемиа 8:10). Итгэлийн амьдралд баяр хөөр нь түр зуур мэдрэгддэггүй, харин Бурхантай хамт амьдарснаар бидний дотор илүү хүчтэй болдог.

Бид Бурханд итгэдэг дагалдагч уу эсвэл мэдрэмжиндээ хөтлөгддөг дагалдагч уу гэдгээ ялгаж салгах нь ирээдүйд маш чухал ач холбогдолтой. Агуу мэхлэгч бидэнд гайхалтай зүйлсийг, бүр Есүсийн тухай хүртэл сонин хачин зүйлсийг үзүүлж сорих болно. Гэхдээ тэдгээр үзүүлбэрүүд нь мэдрэмж, ид шидээр гайхшруулсан өгөөш юм. Энэ бүхэн улам гүнзгийрч, хүмүүс өөрсдийгөө гайхалтай "Итгэмжтэй" байгаа мэтээр ойлгох болно, гэтэл тэд Бурханы үгэнд суурилахаас илүүтэй өөрсдийн мэдрэмжиндээ бүрэн суурилсан байх болно. Тэд сэтгэл хөдлөл, мэдрэмжиндээ удирдуулж байгаагаа сүнслэг байна хэмээн ойлгож, өөрсдөд нь Бурханы үг хэрэггүй хэмээн бодож магадгүй.

Есүс үүний эсрэг Матай 7:21–23 дээр тодорхой хэлсэн байдаг: *"Намайг "Эзэн минь, Эзэн минь" гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно. Тэр өдөр Надад олон хүн "Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?"* гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд "Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл" гэж хэлнэ."

Тиймээс бид зөвхөн дараах зүйлсийг хэлж болох юм: Итгээд дага, Есүсийн дотор аз жаргалтай байхаас өөр ямар ч зам байхгүй, (*Сүмүүдэд Өгөх Зөвлөгөө* 5-р боть "Есүс рүү харж байна" хэмээх 21-р бүлгийг харна уу).

Яагаад Бурханд үргэлжлүүлэн бүрэн бууж өгсөөр байх нь чухал вэ?

Ром 12:1 дээр Бурхан элч Паулаар дамжуулан дараах зүйлсийг хүссэн байдаг: *"Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн."* Түүнчлэн Сургаалт үгс 23:26 дээр дараах уриалгыг хэлсэн байдаг: *"Хүү минь зүрх сэтгэлээ надад өг."*

Бууж өгөх гэдэг нь ямар утгатай болохыг "Есүст бууж өгөх нь" хэмээх 2-р бүлэгт илүү дэлгэрэнгүй тайлбарласан байгаа. Мөн *Христэд Хүрэх Зам* номын 5-р бүлэгт тодорхой тайлбарласан байгаа.

Бурханы хайранд бүрэн бууж өгөх нь бидэнд агуу ивээлийг авчирдаг. Амьдралаа Есүсээр удирдуулахыг зөвшөөрөх үед, Тэрээр биднийг хувиа хичээсэн би гэсэн үзлээс маань чөлөөлдөг (бүхий л атаархал, уур уцаар, маргаан, гэх мэт). Элен Уайт ийнхүү хэлжээ, "Сүнсийг өгнө гэдэг нь Христийн амьдралыг бидэнд өгч байгаа хэрэг юм. Ариун Сүнсийг хүлээн авсан хүн Христийн чанаруудыг эзэмшиж, хүлээн авдаг."[18] "Бид тоогоор ялалт байгуулах шаардлагагүй, харин Есүст бүрэн бууж өгснөөр ялалт байгуулах хэрэгтэй.[19]

Илчлэгдсэн нууцыг ойлгох нь

Ефес 3:18-р эшлэлийг үзэцгээе: "Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай." Бид юуг ойлгох ёстой гэсэн бэ? Христ бидний дотор (Ариун Сүнсээр дамжуулан) амьдардаг бөгөөд үүний дагуу бидний амьдрал өөрчлөгдөж байдаг. Яагаад гэвэл бид Бурханы хайранд үндэслэгдэн суурилсан байдаг. Энэ нь Есүс Христ бидний дотор Өөрийн зан чанарыг хөгжүүлдэг гэсэн үг.

Нэгэн итгэгч хүн ийнхүү бичжээ: "Христ дотор байх" мөн "Миний дотор Есүс байх" гэдэг нь үнэндээ маш энгийн ч ихэнх Христэд итгэгчид үүнийг хялбараар бүрэн ойлгож чаддаггүй билээ."[20]

Паул Колоссай 1:25, 26 дээр ийн хэлжээ: *"Бурханы үгийг биелүүлэхийн тулд та нарын тусын тулд Бурханаас надад соёрхсон үүргийн дагуу би энэхүү чуулганы үйлчлэгч болсон юм. Тэрхүү нууц нь өнгөрсөн үеүдээс,*

18 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 805.

19 Элен Уайт, *Бурханы Охид Хөвгүүд* (Hagerstown, MD: Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо 2003), х. 279.

20 Dennis Smith, Spirit Baptism and Abiding in Christ (2010), p. 12.

үр удмуудаас ***нууцлагдаж*** *байсан боловч одоо Өөрийнх нь ариун хүмүүст илэрхийлэгджээ."* **Энэ ямар нууц вэ** гэдгийг 27-р эшлэл дээр хэлсэн байна: *"Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн."*

Олон зууны турш нууцлагдаж байсан нууц одоо илчлэгдлээ: Есүс Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор амьдрахыг хүсдэг юм. Энэ бол бидний алдрын найдвар хэмээн бичээст хэлжээ. Энэ юу гэсэн үг вэ гэхээр бидний одоогийн амьдралд өгөхийг хүсч буй Бурханы бүрэн дүүрэн амьдрал хийгээд түүнчлэн мөнхийн амьдралыг бидэнд өгч буйн баталгаа юм.

Элен Уайт энэ нууцыг буюу алдрын найдвар болох "Христ таны дотор байх" (Колоссай 1:27) гэсэн санааг илүү дэлгэрэнгүй тайлбарласан байдаг: **"Энэ нууцын мэдлэг нь хүмүүст хязгааргүй хөгжих боломжийн цоожийг нээх түлхүүрийг атгуулж өгдөг."**[21] Библид ихэвчлэн "Христ таны дотор", "Христийн дотор", "Түүн дотор", "Эзэн дотор", "Хайртай хүмүүс дотор" гэсэн илэрхийллүүдийг ашигласан байдаг. Энэ илэрхийлэл Шинэ Гэрээнд 170 гаруй удаа ашиглагдсан байдаг. Жишээлбэл энэ илэрхийлэл нь Паулын Ефесчүүдэд бичсэн захидлын түлхүүр үг юм. Түүний гэрчлэлийн тухай бодоод үзээрэй: *"Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьдардаг"* (Галат 2:20). Түүнчлэн тэрээр Ром 15:18 дээр ийнхүү бичжээ: *"Учир нь Христийн надаар дамжуулан хийсэн зүйлээс өөр ямар ч юмыг би ярьж зүрхлэхгүй."*

Хүмүүсийн сайн мэддэг бусад эшлэлүүдийг дурдвал: *"Харин Бурханд талархлууд нь өргөгдөх болтугай. Тэр нь биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр анхилуулдаг"* (2 Коринт 2:14). *"Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн"* (2 Коринт 5:17). Гол анхаарах зүйл нь гэвэл Сүнсний нөлөөгөөр өөрчлөгдөж буй зан чанар юм: *"Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн"* (Ефес 2:10). *"Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно"* (1 Тесалоник 4:16). *"Харин Түүний үгийг сахидаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ. Үүгээрээ бид Түүний дотор байгаагаа мэднэ"* (1 Иохан 2:5). *"Тэр Өөрийн Хүүг ... илгээж, ... Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно"* (Ром 8:3,4). Хэрэв бид Библийн конкорданс номоос "Христ дотор", "Хайртай хүмүүс дотор", "Эзэн дотор", "Түүний дотор (Христ)" хэмээх үгсийг хайвал маш олон үнэ цэнэтэй эшлэлийг олох болно.

---

21 Элен Уайт, *Боловсрол* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2002), х. 172.

“Христ дотор” эсвэл “Христийн гадна”

Стэнли Жонс хэлэхдээ: “Паул ... “Христ дотор” гэсэн хэллэг дээр анхаарлаа төвлөрүүлж, энэ үгийг захиандаа 97 удаа ашигласан байдаг... Энэ хоёр үг хүн төрөлхтнийг “Христ дотор” болон “Христийн гадна” гэсэн хоёр бүлэгт хуваана гэдгийг тэрээр сайн ойлгожээ. “Христ дотор” байгаа нь “Амь рүү” орох бөгөөд “Христийн гадна” байгаа нь “Үхэл рүү” орох юм.”[22]

22 Е. Стэнли Жонс, *Христийн Дотор,* (London: Hodder and Stoughton, 1961), p. 9; Герман хэлнээс орчуулав.

Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа бүхэн махан биеийн дагуу бус харин Сүнсний дагуу явдаг хүмүүст ямар ч ял байхгүй.

Ром 8:1

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Элен Уайтын хэлснээр жинхэнэ үнэн шашин гэж юу вэ?*

_____

2. *Есүсийг зүрх сэтгэлдээ оруулахтай адил өөр ямар чухал зүйл байдаг вэ?*

_____

3. *Ариун Сүнсийг хүлээн авахад бидний Бурханд итгэх итгэл ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?*

_____

4. *Есүстэй тогтоосон харилцаа маань бидний мэдрэмжин дээр бус харин Түүнд итгэх итгэл болон Түүний үгэн дээр суурилах нь яагаад маш чухал байдаг вэ?*

_____

5. *Христ Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор оршиход, Түүний зан чанар бидний дотор хөгждөг ба энэ нь Сүнсний үр жимс юм. Энэ үйл явц таны амьдралд ямар хамааралтай вэ?*

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Есүс бидний зүрх сэтгэлд итгэлээр дамжуулан амьдардаг энэхүү жинхэнэ шашныг ойлгож ухаарахын төлөө*
  2. *Есүст зүрх сэтгэлээсээ бууж өгөхдөө тууштай байхын төлөө*
  3. *Ариун Сүнсний оршихуй бидний амьдралд илүү ихээр оршин байхын төлөө*
  4. *Мэдрэмжээ зөв зохицуулж, шийдвэрлэхийн төлөө*
  5. *Христийн авчирдаг баяр баясгалан үргэлж өсөн хөгжиж, илүү тод харагдахын төлөө*

"Христ таны дотор" байхын үр нөлөө
Бид нүглийн хүчнээс хэрхэн чөлөөлөгдөх вэ?
Бид нүгэл үйлдсэнээр эргээд "Махан биеийн"
хүмүүс болох уу?

"Христ таны дотор байх" талаар Элен Уайт

"Бурханы хүмүүс Сүнсээр нэгдэх үед Еврей үндэстний нүгэл болох Фарисайизм, өөрийгөө зөвтгөх байдал нь бүх хүний зүрх сэтгэлээс зайлуулагдах болно. ... Бурхан олон зууны турш нуугдмал байсан нууцаа дэлгэх болно. Тэрээр *'Харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг болох та нарын дотор байгаа алдрын найдвар Христийг'* мэдүүлэх болно (Кол. 1:27)."[1]

Иосеф, Даниел болон тэдний хамтрагчид

"Та эдгээр сайхан залуусын үлгэр жишээг дагахад бэлэн байх ёстой. Өөрийн байгаа байдлаасаа хэзээ ч бүү ич; байгаагаараа бай, хүмүүс болон тэнгэр элч нарын харцыг унагаа. Энэ зөвлөгөөтэй зөрчилдөхүйц үйлдлийг санал болгодог хуурамч даруу байдал, хуурамч хянамгай байдалд бүү автагдаарай. Өөрийн сонгосон үгс болон тууштай үйлсээрээ, мөн өөрийн ухамсарт, чин сэтгэлийн сүсэг бишрэлээрээ итгэлийн хүлцлээ хийгээрэй. Тэгснээр сэтгэлийн тань дуганд Христ залрах болно. Тийнхүү бүхий л авьяас бэлгээ хаанчлалын үйлчлэлд ашиглахын тулд Түүний хөлд авчраарай."[2]

Гэр бүлийн амьдрал

Христ зүрх сэтгэлд орвол нэгдмэл байдлыг авчирдаг. "Хэрэв Бурханы хүслийг биелүүлбэл эхнэр, нөхөр бие биенээ хүндэлж, тэдний дунд хайр, итгэлцэл бий болдог. Гэр бүлийн амар амгалан, эв нэгдлийг алдагдуулдаг аливаа зүйл нухчин дарагдаж, хайр энэрэл дээдлэгдэх ёстой.

1 Элен Уайт, *Сонгомол Мэдээнүүд,* 1-р ном, х. 386.

2 Элен Уайт, *Залуучуудад Хүргэх Мэдээ,* (Hagerstown, MD: Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо 2003), х. 28.

Хайр, энэрэл, тэвчээрийг гаргадаг хүнээс адилхан сүнс илэрхийлэгдэх болно. Бурханы Сүнс хаанчилж байгаа гэр бүлийн харилцаанд тохиромжгүй үг, хэл яриа гардаггүй билээ. Хэрэв алдрын найдвар болох Христ гэр дотор байгаа бол тухайн гэрт хайр болон эв нэгдэл байх болно. Эхнэрийн зүрхэнд Христ оршиж байвал нөхрийн зүрхэнд Христ орших зөвшөөрөл болдог. Өөрийн хүмүүст орон гэр бэлдэхээр явсан Христийн өргөөнд тэд хамтдаа оршин суух болно."[3]

"Та гэр орноо Абрахамын гэр шиг байгаасай гэж хүсэх хэрэгтэй. Тэрээр гэрийнхэндээ Бурханы тушаалыг дагахыг заасан. Ээжүүд ээ, та нар хүүхдүүддээ тэвчээртэйгээр эдгээр хичээлүүдийг зааж сургах ёстой. Та өнөө үеийн хэв загварыг судлахад цаг зав гаргаж болохгүй. Тэдэнд өөрсдийг нь Христийнх гэдгийг заа. Өнөөдөр бид зан чанарыг бүтээж байгаа билээ. Залуу эрчүүд, эмэгтэйчүүд ээ, та нар өнөөдөр ирээдүйн хувь заяагаа тодорхойлж байна. **Христийг урьж оруул. Тэр таныг уруу таталтаас хамгаалах болно.**"[4]

Ялалт

"Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна" (2 Коринт 5:17). Эрэгтэй, эмэгтэй хүмүүс Христийн хүчээр нүгэлт зуршлын гинжийг эвдэж чадсан. Тэд хувиа хичээх байдлаас татгалзсан юм. Энгийн нэгэн сүсэгтэй болж, согтуу нэгэн эрүүлжиж, бохир нэгэн цэвэр болов. Сатаны шинж чанарыг агуулж байсан хүмүүс Бурханы дүр төрхтэй болон хувирчээ. Энэ өөрчлөлт өөрөө гайхамшгийн гайхамшиг юм. Үгийн нөлөөллөөр гарсан өөрчлөлт нь өөрөө Үгийн хамгийн нууцлаг нууцуудын нэг юм. Бид үүнийг ойлгож чадахгүй, харин Библид хэлсний дагуу *"Алдрын найдвар болох Христ Таны дотор байна" гэдэгт зөвхөн итгэж чадна* (Кол. 1:27)."[5]

Есүсийн захидлууд

"Есүс Өөрийн хүүхэд бүрээр дамжуулан захидал илгээдэг. Хэрэв та Христийн дагалдагч бол Тэр танаар дамжуулан таны амьдарч байгаа гэр, тосгон, гудамжныханд захидал илгээдэг. Есүс Өөрийг нь таниагүй байгаа хүн бүрийн зүрх сэтгэл рүү ярихыг оролдож, тэдний дотор оршин суухыг хүсдэг. Магадгүй тэд Библийг уншдаггүй эсвэл хуудсанаас нь ярьж

3 Элен Уайт, *Адвентист Гэр Бүл* (Hagerstown, MD: Ревью энд Хералд Хэвлэлийн холбоо 2002), х. 120.

4 Элен Уайт, *Тэвчээр,* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2004), х. 290, 291.

5 Элен Уайт, *Элч Нарын Үйлс,* х. 476.

буй дуу хоолойг сонсохгүй байж болох юм.

Тэд Бурханы хийж буй ажлаас хайрыг нь олж харж чаддаггүй байж болно. Гэхдээ хэрэв та Есүсийн жинхэнэ төлөөлөгч бол таниар дамжуулан Бурханы сайн сайхан байдлын тухай ойлголттой болж, Түүнийг хайрлан үйлчлэх боломжтой юм."[6]

Бурханы хайрын хувийн шинж чанар

Есүс Ариун Сүнсээр дамжуулан бидэнтэй хамт байхыг хүссэнээрээ бидэнд Бурханы агуу хайрын онцгой шинж чанарыг харуулдаг. Христ бидний дотор амьдардаг гэдгийг ойлгоход хэцүү байж болох юм. Гэхдээ Түүний үг үнэн гэдгийг баталдаг.

Нэгэн аав аялалд явж байхдаа Бурханы хайрын талаар хүүдээ ийнхүү тайлбарлахыг хүссэн байна. Аав нь ийн хэлжээ: "Энэ усан онгоцны уртыг ажигла, энэ бол Бурханы хайрын урт юм. Одоо харин зүүн ба баруун тийш хар - энэ бол Бурханы хайрын өргөн юм. Одоо тэнгэр рүү хар. Энэ бол Бурханы хайрын өндөр юм. Одоо энэ далайг хар. Далай их гүн байдаг. Энэ бол Бурханы хайрын гүн юм." Хүү нь энэ тайлбарыг хэсэг зуур эргэцүүлснээ: "Аавaa, тэгвэл үүний хамгийн гоё нь юу болохыг мэдэх үү? Бид энэ хайрын яг дунд нь байна" гэж хэлжээ.

Өдөр бүр амьдралаа Христийн төлөө зориулж, Ариун Сүнсээр дүүрэн байдаг хүн бүр Бурханы хайрын төвд байдаг. Бидэнд үүнээс илүү сайхан амьдрах газар гэж үгүй. Өглөө болгон би гайхамшигт Эцэгтээ хандан намайг энэ байрлалд байлгахын төлөө залбирдаг.

Эцсийн зорилго: Бялхам амьдрал

Элч Паул Ефес 3:19 дээр биднийг Есүсийн өгсөн хайрыг ойлгоосой, мөн энэ хайраар дамжуулан бид Бурханы бүрэн дүүрэн байдлаар дүүрдэг болохыг мэдүүлэхийг хүссэн. Эшлэлд: *"Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай"* гэж хэлжээ.

Христ бидний дотор байснаар ямар нөлөөтэй болохыг бид харж байна уу? Энэ бол Бурханы бүрэн дүүрнийг мэдрэх цорын ганц зам юм. Иохан 10:10 дээр Христ биднийг илүү бялхам амьдралтай болгохын тулд ирсэн гэж хэлсэн. Колоссай 2:9,10 дээр *"Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог. Түүн дотор та нар төгс болгогдсон. Тэр бол бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн нь мөн."* Та Бурханы бүрэн дүүрэн байдлыг мэдэрч байна уу? Бурхан үүнийг танд өгөхийг хүсч байна. Шаардлагатай алхмуудыг хийгээрэй!

---

6 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 115.

Бидний хүсэлтээс давсан хариултууд

Эзэн Ефес 3:20 дээр *"Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай"* гэсэн амлалтынхаа дагуу бидний залбиралд хариулаач хэмээн бид залбирч болно. Бидний гайхалтай Эзэн бидний залбиралд хариулаад зогсохгүй, бидний хүссэнээс, төсөөлөн хүлээж байснаас ч илүүг Өөрийн алдар, хүч, баялгийн дагуу бялхмаар ивээдэг хэмээх энэхүү амлалтыг барин залбирч болно. Түүнчлэн Бурхан бидний залбиралд хариулж, бидэнд гайхалтай агуу зүйлсүүдийг илчилж өгнө гэсэн Иеремиа 33:3-н дагуу залбирч болно: *"Намайг дууд, Би чамд хариулж, чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина."*

Есүсийн амьдрал надад хэрхэн нөлөөлдөг вэ?

"Харин та нар Түүнээс болж Христ Есүс дотор байгаа юм. Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон юм" (1 Кор. 1:30). Христ бидний мэргэн ухаан болсон. Бид Христтэй хамт байхдаа ухаалаг үйлдэл хийж чадна. *"Учир нь мэргэн ухаан нь бадмаараагаас ч илүү үнэтэй. Хүсэж болох ямар ч зүйлсийг түүнтэй зүйрлэхийн аргагүй"* (Сургаалт үгс 8:11). "Мэргэн ухаан тэнэг мулгуугаас давуутай нь гэрэл харанхуйгаас илүүтэйн адил болохыг би ойлгов" (Номлогчийн үгс 2:13). Христ бидний дотор байхгүй үед бид өөрсдийгөө маш ухаалаг байна гэж бодох боловч үнэндээ маш мунхаг байдаг. Адам, Ева хоёрыг санацгаая. Тэд маш ухаалаг байсан ч Бурханд итгэхийн оронд өөрсдийнхөөрөө шийдсэн нь маш мунхаг үйлдэл болдог. "Христ дотор" байх нь миний ухаалаг, мэргэн эсэхийг тодорхойлдог. *"Мэргэн ухаан нь нэг мэргэн хүнийг хотын арван захирагчаас илүү хүчтэй болгодог."*

Христ бидний зөвт байдал болдог. Хүн төрөлхтөн гэм нүгэлд унах үед алдагдсан зөвт байдлыг Түүгээр дамжуулан буцаан авах боломжтой болсон гэсэн үг. Ром 8:3,4 дээр: *"Тэр Өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв. Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно."* Энэ эшлэлд Сүнс дотор явж буй хүн Есүсээр дамжуулан зөвтгөгдсөн гэдгийг анхааралаарай. Деннис Смит: "Итгэлээр зөв шударга хүмүүс зөвтгөгдөж, ариусгагддаг. Зөвтгөл гэдэг нь Бурхан итгэгчийг нүгэл болон шийтгэлээс чөлөөлж, Христийн зөвт байдлаар гэмшсэн нүгэлтнийг (бүрэн дуулгавартай байдлаар) хувцасладаг гэсэн үг юм."[7]

7 Деннис Смит, *40 Өдөр:* Бурхантай харилцах харилцаагаа сэргээх мөргөл ба залбирал, ном 2, х. 18.

Христ миний гэм бурууг авч, Өөрийнхөө зөвт байдлыг надад өгсөн. Энэ солилцоогоор бид нүгэл үйлдээгүй мэт Эцэгийн өмнө зогсож чаддаг. *"Өрнө зүг дорно зүгээс хол байдаг шиг Тэр бидний алдаа зөрчлийг биднээс тийн холдуулсан"* (Дуулал 103:12). Бурханы нигүүлслээр бид гэм бурууг үй амьдралаар амьдарч чадна.

Христ биднийг ариусгасан. Ариусгал гэдэг нь юу гэсэн үг вэ? "Жинхэнэ ариусгал гэдэг нь төгс хайр, төгс дуулгавартай байдал, Бурханы хүслийг төгс дагах явдал юм."[8] Баяр хөөртэй, дуулгавартай амьдрахын тулд Христийн дотор оршихын ач холбогдлыг 4-р бүлэг буюу "Христийн дотор дуулгавартай байх нь" хэмээх сэдэв дотор илүү дэлгэрэнгүй авч үзэх болно. Христ биднийг аварсан, үүнийг өөрөөр хэлбэл бидний бүх гэм бурууг уучилсан, нүглийн боолчлолоос ангижруулсан, мөн Бурханы дэргэд мөнхийн амьдралаар амьдарч чадна гэсэн үг юм. Есүс Өөрийн золиослолоор төлөөсийг төлсөн билээ.

Африкт боолын наймааны хоригдлууд хүзүүгээрээ төмөр хүзүүвч зүүж, бусад хоригдлуудтай гинжээр холбогдсон байдаг байв. Эдгээр дорой хүмүүсийн зарим нь аврагддаг байсан. Төлөөсийг төлсөн тохиолдолд боол төмөр гинж болон хүзүүвчнээсээ чөлөөлөгддөг байлаа. Есүс бидний төлөөс болон золиослогдсон. Тэр бидний төлбөрийг хийсэн юм.

Есүсийн сэтгэлгээ бидний дотор алхам алхмаар бий болдог. Бид Филиппой 2:5-г нэхэмжлэн залбирах хэрэгтэй, "Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай." Бид Христийг өөрсдийн дотор орохыг зөвшөөрөх тэр мөчөөс л Христ Өөрийн санаа бодол болон үйлдлийг бидний дотор биежүүлж эхэлдэг. Дараа нь бид Түүний хайрладаг зүйлсийг хайрлаж, Түүний хүсдэггүй зүйлсээс хол байдаг.

Есүс надаар дамжуулан сайн үйлс хийдэг

Бурханы үгэнд ийн бичсэн байдаг Ефес 2:10: "Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ." Хэрэв бид "Христ дотор" байвал Бурхан таны төлөө болон миний төлөө сайн үйлсийг бэлдсэн байдаг, тийнхүү бид тэдгээрийг гүйцэлдүүлэх учиртай. Энэ үүргийг гүйцэтгэснээр Эзэн бидэнд ухаалаг замыг төлөвлөсөн байдаг. Түүний төлөө, мөн бусдын төлөө үйлчилсэнээр гурван зүйл тохионо:

1. Бусдын төлөө ажиллаж байгаа учраас өөрийнхөө би гэсэн үзлээ байнга эмчилж байдаг.
2. Бусад хүмүүс надаар дамжуулан ивээгддэг.
3. Эзэн надад буцаагаад маш их ивээлийг өгдөг.[9]

8 Элен Г. Уайт, *Элч Нарын Үйлс,* х. 565.

9 *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номын "Есүсийн сүнсээр дүүргэгдсэн

Бид сайн үйлс хийснээр итгэлээр өсөх болно. Бидний туршлага, оюуны болоод сүнслэг чадвар маань сайжирч, мөн бидний баяр баясгалан, хүч чадал нэмэгдэх болно, тийнхүү явцдаа бид Бурханы хаанчлалын төлөө ажиллаж байгаа юм. Энэ ажил үүрэг биднийг Бурханы хаанчлалд бэлтгэх болно.

Өөр нэг гайхалтай асуулт бол: Би хүний мөхөс хүч чадлаар Бурханы төлөө ажиллаж байна уу эсвэл бидний Эзэн бурханлаг чадвараараа надаар дамжуулан ажиллаж байна уу?[10]

Бурхан надад Түүний гэрч болох боломжийг олгодог

Есүс "Алдагдсаныг, аврахаар ирсэн" (Лук 19:10). Тэрээр хүмүүсийг надаар дамжуулан аврал руу хөтлөх болно. "Таны дотор амьдардаг Есүс Өөрийг нь танихгүй хүмүүсийн зүрх сэтгэл рүү ярихыг хүсдэг."[11] "Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно" (Үйлс 1: 8). Бид энэ сэдвийг 5-р бүлэг буюу "Есүсээс ирдэг сэтгэл татам итгэл" гэсэн хэсэг дээр хөндөх болно.

Бурхан биднийг «Ариун Сүнсээр залбирч» байхыг уриалдаг (Иуда 20). Христ Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор оршсон тэр үед бид Ариун Сүнсээр мөн Есүсийн нэр дээр залбирч чадна. Есүс: «Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ" (Иохан 14:13). Биднийг зөвхөн "Христийн нэрээр залбираад зогсохгүй Ариун Сүнсний удирдамжаар залбирах ёстой" гэдгийг тодорхой бичсэн байна.[12]

Есүсийн нэрээр залбирах гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь "Есүсийн нэрийг залбирлын эхлэл ба төгсгөлд дурдахаас илүү зүйл юм. **Энэ нь Бид Түүний амлалтад итгэж, ивээл нигүүлсэлд найдаж, Түүний төлөө ажиллах үедээ Есүсийн оюун ухаан болон сүнсээр залбирахыг хэлж байгаа юм.**"[13] Тиймээс, Христийн нэрээр залбирах нь дараах дөрвөн зүйлийг агуулдаг.

1. Есүсийн сүнсээр залбирна гэдэг нь Ариун Сүнсээр дүүрэн байх гэсэн үг юм.

хамтрагчид" сэдэв. (2019 он).

10 Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.steps-to-personal-revival.info сайтаас "Development" гэсэн хэсгээс харна уу.

11 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 115.

12 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 147.

13 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 100, 101.

2. Бид залбирч байхдаа Түүний амлалтад итгэж, Түүний амлалтыг нэхэмжлэх хэрэгтэй.
3. Бурхантай харилцан итгэлцсэн харилцаан дотор Түүний ивээл нигүүлсэлд итгэн найдах.
4. Түүний ажлыг хийх, жишээлбэл Түүний Сүнсээр дамжуулан бүх зүйлд дуулгавартай байх.

Бид Христ дотор үлдэх үед эдгээр бүх нөхцөл нь Түүний нигүүлслээр биелэгддэг. Тиймээс Есүсийн нэрээр залбирах нь Түүний хүчээр залбирах гэсэн үг юм. Тэр бидний залбиралд хариулна гэж амласан. Энэ нь Есүс Өөрийг нь дагасан хүмүүст маш их итгэл найдвар төрүүлж байгааг харуулж байна. Бид Христийн дотор байснаараа бүхий л амлалтуудаас давуу талыг хүртэж болно.[14] *"Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотор "За" гэдэг. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүгээр дамжуулан "Амен" гэдэг"* (2 Коринт 1:20). *"Өөрийнхөө алдар ба давуу чанараар биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний бурханлаг хүч бидэнд амь болоод сүсэглэлд хамаатай бүхнийг соёрхсон.* ***Эдгээрээр дамжуулан Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхсон. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарын хуваалцагч болох юм"*** (2 Петр1:3,4). Бурханы гайхалтай арга замыг анзаарна уу: Тэрээр аль хэдийн бидний амьдралд мөн бурханлаг амьдралын хэв маягт хэрэгтэй зүйлийг өгсөн билээ. Бид эдгээр бэлгүүдийг Христтэй дотно харилцаатай байснаар хүлээн авдаг. Эдгээр нь амлалтыг нэхэмжлэн залбирах, өөрөөр хэлбэл итгэлээр залбирахад бидэнд өгөгддөг зүйл юм. Ингэснээрээ бид бурханлаг байдлыг хүртэгчид болдог.

Нүглийн хүчнээс аврагдах нь

"Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь {амь өгдөг Ариун Сүнсний хүч} чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ" (Ром 8:1,2).

Христ Есүс дотор байгаа хүмүүст яагаад ял байхгүй гэж? Нэгдүгээрт, Христ миний нүглийн гэм бурууг Өөртөө үүрсэн. Хоёрдугаарт, Тэр бидний дотор байхад биднийг хүлсэн нүглийн гинж тасардаг; нүглийн хуулиас бид ангижирдаг гэсэн үг. Энэ нь бид огт нүгэлгүйд тооцогдох ч, бас нүгэл үйлдэж болдог гэсэн үг юм. Галат 5:16-д нүглийн хүчнээс чөлөөлөгдөх

14 Хэлмут Хаубэйл- *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* ном, Амлалтаар залбирах нь 5-р бүлгийн: бодит амьдралд хэрэгжүүлэх түлхүүр сэдвээс дэлгэрэнгүйг үзээрэй.

тухай чухал ач холбогдолтой зүйлийг бичсэн байдаг. "Харин Сүнсээр яв {Ариун Сүнсээр байнга дүүр} тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ."

Дараагийн эшлэлүүд болох Галат 5:17,18-р эшлэлүүдэд Ариун Сүнсээр амьдрахтай холбоотой болохыг тайлбарласан байдаг. Харин 19-21-р эшлэлүүдэд Ариун Сүнсээр амьдрахад бидний хийх шаардлагагүй болдог махан биеийн үйлсийг жагсаан бичжээ. Бидний дотор буй Христ биднийг гэм нүгэл болон унасан тэнгэр элч нарын хор хөнөөлөөс хамгаалдаг. 1 Иохан 5:18 дээр ийнхүү хэлжээ: *"Бурханаар төрсөн хэн боловч нүгэл үйлддэггүйг бид мэднэ. Харин Бурханаар төрсөн Тэрээр түүнийг хамгаалдаг бөгөөд муу нэгэн түүнд хүрэхгүй."* Христ муу ёрын зүйлд зай үлдээхгүйн тулд бидний зүрх сэтгэлийг Ариун Сүнсээр дүүргэдэг. Гэсэн хэдий ч *"Доторх хүн маань өдрөөс өдөрт шинэчлэгдэж байгаа"* (2 Кор 4:16) гэдгийг бид ойлгох хэрэгтэй.

Бидний дотор буй Христ биднийг нүгэл үйлдэхгүй байхыг уриалдаг

1 Иохан 3:6–9 дээрээс бид гэм нүгэлтэй холбоотой дараах чухал зүйлсийг уншдаг: *"Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй. Бяцхан хүүхдүүд ээ, та нарыг хэн ч бүү мэхлэг. Зөвийг үйлдэгч нэгэн нь Түүний зөвт байгаачлан зөвт байна. Нүгэл үйлддэг нэгэн нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн. Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ. Бурханаас төрөгч ямар ч хүн нүгэл үйлддэггүй. Учир нь Бурханы үр түүний дотор байгаа. Тэр хүн Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж чаддаггүй."*

Эртний Грек хэлний мэргэжилтнүүд энэхүү нүгэл үйлдэхтэй холбоотой үгсийг зуршил болсон гэм нүгэлтэй холбоотой гэдгийг хэлдэг. Грек эх хэл дээрээс нь үзвэл "Хүн үргэлж буюу дандаа гэм нүгэл үйлдэггүй, харин зуршлаараа үйлддэг (энэ нь заримдаа нүгэл үйлддэг) гэжээ. Бурханы хүүхдүүд болох бид зөв зүйлийг хийж, Бурханы зарлигуудыг дагадаг."[15] Энэ нь Христ бидний дотор буюу бидэнтэй хамт байхад нүгэлт зуршлаасаа ангижрах боломжтой гэсэн үг юм. "Христ бидний дотор" байх нь нүглээс ангижирч ялахад тусалдаг.

15 Werner E. Lange, Hrgb., Unser größtes Bedürfnis (Lüneburg: 2011), S. 31.

Бид нүгэл үйлдвэл эргээд "Махан биеийн" итгэгч болох уу?

Энэхүү гайхамшигтай өөрчлөлтөөр дамжуулан бид гэм нүгэлгүй байдалд хүрч чадахгүй гэдгийг ойлгоорой. Бид өөрсдийн сул дорой байдал, хөнгөн хуумгай эсвэл мунхаг байдлаасаа болж нүгэлд унаж болно. Хэрэв бид ийм нөхцөл байдалд орвол "Сүнслэгээр амьсгалах" хэрэгтэй. Энэ нь нүглээ хүлээн зөвшөөрч, Бурханы уучлалыг хүлээн авч, Ариун Сүнсээр дүүрэхийг дахин гуйх хэрэгтэй гэсэн үг юм. Бид "Сүнслэгээр амьсгалах" үедээ Сүнслэг итгэгч хэвээр үлдэх бөгөөд дахин махан биеийн итгэгч болохгүй. Нүгэл нь бидний Бурхантай харилцах сүнслэг харилцааг таслахгүй боловч, энэ нь бидэнд тулгарч буй бэрхшээл юм.

Хэрэв бид итгэлгүй байдалд зөвшөөрөл олгож "Сүнсээр амьсгалахаа" зогсоовол дахин махан биеийн итгэгч болно. Бидний нүгэлт чанар Христийн хоёр дахь ирэлт хүртэл бидэнтэй хамт байсаар байх болно. Бурханы сайн мэдээний элч нар дотроос өөрсдийгөө гэмгүй гэж хэлсэн хүн байхгүй билээ. Гэсэн хэдий ч "Бидний дотор байгаа Христ" бидний нүгэлтэй харьцах хандлагад эрс шийдэмгий өөрчлөлтийг бий болгодог.

Бодит үр дүн

Элч Иохан ийн бичжээ: *"Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн"* (1 Иохан 2:1). Бурхан биднийг Христ дотор гэмгүй амьдралаар амьдрахыг хүсдэг. Гэхдээ хэрэв бид нүгэл үйлдвэл Өмгөөлөгчөөсөө уучлал гуйж, уучлалыг хүлээн авч болно. Элен Уайт хэлэхдээ: "Нүглийг бурханлаг хүчээр бүрэн дүүрэн, өөрчлөгдөшгүй Бурханы гурвалын нэг болох Ариун Сүнсээр дамжуулан бид эсэргүүцэн, даван туулж чадна."[16] Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор амьдарч байгаа Христийн улмаас бидний дээр буй нүглийн хүч нурдаг ба бидний нүгэл үйлдэх байдал багасан цөөрдөг.

Сайн эрүүл мэнд

Бидний дотор байгаа Христ бидний эрүүл мэндэд санаа тавьдаг: *"Хайрт минь, сэтгэл тань амар тайван байгаагийн адил бүх зүйл тань сайн сайхан байж, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна"* (3 Иохан 2). *"Амар тайвны Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгаг. Сүнс, сэтгэл, бие тань бидний Эзэн Есүс Христийг ирэхэд бүрэн хамгаалагдсан бөгөөд гэм зэмгүй байх болтугай. Та нарыг Дуудагч нь итгэмжит бөгөөд Тэр мөн үүнийг биелүүлэх болно"* (1 Тес. 5:23, 24).

16 Элен Уайт, *Та Нар Хүчийг Авна,* 1-р сарын 5; х. 13.

Генетикийн доктор Сан Ли лекц өгч байхдаа Христтэй харилцах итгэлийн харилцааны ачаар бидний генүүд сайн ажиллаж, эрүүл мэндийн даавар ялгаруулдаг болохыг цохон тэмдэглэсэн байна. Итгэл ба эрүүл мэндийн хоорондын холбоо нь дэлхий ертөнцөд нэн шаардлагатай байгаа мэдээ юм. Энэ мэдээг зөвхөн Эзэнд өөрсдийгөө бүх зүйлээрээ даатгадаг, өдөр бүр Ариун Сүнсийг гуйдаг мөн эрүүл мэндийн зөвлөмжийн дагуу амьдардаг Есүсийн дагалдагчид түгээж чадна.

Профессор Гроссарт-Матичекийн удирдлаган дор гучин жилийн хугацаанд 35,000 хүн дээр хийгдсэн судалгаанаас үзэхэд эрүүл мэндэд хамгийн сайн нөлөө үзүүлдэг хүчин зүйл бол Бурхантай харилцах, хайрын харилцаа болохыг харуулжээ. Энэ харилцаа байгаа үед эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн гэх мэт эрүүл мэндийн бусад хүчин зүйлсийн нөлөө хэд дахин илүү байдаг байна.[17] Энэ нь Библийн дараах эшлэлийн утгыг тодорхой харуулж байна. "Учир нь биеийн дасгал нь өчүүхэн тус болох юм. Харин одоогийн болон ирэх амийн төлөөх амлалт бүхий сүсэглэл нь бүх зүйлд тустай" (1 Тимот 4:8).

Деннис Смит нь *"40 өдөр"* цуврал номын 3 дахь номондоо "Бурханы сүүлчийн өдрийн хүмүүст зориулсан эрүүл мэндийн зарчим" гэсэн хэсэгт эрүүл мэндийн талаарх бидний сайн мэддэг ойлголтоос эрс өөр талыг харуулсан байдаг. Тэрээр Ариун Сүнсний хүч хэрхэн амьдралын хэв маягийг өөрчлөхөд нөлөөлж, ажилладаг талаар хуваалцсан билээ. Тиймээс сүнслэг эрүүл мэнд чухал ач холбогдолтой юм.

Смит: «40 өдрийн мөргөлийн ном нь Бурханы бидэнд мэдрүүлэхийг хүсдэг бие бялдар, сэтгэл зүй, оюун санааны бүрэн шинэчлэлтийг авахын тулд Бурхантай хэрхэн хамтарч ажиллахыг харуулах болно» гэжээ.[18]

Нэгэн бизнесмен ийнхүү бичжээ: "Би өдөр бүр Ариун Сүнсээр дүүрэн байснаар эрүүл мэндийн мэдээг хүлээн авсан. Үүнээс өмнө эрүүл мэндийн нэг ч семинар надад огт нөлөөлдөггүй байв. Би маханд маш их дуртай байсан ба ямар төрлийн мах идэж байгаадаа төдийлөн анхаарал тавьдаггүй байв. Түүнчлэн би кофе, хар цай уудаг байсан ба түүнийгээ асуудал гэж бодохгүй байлаа. Хааяа бас би пиво уудаг байв. Тэгээд 2009 оноос хойш би Ариун Сүнсээр дүүрэн байхын тулд өдөр бүр залбирч эхэлсэн юм. Ариун Сүнс намайг мах, кофе, хар цай, шар айраг хэрэглэхээс татгалзахыг ятгасан билээ. Би ч цагаан хоолтон болж чадлаа.

17 *Шинэ Гараа* эрүүл мэндийн номноос мөн Др. Хайде (Лейпциг:, 2014), х. 333, 334.

18 Деннис Смит, *40 Өдөр:* Бурханы сүүлчийн өдрийн хүмүүст зориулсан эрүүл мэндийн зарчим, (Hagerstown, MD: Review and Herald Publishing Association, 2012), 1 дэх өдөр.

Ариун Сүнстэй байх нь бүх зүйлд, тэр дундаа тэвчээр, амьдралын хэв маягт ялалтын үндэс суурь болдог гэдгийг би ойлгосон юм."[19]

Нэгэн эмэгтэйн сэтгэгдэл: "Бүрэн бууж өгснөөр миний амьдрал өөрчлөгдсөн." (бид зөвхөн эрүүл мэндийн хэсгийг нь хуваалцъя): "Би өдөр бүр Ариун Сүнсийг миний зүрх сэтгэлд ажиллаж, амьдрахыг урьдаг байв. Тэгээд би байнга идэхээ больсон. Миний хувьд үүнийг өөрийн хүчээр хийх боломжгүй байлаа. Тийнхүү би өдөр тутмын хэрэгцээ шаардлагаа илүү тайвнаар хангаж сурсан тул стресс миний ходоодыг зангируулахаа больсон. Бурхан надад кофе уухаа болих хүчийг өгсөн юм. Өмнө нь энэ талаар бодож ч чаддаггүй байв. Учир нь кофеноос гарах гэж оролдох үед миний толгой таван өдрийн турш аймшигтай өвддөг байсан ба шинж тэмдгийг нь зогсоож болдоггүй байлаа. Энэ бол хүнд хэлбэрийн шинж тэмдэг билээ. Харин энэ удаад би үр дагаврын талаар бодсонгүй. Би зөвхөн дахин кофе уумааргүй байгаагаа л санаж байна. Өнөөдөр надад кофе уух хүсэл огт байхгүй. Би бас махан хоолны тал дээр ижилхэн асуудалтай байсан. Манай гэр бүлийнхэн болоод миний хувьд махнаас татгалзах хүсэл огт байдаггүй байв. Харин өнөөдөр миний хувьд энэ нь амархан болсон бөгөөд надад мах идэх хүсэл огт байхгүй болсон.[20]

Эрүүл мэндийн тэргүүлэх мэргэжилтэн ингэж хэлжээ: "Өнөө үеийн жинхэнэ хэрэгцээ бол зөвхөн эрүүл мэндийн боловсрол биш юм. Бидэнд маш сайн эрүүл мэндийн мэдээлэл бий. Шаардлагатай зүйл гэвэл энэхүү эрүүл мэндийн мэдээгээ бодит амьдралд хэрэгжүүлэх холбоос юм. Энэ бол өөрчлөх хүч."[21]

Сайн мэдээ бидэнд Ариун Сүнсээр дамжин бидний дотор буй Христийн улмаас өөрчлөгдөх хүчийг өгдөг.

Хадсон Тейлорын агуу өөрчлөлт

Хадсон Тейлор Хятадад сайн мэдээ түгээгчээр үйлчилж байх үедээ сайн мэдээний ажилтан МакКартигаас захидал хүлээн авчээ. Бурхан энэ захидлыг ашиглан хэрхэн бид Христийн дотор мөн Христ бидний дотор оршин байх тухай гайхалтай үнэнийг ойлгоход нь тусалж, түүний

19 2013 оны 3-р сарын 3-наас 3-р сарын 21-ний хооронд нэгэн бизнес эрхлэгчээс ирсэн имэйлийг богиносгон оруулаа.

20 Гэрчлэлийг бүтнээр нь www.missionsbrief.de - сайтаас Герман хэл дээр уншаарай- Missionsbrief Nr. 42, S. 17, Vцllige HIngabe vergnderte mein Leben.

21 Дон Макинтош, АНУ-ын Веймарийн Ньюстарт Глобал захирал, Weimar, USA, in D'Sozo, (Remnant USA), Foreword.

нүдийг нээжээ. Энэ захидлаар Христ болон итгэгчдийн хооронд байдаг эв нэгдлийн нууцын талаарх үнэнийг илчилсэн юм. Энэ өдрөөс хойш Тейлорын Бурхантай алхах зам нь амар тайван, ялалтын зам болсон. Найзууд нь түүний энэ гайхалтай өөрчлөлтийг анзаарсан байдаг. Бурхан амьдралд нь юу хийснийг гэрчлэхийн тулд Тейлор хэрхэн шинэ замаар, шинэ хүн болж, шинэ ертөнцөд алхсаныг найзууд нь гэрчилдэг.

Тейлор Англид байгаа эгчдээ захидал бичсэн байдаг. Тэрээр өөрийн олж мэдсэн энэхүү гайхамшигтай үнэн болон Бурханыг мэдэрсэн гайхалтай мэдрэмжээ захидалдаа тайлбарлахыг хичээсэн юм. Тэрээр: "Миний ажил урьд өмнө хэзээ ч ийм өргөн цар хүрээтэй, хариуцлагатай мөн одооных шиг ийм хэцүү байгаагүй, гэхдээ би одоо дарамт бэрхшээлийг мэдрэхгүй байна. Өнгөрсөн сар миний хувьд амьдралын хамгийн аз жаргалтай мөч байсан байх. Эзэн миний төлөө юу хийсэн талаар бага зэрэг ярихыг хүсч байна. Би үүнийг тодорхой тайлбарлаж чадах эсэхээ мэдэхгүй байна. Учир нь үнэндээ цоо шинэ, хачин сонин эсвэл гайхамшигтай зүйл огт байдаггүй ч надад бүх зүйл шинэ мэт болсон юм! Товчхондоо: "Би харалган байсан ба одоо харж байна!" Маш дарамттай хэцүү байхад Бурхан МакКартигийн захидалд бичсэн нэгэн өгүүлбэрийг ашиглан миний нүдийг бүрхсэн бүрхүүлийг унагаасан билээ. Бурханы Сүнс надад Есүстэй нэгдмэл байх тал дээр урьд өмнө хэзээ ч мэдэрч байгаагүй тийм үнэнийг илчилсэн юм."

Тейлор захидалдаа Тэр бол усан үзмийн мод, итгэгчид бол мөчир юм гэсэн Христийн үгийг хэрхэн ойлгосноо тайлбарлав: Тэрээр: "Өө, энэ үнэнийг мэдэх нь ямар их баяр хөөр вэ! Хэрэв хүн аль хэсэг нь илүү амттай вэ гэж асуувал, (бүрэн ойлголцол ба бууж өгснөөр) Христтэй нэг болох цаашдын байдал юм. Би үүнийг мэдэрснээс хойш ямар ч зүйлд санаа зовохоо больсон. Учир нь Тэр Өөрийн хүслийг биелүүлэх чадвартай бөгөөд Түүний хүсэл бол миний хүсэл юм. Миний хаана, ямар байдалтай байх нь хамаагүй. Миний бодож байгаа биш Түүний бодож байгаа нь чухал юм. Учир нь хамгийн амархан газар ч Тэр надад ивээлээ өгнө, хамгийн хэцүү газар байсан ч Түүний ивээл надад хангалттай."

Тейлорт тохиолдсон явдлын талаар Деннис Смит дараах зүйлийг хэлжээ: "Хадсон Тейлор Бурхантай хамт явах замдаа ялалтын нууцыг олсон. Тэрээр Христийн төлөө үйлчлэхдээ бүх нөхцөл байдалд хэрхэн амар тайван байж болохыг олж мэдсэн юм. Бурхан хүүхдүүддээ энэхүү ялалт, амар тайвныг санал болгодог. Та ийм ялалт, амар амгаланг хүсч байна уу? Гагцхүү Христийн доторх энэхүү амар тайван болоод ялалтыг хүн болгон олж мэдрээсэй гэж би залбирч байна.[22]

22 Деннис Смит, *Сүнсний Баптисм ба Христ Дотор Байх нь,* х. 10, 11. Цааш нь уншихыг зөвлөж байна: Деннис Смит, *40 Өдөр:* Хоёр дахь ирэлтэд бэлтгэх залбирал ба мөргөл (Hagerstown, MD: Review and Herald Publishing Asso-

Би энэ уриалгад нэгдэж байна. Мөн Ариун Сүнсээр дамжуулан Христийн дотор байгаа бүх хүнд Ариун Сүнсний ер бусын хүчээр Христийн дотор элбэг дэлбэг, үр бүтээлтэй амьдралаар амьдрахыг хүсч байна. "Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй" (Иохан 15:5).

Есүс Өөрийнхөө талаар ийнхүү хэлсэн байдаг: "Харин Миний дотор оршигч Эцэг Өөрийнхөө ажлуудыг хийж байгаа юм" (Иохан 14:10). Тэгвэл Есүс таныг болон намайг ийнхүү хэлээсэй гэж маш их хүсдэг, "Миний дотор оршигч Есүс Христ Өөрийн ажлыг хийдэг." "Христ бидний зүрх сэтгэлд, Христ бидний амьдралд байна гэдэг бол аюулгүй байдал юм."[23]

Залбирал: "Эзэн Есүсээ, Та миний амьдралд орохыг хүсэж байгаад би маш их баярлаж байна. Би амьдралаа Танд өгөх үед, Та намайг Ариун Сүнсээр дүүргэдэг. Бурханы нигүүлслээр Та миний хувьд мэргэн ухаан, зөвт байдал, ариусал, аврал болсон учраас би Танд магтаал, талархлыг өргөхийг хүсч байна (1 Кор. 1:30). Ариун Сүнсээр дамжуулан Тантай харилцах харилцаанаасаа баяр хөөрийг мэдэрч, өсөн дэвжихэд минь туслаач. Амен."

ciation, 2009)), ялангуяа 4 дэх өдрийн уншлага буюу: "Христ таны дотор" сэдэв, х. 18. Мөн номын 4-р бүлэг болох Сүнсний баптисм ба Христ дотор байх нь, х. 81–102.

23 Элен Г. Уайт, *Анагаахуйн Үйлчлэл,* х. 511.

Бурхан биднийг Ариун Сүнсээр дүүрэхийг хүсээсэй хэмээн хүлээж байдаг.

"Бурханы хүч өөрийг нь шаардаж, хүлээн аваасай хэмээн биднээс хүсч байдаг. Энэхүү итгэлээр нэхэмжлэгдэж амлагдсан ивээл нь Өөртэйгөө хамт өөр бусад бэлгүүдийг авчирдаг. Энэ нь алдрын баялгийн дагуу өгөгдсөн юм." Ye Yеийн Хүслэн, 672.1 #13

Хосууд болон Ариун Сүнс

Гэрлэсэн хос мэт ойр дотно байдал

Нөхөр бид хоёр *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номыг уншаад маш ихээр ивээгдсэн. Бид одоо энэ номыг гурав дахь удаагаа хамтдаа уншиж байна. Энэ ном бидний амьдралыг Бурханы үгтэй ойртуулж, амьдралын хэцүү асуудалд маань шийдлийг харуулдаг. Хамтдаа уншиж, залбирсан нь биднийг ойр дотно, өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй нэгдмэл байдал уруу хөтөлсөн. Хамтдаа нэг баг байх нь үнэхээр гайхалтай зүйл шүү. Бусдын төлөө ажиллаж, залбирч, заан сургаж, үйлчлэх нь гайхалтай баяр хөөр юм. #119

Гайхалтай үйл явдлууд

40 өдрийн ном бидэнд гайхалтай мэдрэмжийг өгсөн. Юунаас ч илүү сэргэлт болсон. Бид хоёр өглөөд хамдтаа судалж, санаа бодлоо хуваалцсанаар хоёулаа сүнслэгээр өсөж улам илүү дотно болсон. Хамтдаа залбирсны дараа бид өдөр бүр энгийн зүйлд ч хүртэл Бурханы удирдамжийг мэдэрдэг болов. Бид өдөр бүр ямар их хүч чадлыг хүлээн авч буйгаа хэмжишгүй юм. #3

Гэрлэлтийн амьдралтайгаа тэмцэлдсэн минь

Намайг *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номыг унших үед Бурхан миний сүнслэг нүдийг нээж өгсөнд би талархдаг. Би одоо өмнөх шигээ итгэгч байхаа больсон. Адвентист хүний хувьд би Христэд итгэгчийн амьдралыг мэдэрсэн хүн гэж боддог байсан боловч, сэтгэлийн гүндээ ямар нэгэн юм дутагдаад байгааг ухаарсан юм. Би гэр бүлийн амьдралдаа нөхөртэйгөө (сүмийн гишүүн) сайхан харилцаатай байх гэж их тэмцсэн. Харин одоо бид хамтдаа залбирч бие биенийгээ сүмд явахад нь урамшуулан дэмждэг болсон. #120

Энэ ном бас хосуудад тусалдаг

Би Адвентист номын дэлгүүрт орлоо. Надад *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номыг санал болгов. Би авахыг хүссэнгүй. Тэгсэн чинь худалдагч эмэгтэй надад авахыг дахин санал болгож, "Энэ ном бас хосуудад ч тус болдог шүү. Миний үеэл нөхрөөсөө салсан боловч, энэ номын ачаар тэр хоёр буцаад нийлсэн юм. Одоо тэд хамтдаа залбирч, хамтдаа сүмд явж байгаа" гэж хэлэв. Тэгэхээр нь би номыг худалдаж авсан ба надад ч гэсэн нандин эрдэнэс мэт сэтгэгдлийг төрүүлсэн. #120a

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Христтэй нэгдмэл байснаар ямар олон үр дүн гардаг вэ?*

   _____

2. *Есүсийн Сүнсээр залбирна гэдэг нь юу гэсэн үг вэ?*

   _____

3. *Нүглийн талаар Христ бидэнд юу хийж өгсөн бэ?*

   _____

4. *Христийн улмаас бид нүгэлгүй болж чадах уу?*

   _____

5. *Итгэл болон эрүүл мэндийн хооронд ямар холбоо байдаг вэ?*

   _____

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Христ бидний дотор байснаар өдөр бүрийн амьдралд минь харагдахуйц тодорхой үр дүн гарахын төлөө*
  2. *Есүсийн Сүнсээр залбирах чадвар болон ойлголтын төлөө*
  3. *Нүгэлт зуршлаа ялж, чөлөөлөгдөх мэдрэмжийн төлөө*
  4. *Биднийг сүнслэг бардамналаас хамгаалахын төлөө*

ЕСҮСЭЭС ИРДЭГ ДУУЛГАВАРТАЙ БАЙДАЛ

Би хэрхэн баяр хөөртэй дуулгавартай байдалд амьдрах вэ?
Яагаад баяр хөөр байдаг вэ?
Дуулгавартай байдал яагаад надад тустай гэж?
Дуулгавартай байдал нь миний доторх Есүсээр дамжуулан хэрхэн ажилладаг вэ?
Итгэлийн дуулгавартай байдал нь Бурхан хүн хоёрын хамтын ажиллагаа юу?
Бурхан юу хийдэг вэ? Хүн юу хийдэг вэ?

Библи болон галт тэрэгний цагийн хуваарь

Германы Франкфурт дахь чуулганы үеэр теологийн оюутнууд Хятадад ажиллаж байсан нас дээр гарсан сайн мэдээ түгээгч Хадсон Тейлороос "Та яаж Библийн үг бүрт итгэдэг вэ?" хэмээн асуужээ.

Тэрээр ийнхүү хариулав: "Хэрэв та маргааш гэр лүүгээ явахыг хүсвэл галт тэрэгний цагийн хуваариас явах цагаа харна. Хэрэв та галт тэрэг 7 цагаас явахыг мэдсэн бол өөр асуулт асуулгүй тухайн өдөр нь галт тэрэгний буудал дээр очиж явах галт тэргэндээ сууна. Та галт тэрэгний цагийн хуваарийг ашигласан шиг би өнгөрсөн 50 жилийн турш Библийн амлалтууд болон тушаалуудыг яг тийнхүү ашигласан билээ. Би урт удаан амьдралынхаа туршид мөн зуу зуун үхлийн аймшигтай тулгарч байхдаа тэдгээр заавар тушаалууд үнэн болохыг өөрийн биеэр мэдэрсэн юм. Жишээ нь Библид *"Гагцхүү Бурханы хаанчлал болон зөвт байдлыг хайгтун тэгвэл энэ бүхэн та нарт нэмэгдэх болно"* (Матай 6:33) гэж хэлсэн байдаг. Би энэ чиглүүлгийг дагаснаар ямар ч ноцтой нөхцөл байдалд хэзээ ч урам хугарч байгаагүй. Хэрэв та ийн үйлдвээс адил зүйлийг мэдрэх болно."[1]

1 Профессор Др. Карл Хэймийн мөргөлийн материал, одоогоор надад энэ материал байхгүй байна.

Христээс ирдэг дуулгавартай байдлыг бодож тунгаах нь агуу баяр хөөрийг авчрах болно. Бид одоо үүнийг хийх хэрэгтэй. Энэхүү дуулгавартай байдалд онцгой нэр бий: итгэлийн дуулгавартай байдал.

Бурхан юуны төлөө сайн мэдээний үйлчлэгчдийг дууддаг вэ?

Сайн мэдээний үйлчлэгчийн хувьд би Ром 1:5 дээрээс надад хэрэгтэй маш чухал зааврыг олсон: *"Бид Түүний нэрийн төлөө бүх харь үндэстний дунд итгэлийн дуулгавартай байдлыг бий болгохын тулд Түүгээр дамжуулан нигүүлсэл болон элчийн үүргийг хүлээн авсан билээ."*

Энэ нь Бурхан бусад хүмүүсийг итгэлийн дуулгавартай байдалд чиглүүлэхийн тулд хүмүүсийг Өөрийн үйлчлэлдээ дууддаг гэсэн үг. Энэ нь надаас дуулгавартай байдлыг илүү сайн ойлгож, Бурханы тусламжтайгаар бусдад үлгэр жишээ болохыг шаарддаг. Би тийнхүү үйлдэх нь Бурханы нэрээр үйлдэж байгаа бөгөөд Есүс Христийн эрх мэдэлд байна гэсэн үг.

Итгэлийн дуулгавартай байдал хэрхэн бий болдог вэ?

Бурхан биднийг итгэлийн дуулгавартай байдалд хүргэхийг хүсдэг тухай Ром номын төгсгөлийн хэсэгт ингэж бичсэн байна: *"Бурхан миний сайн мэдээг болон Есүс Христийг тунхагласнаар дамжуулан өнө эртний турш нууцлагдаж байсан нууцыг илчилж та нарыг бат бэх болгоно. Тэр нууц нь эдүгээ илэрхий болж мөнх Бурханы тушаалын дагуу эш үзүүлэгчдийн Судруудаар дамжин бүх үндэстэнд мэдэгдэн, тэд итгэж, дуулгавартай дагах болсон. Цорын ганц мэргэн Бурханд, Есүс Христээр алдар нь үүрд мөнх байх болтугай. Амен"* (Ром 16:25–27).

Энэ эшлэлд итгэлийн дуулгавартай байдлыг өсгөх тодорхой зорилгын төлөө нууц илчлэгдсэн хэмээн тайлбарлаж байна. Энд тэр нууц юу болохыг бичээгүй байна. Гэхдээ бид Колоссай 1:27 дээрээс нууцын тухай тайлбарыг олж болно: *"Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн."*

Тэр нууц бол: Бидний доторх Христ юм. Христийн дотор итгэлийн дуулгавартай байдалд хүрэхэд ямар үр нөлөө гардаг вэ? *"Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна"* (2 Коринт 5:17). Бидний дотор Христ байснаар бид шинэ амьдралтай болдог. Өөр нэгэн эшлэлд энэхүү шинэ амьдралыг дүрсэлсэн байдаг: *"Та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай"* (Ефес 3:19).

Итгэлийн дуулгавартай амьдралыг бид хэрхэн ойлгох вэ?

Бидний хандлага Түүний хуулийн дагуу өөрчлөгддөг. *"Түүний тушаалууд нь хүнд дарамт биш билээ"* (1 Иохан 5:3). *"Миний буулга хөнгөн"* (Матай 11:30) гэж Есүс хэлсэн. *"Би өөрийн хайрладаг Таны тушаалуудад баясах болно"* (Дуулал 119:47). Учир нь тэд *"Таны амнаас гарсан хууль надад мянга мянган алт мөнгөнөөс ч хавьгүй илүү юм"* (эшлэл 72). *"Таны үг амтлахад минь ямар чихэрлэг вэ! Миний аманд зөгийн балаас ч илүү чихэрлэг!"* (эшлэл 103). Мөн *"Их олз олсон хүн шиг би Таны үгэнд баясдаг"* (эшлэл 162). *"Амар амгалан"* өгдөг (эшлэл 165). Итгэлийн дуулгавартай байдал гэдэг бол үнэхээр тааламжтай зүйл юм.

Бидний амьдралд бат бөх суурь хэрэгтэй

Германы нэгэн яруу найрагч Матиас Клаудиус ингэж бичжээ: "Хүнд өөрөө түүнээс хамаардаггүй харин түүнээс өөрөө хамаардаг ямар нэгэн бат бөх тулгуур хэрэгтэй байдаг."[2] Өнөө үед олон хүн итгэлтэй байдал дутагдсанаас болж бат бөх тулгуургүй байдаг учраас сэтгэл зүйн эмгэгтэй зовж амьдардаг. Харин Бурхан бидэнд дотно харилцаагаараа дамжуулан Үгэнд нь суурилсан бат бөх сууриа өгөхийг хүсч байдаг.

Энэхүү Христэд итгэгч яруу найрагч маань бидний амьдралд бат бөх суурь, найдвартай жишиг хэрэгтэйг харуулж байна. Хаанаас бид энэ суурийг олж болох вэ? Бурхан энэ суурийг маш эрт тавьсан билээ. Түүний нэр бол Есүс Христ. *"Учир нь тавигдсан ганц суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй"* (1 Коринт 3:11). Есүс бол бидний амьдралд тэрхүү бат бөх суурийг тавьж чадах Нэгэн билээ.

Амьдралдаа тавих хамгийн сайн жишгийг бид хаанаас олж болох вэ?

Жишгийг тогтоох нэгэн хэн бэ? Зөвийг тодорхойлон тогтоох нэгэн хэн бэ? Энэ тал дээр Библи бидэнд тодорхой хариултыг өгдөг. *"Та юу зөв болохыг тодорхойлдог"* Дуулал 99:4. *"Түүний мутрын үйлс бол үнэн ба шударга ёс юм. Түүний бүх тогтоолууд баттай юм. Тэд мөнхийн мөнхөд бат тогтоогдсон"* Дуулал 111:7,8. (мөн Дуулал 148:6).

Бүтээгч Бурхан юу зөв болохыг тодорхойлсон. Бурханаас өөр хэн ч дүрэм журам, жишгийг тогтоох эрхгүй билээ. Зөвхөн Бүтээгч Бурхан, бүхнийг Эзэмшигч Түүнд энэ эрх мэдэл бий. Өөр хэн ч бүхнийг тодорхой мэдэхгүй. Харин Бурхан ганцаараа бүхнийг мэдэгч-бүхнээс мэргэн юм.

---

2 Матиас Клаудиус (Edition Steinkopf, 1982), S. 10.

Жишгийг тогтоогч Нэгэний зан чанар маш чухал билээ. Библи бидэнд Бурхан бол хайр гэдэг. Тэрээр хайр, үнэн, баяр хөөр мөн шударга байдлын эх сурвалж юм. Гайхалтай зан чанар, хязгааргүй чадвар, бүхнийг мэдэгч зан байдлынхаа улмаас Бурхан тэнгэр элчүүдэд, орчлон ертөнцөд, хүн төрөлхтөн болон ан амьтдад дүрэм журмыг тогтоож өгсөн. Хайрын Бурхан маань амьдрахад хамгийн тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлэн бүтээсэн юм.

Бурхан зөвхөн дэлхийн оршин тогтнол, нар сарны хоорондын зай, дэлхийн тэнхлэгийн хөдөлгөөн гэх мэт байгаль дэлхийн зүй тогтлыг бүтээхээс гадна Тэрээр бас хүн төрөлхтнийг аз жаргалтай байлгах ёс суртахууны хуулийг бүтээсэн билээ.

Бидний хайрын Бурхан бидэнд гайхалтай дүрэм журам тогтоож өгсөн. Бид төгсгөлийн цаг үед хачин жигтэй үзэгдлүүд тохиоход, мөн Бурханы хуулинд дуулгавартай байх тал дээр агуу эргэлзээ бий болоход энэхүү бодлыг оюун ухаандаа хадгалахыг хүсдэг.

Бурханы зарчимд дуулгавартай байхад эргэлзэх

Паул ийн хэлжээ: *"Хэрэв бидний сайн мэдээ нууцлагдсан бол энэ нь мөхөж буй хүмүүсийн хувьд нууцлагдсан хэрэг. Энэ үеийн бурхан үл итгэгчдийн бодол санааг сохолсон учраас тэд Бурханы дүр болох Христийн алдрын сайн мэдээний гэрлийг үзэж чадахгүй болжээ"* 2 Коринт 4:3,4.

Сатан сохолдог бас далдлан нуудаг. Харалган оюун ухаан хоёр зүйлийг илтгэдэг: Нэгдүгээрт зарим зүйлсийг огт хардаггүй. Тэр зүйл нь хувирч өөрчлөгдсөн эсвэл нуугдсан байдаг. Хоёрдугаарт оюун бодол нь илбэдүүлсэн мэт тухайн зүйлийг зөв биш буруу талаас нь хардаг. Бидэнд эдгээрийг ямар ихээр тулгадаг болохыг бид ухаардаг ч үгүй билээ. Энэхүү харалган болгох, далдлан хувиргах байдал нь зөв өнцгөөс харахад садаа болдог.

Энэ нь итгэгч бус хүмүүст тохиодог гэж эшлэлд хэлсэн байна. Гэхдээ энэ нь махан биеийн итгэгчдэд бас тохиодог болохыг бид олж илрүүлсэн нь гайхмаар юм. Тэд Есүст итгэдэг дүр үзүүлэх боловч өөрсдийгөө Түүнд бүрэн буулгаж өгөөгүй байдаг. Тийм учраас "Энэ дэлхийн бурхан" тэднийг сохолдог байна.

Сатан энэхүү харалган болгох ажлаа сүнслэг Христэд итгэгчдэд хүртэл хийхийг оролддог гэдэгт би итгэж байна. Есүс Матай 24:24-д ийн хэлсэн: *"Хэрэв боломжтой бол тэд сонгогчдыг хүртэл төөрөлдүүлнэ"* мөн 1 Иохан 5:18 дээр ийн хэлжээ: *"Бурханаар төрсөн хэн боловч ... ёрын муу нэгэн тэдэнд хүрэхгүй."* "Сатан зөвхөн дэлхийг боолчлоогүй ба түүний худал

хуурмагууд Эзэн Есүс Христийн үнэн сүмүүдэд хүртэл нөлөөлж байна."[3] Есүс Лаодикчуудад бичсэн захидалдаа (Илчлэлт 3:17) энэхүү үзэгдлийн талаар тодорхой дүрсэлсэн байдаг.

Дэлхийн төгсгөлийн үйл явдлуудын талаар Матай 24, 25-р бүлэгт ярихдаа Есүс төгсгөлийн үеийн тэмдэг болох хууралт гэдэг үгийг дөрвөн удаа дурдсан байдаг. Хууран мэхлэлт аль хэдийн хүчтэй байгаа. Гэхдээ энэ нь улам ихээр өсөх болно. Харалган болсон хүмүүс үүнийг харахад маш хэцүү байх болно. Хүн бүр өөрсдийгөө шалгаасай гэж би бодож байна. Зөвхөн Ариун Сүнс худал үнэнийг ялгахад бидний нүдийг нээж өгч чадна гэдгийг бид ухаарах хэрэгтэй. Агуу хууран мэхлэлтийн бас нэг хэсэг нь Бурханы хүсэл, Бурханы үг, Бурханы хуулинд дуулгавартай байхтай холбоотой.

Олон хүн Бурхан ямар дуулгавартай байдлыг хүсдэг мөн хэрхэн дуулгавартай байх талаар тодорхой мэддэггүй. Энэ бол итгэлийн дуулгавартай байдал бөгөөд энэ нь ихэд онцгой дуулгавартай байдал юм.

Итгэлийн дуулгавартай байдал гэж юу вэ?

Бидэнд энэ ойлголтыг тодорхойлох гэсэн элч Паулын хэд хэдэн хувилбар байдаг. Энэ нь Бурханы авралын төлөвлөгөөтэй дагалддаг дуулгавартай байдал гэдэг нь тодорхой. Энэ бол Ариун Сүнсээр дамжуулан Есүс Христтэй жинхэнэ итгэлийн харилцаанд орох тухай асуудал билээ. Тэгээд үр дүн нь Христийн золиослолоор ирэх миний аврал юм. Христэд бууж өгнө гэдэг нь бас Ариун Сүнсний хүчээр хуулиудыг сахихыг хэлдэг. Энэ бол миний өөрийн хүчин чармайлтаар ирдэг дуулгавартай байдал биш юм.

Паул Бурханы хуулийг яг таг сахиж байж тэнгэрийн хаанчлалд орно гэсэн Фарисайчуудын дуулгавартай байдлын эсрэг хатуу зогсдог. Харин энэ дуулгавартай байдал бол Фарисайчуудынхаас эрс ялгаатай бөгөөд жинхэнэ дагалдагчийн харилцаанд байдаг гэдгийг тэр тодорхой илэрхийлдэг. Энэ дуулгавартай байдал Есүс Христээс ирдэг авралыг баяр хөөртэйгөөр хүлээн авахаас эхэлнэ. Мөн Есүсийн дагалдагч гэдэг утгаараа тухайн хүн амьдралдаа дуулгавартай үйлдлүүдийг гаргадаг билээ.

Энэхүү дуулгавартай байдал нь зүрх сэтгэлээс гардаг итгэлцэл дээр тогтдог. Деннис Смит ийн хэлжээ: "Аливаа хүн Ариун Сүнсээр дамжуулан Бурхантай дотно харилцаатай байгаа бол дуулгавартай байдал зүрх сэтгэлээс нь хүчилж биш аяндаа л урсан гардаг."[4] Энэ бол хүн ба Бурханы хамтын ажиллагааны үр дүнд бий болдог дуулгавартай байдал юм.

---

3 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* хс. 414.

4 Деннис Смит, *40 өдөр:* Дахин ирэлтэд бэлтгэх мөргөл болон залбирал х. 21, 22.

Бурхан нууцыг илчилсэн

Ром 16:25,27-р эшлэлийг дүгнэвэл: Бурханы мөнхийн хууль тушаалаар итгэлийн дуулгавартай байдлыг тогтоох нууц илчлэгдсэн. Бурханы тушаалын дагуу бидний дотор орших Христийн нууц нь биднийг итгэлийн дуулгавартай байдалд хүргэдэг. Итгэлийн дуулгавартай байдал нь хайр, итгэл, найдвар дээр суурилсан сайн дурын дуулгавартай байдал юм. Бид Бурхантай итгэлцлийн харилцааг тогтоосон ба энэхүү итгэлцэл дээр суурилан, мөн Түүний хуулиуд бидний сайн сайхны төлөө байдгийг ойлгосны үндсэн дээр бид дуулгавартай байхаар шийддэг.

"Зөвхөн итгэл биднийг Христийн нигүүлслийг хуваалцагчид болгодог ба дуулгавартай байдлыг харуулах боломжтой болгодог."[5]

Энэ нууц юунаас бүрэлддэг вэ?

Паул бидэнд хандан Колоссай 1:25-27 дээр ийнхүү бичжээ: Тэрээр *"Бурханы үгийг биелүүлэхийн тулд та нарын тусын тулд Бурханаас надад соёрхсон үүргийн дагуу би энэхүү чуулганы үйлчлэгч болсон юм.* ***Тэрхүү нууц нь өнгөрсөн үеүдээс, үр удмуудаас нууцлагдаж байсан боловч одоо Өөрийнх нь ариун хүмүүст илэрхийлэгджээ****..." Энэ нь ямар нууц вэ? "Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг, тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм.* ***Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн.****"*

Нууцлагдсан энэхүү нууц нь одоо илчлэгдсэн бөгөөд энэ нууц бол Есүс Өөрөө юм. Тэрээр бидний дотор Ариун Сүнсээр дамжуулан амьдрахыг хүсдэг. Дээрх эшлэлд энэ бол бидэнд өгөгдсөн алдрын найдвар юм гэжээ. Энэ нь Бурханы бидэнд одоо өгөхийг хүсдэг бүрэн дүүрэн амьдрал болон ирээдүйд хүрч болох мөнхийн амьдрал гэсэн үг юм. Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор амьдрахыг хүсдэг Христтэй харилцах дотно харилцаа нь Бурханы агуу хайрыг бидэнд маш өөр арга замаар харуулж байгаа юм. "Христ бидний дотор байх" гэдэг нь тэрхүү нууцын зүрх нь юм. Өргөн утгаар хэлбэл энэ нь сайн мэдээ эсвэл авралын төлөвлөгөө гэсэн үг.

Ром 16:25, 26 дээр энэхүү нууцаар итгэлийн дуулгавартай байдал нь бий болсон буюу гүйцэлдсэн хэмээжээ. Энэ нь Христийн улмаас бид дуулгавартай байх хүсэлтэй болсон гэсэн үг.

Христ бидний дотор хэрхэн оршдог вэ?

Христ бидний дотор амьдрах боломжтой юу? Бид Ефес 3:16,17,19 дээрээс дараах эшлэлүүдийг уншдаг: *"Тэр Өөрийн алдрын баялгийн*

5 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 60, 61.

дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, ... мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай."

Тэгэхээр бидэнд дараах зүйлсийг хэлсэн байна:

1. Ариун Сүнсний тусламжтайгаар бид хангалттай дотоод хүчийг олж авдаг.
2. Ариун Сүнсээр дамжуулан Христ бидний дотор итгэлээр оршдог.
3. Тэгэхээр бид хайранд үндэслэгдэж суурилсан байх болно. Христ бидний дотор амьдрахад Тэрээр Өөрийнхөө хайрын зан чанарыг бидний дотор хөгжүүлдэг. Библи үүнийг "Сүнсний үр жимс" (Галат 5:22) гэж бичсэн байдаг.
4. Энэ нь биднийг "Бурханы бүрэн дүүрнээр дүүргэгдсэн" амьдрал уруу хөтөлдөг. (Иохан 10:10; Колоссай 1:9,10-г хараарай).

Христ бидний дотор байна гэдэг бол одоо бидний дуулгавартай байдал хэрэгжих боломжтой гэсэн үг. Учир нь бидний дотор буй Христ үүнийг гаргадаг юм. Элен Уайт: Хэрэв хүн Христийг хүлээн авбал тэрээр Христийн амьдралаар амьдрах хүчийг хүлээн авдаг" гэж хэлжээ.[6]

Бид Есүст бүрэн итгэж найдах буюу өөрсдийгөө Түүнд бүрэн зориулах үед Тэрээр бидний дотор амьдардаг. Тэгээд үр дүнд нь итгэлийн дуулгавартай байдал бий болдог. Христ бидний дотор Өөрийн ялгуусан амьдралаар амьдрахыг хүсч байна.

Галат 4:19 дээр элч Паул үнэ цэнэтэй санааг бичсэн байдаг: *"Хүүхдүүд минь, Христ та нарын дотор дүрээ олтол би төрөх зовлонг дахиж эдэлж байна."* Паул итгэгчдийн дотор Христийг амьдраасай хэмээн ихэд санаа тавьсан юм. Тэгээд тэрээр "Христ та нарын дотор дүрээ олтол" гэж хэлжээ. Аливаа хүн бүрэн хөгжихөд хэр хугацаа орох вэ? Багадаа л 16-17 жил орно. Паул энд өсөлтийн үйл явцыг дүрсэлсэн гэж би итгэж байна. Бид Христэд өдөр бүр амьдралаа зориулж, өдөр бүр Ариун Сүнсийг гуйхад энэхүү харилцаанд өсөх үйл явц явагдаж байдаг.

Тодорхой бус утгууд

Харамсалтай нь дуулгавартай байх талаар хэд хэдэн зүйл тодорхойгүй байна. Нэгдүгээрт, бидний итгэлийн амьдралын талаар Есүсийн хэлсэн хамгийн чухал зүйлийг харцгаая: *"Надгүйгээр та нар юу ч хийж чадахгүй"* (Иохан 15:5). Энэ нь дуулгавартай байдлын чухал хэсэгт хамааралтай.

6 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 314.

Хоёрдугаарт, дуулгавартай байдлын үндсэн зарчмуудыг тайлбарласан Элен Уайтын бичээсийг харцгаая. "Хуулийг сахиж өөрийн үйлдлээр диваажинд очихыг оролддог хүн боломжгүйг оролдож байна. Хүн дуулгаваргүйгээр аврагдах боломжгүй гэхдээ түүний үйлс өөрийнх нь байх ёсгүй. Түүний хүсэл биелэгдэхийн тулд Христ түүний дотор ажиллах ёстой."[7]

Энд гурван чухал санааг илэрхийлжээ:

1. Өөрийнхөө үйлсээр тэнгэрт хүрэх боломжгүй. Хүн гавьяа байгуулснаар Бурханаас ямар нэгэн зүйл олж авахыг хүсэх нь (үйлсээр зөвтгөгдөх) бүтэхгүй гэсэн үг.
2. Есүсийн шавь нар Бурханы хүслийн дагуу амьдрахаар дуудагдсан тул дуулгавартай байх нь Бурхантай хамт амьдрах амьдралын салшгүй нэг хэсэг юм.
3. Дуулгавартай байх нь бидний өөрсдийн хүчээр мөн хүслээр болдоггүй. Харин бидний дотор буй Христээр дамжин гүйцэлдэх зүйл юм.

Одоо ийм үр дүнд хэрхэн хүрэхийг илүү нарийвчлан авч үзье. Диваажинд үйлсээрээ очдог гэж итгэдэг хүмүүс олон байдаг. Тэд Бурханы тэдэнд өгсөн гайхамшигтай арга замыг мэддэггүй учраас энэ буруу замаар явах нь зөв гэж боддог. Тэд ингэснээрээ боломжгүй зүйлд хүрэхийг оролдож байна.

Ариун Сүнсээр дамжуулан Есүс дотор байдаггүй хүмүүс хэр их эсвэл бага хэмжээнд дуулгавартай байхаас үл хамааран боломжгүй зүйлийн хойноос хөөцөлдөж байдаг.

Бид өөрсдийн хичээл зүтгэлээр (хуулийн дагуу үйлсээр) аврагдахгүй, харин зөвхөн Бурханд итгэх итгэлээр аврагдахыг Сударт заадаг. Ром 3:28: "Учир нь хүн Хуулийн үйлсээс ангид, итгэлээр зөвтгөгддөг гэж бид үздэг." "Нүгэлд унасан хүн авралыг олохын тулд хамгийн сайнаараа, илүү хичээнгүйлэн сайн үйлсийг дахин дахин давтан үйлдэх гэж хичээх хэрэггүй." Аврал бол зөвхөн Есүс Христэд итгэх итгэлээр л ирдэг."[8]

Дуулгавартай байдал зайлшгүй шаардлагатай

Есүс дуулгавартай байхыг онцолсон байдаг. Түүний хэлсэн хамгийн сүүлийн үгс бол: *"Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа"* (Матай 28:20). Тэрээр энд дуулгавартай байдлын талаар тодорхой ярьж байна. Синаи уулаад Есүс Христ өөрийн гараар бичиж Мосед өгсөн тушаалууд нь бидний дуулгавартай байдлыг шаарддаг.

7 Элен Уайт, Ревью энд Хералд, 1890 оны 7 сарын 1, 11 хэсэг.

8 Элен Уайт, *Итгэл ба Үйлс:* Ревью энд Хералд, 1999, х. 18.

Библид бичигдсэн энэхүү Бурханы хүлээлтийг дараах байдлаар дүгнэжээ: "Түүний бүхий л бэлгүүд дуулгавартай байх нөхцөлөөр өгөгдөхөөр амлагдсан."[9]

Христийн Гол Хичээлүүдэд: "Бурханы зан чанар Түүний хуулинаас харагддаг; Бурхантай зохицон амьдрахын тулд Түүний хуулийн зарчмууд таны үйл хөдлөлийн үндэс байх ёстой. "Христ хуулийн шаардлагыг багасгадаггүй."

"Дуулгавартай байдал нь мөнхийн амьдралын нөхцөл шаардлага юм."[10]

Дуулгавартай байдал нь бидний Бурханыг мэддэг эсэхийг харуулдаг: *"Хэрэв бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ. "Түүнийг би мэднэ" гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нэгэн бол худалч бөгөөд түүний дотор үнэн байхгүй"* (1 Иохан 2:3,4). *"Түүний тушаалуудыг сахигч нь Түүний дотор байж, Тэр түүний дотор байна"* (1 Иохан 3:24).

Мөн дуулгавартай байдал нь Бурханыг хайрладаг эсэхийг маань харуулдаг үзүүлэлт юм: *"Бурханыг хайрлах нь Түүний тушаалуудыг сахих юм. Түүний тушаалууд нь хүнд дарамт биш билээ"* (1 Иохан 5:3).

Дуулгавартай байдал бол үлдэгчид буюу *"Бурханы тушаалуудыг сахидаг"* (Илчлэлт 12:17) төгсгөлийн үеийн сүмийн шинж тэмдэг гэж Библид бичсэн байна. *"Бурханы тушаалууд хийгээд Есүст итгэх итгэлийг сахидаг ариун хүмүүсийн тэвчээр энд байна"* (Илчлэлт 14:12).

Энэ цаг үеийн хамгийн амжилттай номлогч болох Чарльз Финни хэлэхдээ: "Сэргэлт бол Бурханд дуулгавартай байх шинэ эхлэл юм"[11] гэжээ. Түүнчлэн бид 2011 оны 8-р сарын 31-нд хэвлэгдсэн *Насанд Хүрэгчдийн Библи Судлалын гарын авлагаас* эш татахыг хүсч байна. "Дуулгавартай байх нь аврал гэсэн үг биш, харин аврагдагчдын амьдралд авралаас ирсэн ивээл ерөөл болон үр дагаврыг илчилдэг зүйл юм."

Христ дотор дуулгавартай байх

Бид зөвхөн Христийн дотор байснаар дуулгавартай байж чадна. Зөвхөн Тэр л үүнийг хийх чадвартай. Христ Өөрөө хүн байсан болохоор бидэнд дуулгавартай байдлын үлгэр жишээ болдог. *"Тэр Хүү нь байсан хэрнээ зовсон зүйлсээсээ дуулгавартай байдалд суралцсан"* (Еврей 5:8). *"Тэр төгс болгогдсонооров Өөрт нь дуулгавартай байдаг бүх хүнд мөнх авралын эх үндэс нь болсон"* (эшлэл 9).

9 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 145.

10 Дээрх номтой адил., х. 391

11 Cited in Unser größtes Bedürfnis (Our Greatest Need), Lüneburg: Werner E. Lange, 2011, S. 102.

Үйлс 5:32 дээр үүнийг баталдаг: Бурхан Өөрт нь дуулгавартай нэгэнд Ариун Сүнсээ өгдөг. Энэ нь Бурханы тушаалуудад дуулгавартай байх нь бидний авралын нөхцөл гэсэн үг үү? Үгүй огт тийм биш! Харин авралын зам зөвхөн итгэлээр л ирдэг бөгөөд энэхүү замаар явахдаа бид Бурханд дуулгавартай байх ёстой. Дараа нь Тэр Өөрийн Сүнсээрээ дамжуулан гайхамшигтай байдлаар бидний амьдралд ажилладаг бөгөөд ингэснээр бид Бурханы хүссэн сайхан амьдралаар амьдрах болно.

Яг энэ зүйлийг Паул Ром 8:3,4 дээр бичжээ: *"Махан бие мөхөс болохоор Хуулийн хийж чадаагүйг Бурхан хийсэн юм. Тэр Өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв.* ***Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно.***" Бурхан ийнхүү хэлсэн: "Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно" (Езекиел 36:27).

Ариун Сүнсээр үргэлж дүүрэн амьдрах

"Сүнсний дагуу алхах" гэдэг нь Ариун Сүнсээр үргэлж дүүрэн амьдрах гэсэн үг юм. Дуулгавартай байдал нь бидний доторх Христээр дамжуулан, ялангуяа Ариун Сүнснээс хамааралтай амьдардаг хүмүүст бүрэн биелэгддэг болохыг энэхүү бичвэрээс харж болно. Хуулиар шаардагдах зөв шударга байдал бидний дотор биелэгдэхийн тулд Бурхан Хүүгээ илгээсэн. Бичвэрт зөвт байдал биднээр дамжуулан гүйцэлддэггүй харин бидний дотор байдаг гэдгийг анхааараарай.

Паул Галат 2:20 дээр өөрийнхөө амьдралын талаар юу гэж хэлсэн бэ? *"Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна."* Христ түүний амьдралыг хөтөлж байгааг Паул тодорхой тайлбарласан байна. Езекиел 36:27 дээр Бурхан бидэнд ийн хэлдэг, *"Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно."*

Энэ эшлэлийн утга нь тодорхой байна уу? Бурхан биднийг Өөрийн Сүнсээр дүүргэхийг хүсдэг бөгөөд үүгээрээ биднийг Өөрийнхөө зарлигуудыг сахидаг хүмүүс болгодог. Энэ нь Ариун Сүнсээр дамжуулан бидний дуулгавартай байдлыг Бурхан анхаарч халамжилна гэсэн үг юм.

Дуулгавартай байдал нь Ариун Сүнс болон Христээс ирдэг болохыг бид энд тодорхой харж байна. Энэ бол чин сэтгэлээсээ дуулгавартай байх явдал юм. Энэ нөхөрлөл байхгүйгээр бид зөвхөн өнгөц, хангалтгүй дуулгавартай байдлыг бий болгоно. "Христийн сэргээгч хүчгүйгээр зан чанарын өнгөцхөн зөвт байдал бий болдог гэдэг нь үнэн юм. Хайрын нөлөө буюу бусдыг хүндлэх хүсэл эрмэлзэл нь дэг журамтай амьдралыг бий болгож болох юм. Өөрийгөө үнэлж хүндэтгэх нь муу зүйлээс

зайлсхийхэд хүргэж болно. Мөн хувиа хичээсэн сэтгэлээс өгөөмөр үйлс гарч болно."[12] Бид магадгүй Бурханы тушаалыг үүрэг хариуцлага буюу биднээс шаардаж буй зүйл хэмээн бодсоны улмаас дагаж байж болох юм. "Бурханы зарлигуудыг зөвхөн үүрэг хариуцлага үүднээс сахихыг хичээдэг хүн дуулгавартай байдлын баяр баясгаланд хэзээ ч орж чадахгүй." Тэр хүн дуулгавартай байгаа юм биш. Хэрэв Бурханы шаардлага нь хүний дур хүсэлтэй зөрчилддөг учраас дарамт хэмээн тооцдог бол тэр хүний амьдрал Христэд итгэгчийн амьдрал биш юм. Учир нь жинхэнэ дуулгавартай байдал нь хүний дотор буй зарчмаас улбаалан гардаг."[13]

Христ бидний дотор хэрхэн амьдардаг вэ?

Есүстэй харилцах харилцаа нь Түүнд бүрэн бууж өгөхөөс эхэлдэг. Үүний хариуд Тэрээр бидэнд сүнслэг дахин төрөлтийг өгдөг (Иохан 3:1–21-г үзнэ үү). Бидний шинэ амьдралыг Бурхан өгсөн ба Христтэй харилцах харилцаагаа өдөр бүр шинэчилснээр тэжээгддэг юм. Энэ нь Ариун Сүнсээр дүүргэгдэх, сэргэх зэрэг бидний өдөр бүрийн зориулалтыг шаарддаг. Есүс ийм байдлаар бидний дотор амьдардаг. *"Тэр ... Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, ..."* (Ефес 3:16,17).

Христ таны дотор амьдардаг эсэхийг шалга

Судар биднийг Христийн дотор амьдарч байгаа эсэхээ шалга гэж уриалдаг. *"Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө батал. Эсвэл Есүс Христ та нарын дотор байгааг та нар өөрсдөө мэддэггүй юм уу? Та нар үнэхээр шалгалтандаа унадаггүй л юм бол. ..."* (2 Коринт 13:5).

Бурхан биднийг сүнслэг байдлаа мэдэж байхыг хүсдэг. Ямар үед бид шаардлагад нийцээгүй буюу тохироогүй байдаг вэ? Бид Ариун Сүнсээр дүүрэн байх үедээ мөн Христийн дотор байх үедээ шаардлага хангасан байдаг. Харин Ариун Сүнсээр дүүрээгүй, дутмаг амьдрал нь шаардлагыг хангаагүй байдаг. Библи үүнийг махан биеийн бодол санаа гэж нэрлэдэг.

Бидний унадаг машин хэзээ хэрэггүй болдог вэ? Явахаа больсон үед хэрэггүй болдог. Хэрэв шатахуун байхгүй бол бид юу хийдэг вэ? Бид нэг бол түрж болно эсвэл шатахуун худалдан авч болно. Гэхдээ мэдээжийн хэрэг бид машинаа шатахуунаар дүүргэнэ. Есүс Ариун Сүнсээр дамжуулан бидний зүрх сэтгэл дотор оршихгүй байваас бидний дуулгавартай байдал нь түлшгүй машинаа түрэхийг оролдож буй хүнтэй адил юм.

---

12 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 58.

13 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 97.

Энэ жишээ нь Есүс бидний итгэл бишрэл болон амьдралд хичнээн чухал болохыг танд илүү тодорхой болгож байна уу? Есүсийг орлуулшгүй билээ. *"Хүү байгаа хүнд амь бий"* (1 Иохан 5:12). *"Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй"* (Иохан 14:6). Бидэнд Есүс хэрэгтэй. Түүнгүйгээр бид аврагдаж чадахгүй. Бид ирээдүйн мөнх амьдрал болон энэ дэлхийн амьдралдаа бүрэн дүүрэн амьдарч чадахгүй.

Дуулгавартай байдал хэрхэн биелдэгийг та илүү сайн ойлгож байна уу? Бид өдөр бүр буун өгч, Ариун Сүнсийг залбиран гуйснаараа Есүст бэлэн байгаагаа харуулдаг. Бид 1 Коринт 1:30-г уншсанаар үүнийг илүү сайн ойлгоно: *"Харин та нар Түүнээс болж Христ Есүс дотор байгаа юм. Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон юм."* Христ энэ бүхнийг хүсдэг ба бидний дотор биелүүлж чадна. Христ биднийг ариусгасан гэдэг нь бид дуулгавартай амьдрах боломжтой болсон гэсэн үг юм.

Бид хэзээ аврагддаг вэ?

Энэ асуултын хариулт яагаад маш чухал вэ? Би аль хэдийн аврагдсан бол дуулгавартай байдал нь авралын үр дүнд бий болдог нь тодорхой болно. Дуулгавартай байдал нь авралын урьдчилсан нөхцөл биш юм. Би Есүс Христэд бүрэн бууж өгөх тэр мөчдөө аврагдсан байдаг. *"Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно"* (Ефес 2:8,9).

Элч Паул Ефесчүүдэд захидал бичихдээ тэднийг аль хэдийн аврагдсан гэдгийг мэдэгджээ. Гэсэн хэдий ч Ром 8:24-т тэрээр ***"Бид найдвараар аврагдсан юм"*** гэж хэлсэн байдаг. Бидэнд Бурхантай хамт байх эсвэл орхиод явах эрх чөлөө бий.

Бид (найдвараар) аврагдсаны дараа гол асуудал бол амьдралынхаа төгсгөл хүртэл эсвэл Түүний хоёр дахь ирэлт хүртэл Христийн дотор байх явдал юм. Бид итгэлээр аврагдсан (Ефес 2:8), гэхдээ дараа нь энэ итгэл бишрэлдээ үлдэх шаардлагатай байдаг. *"Та Эзэн Есүс Христийг урьд нь хүлээн авсан тул түүн дотор алх"* (Колоссай 2:6). Энд гол нь бууж өгснөөрөө Христийн дотор байх явдал юм. Деннис Смит Христийн дотор байх талаар дараах зүйлийг бичжээ: *"Түүний дотор байх нь аврагдахын төлөө хийх ёстой ажил биш, харин Есүсийг биднээр дамжуулан, бидний дотор, бидний төлөө бүх зүйлийг хийхийг зөвшөөрч буй явдал юм."*[14]

14 Деннис Смит, *40 Өдөр:* Бурхантай харилцах харилцаагаа сэргээх залбирал ба мөргөл, 2-р дэвтэр (Hagerstown, MD: Review and Herald Publishing Association, 2011), х. 35.

Яагаад бүрэн бууж өгөх шаардлагатай вэ? Тэгэх нь юунд хэрэгтэй вэ?

Бүрэн бууж өгөх нь биднийг өөрсдийн маань Би гэх үзлийн дарангуйллаас ангижруулдаг. Бидний би гэх үзэл нь бидний асуудлын гол шалтгаан байдаг. Сургаалт үгс номонд: Хүн бүрийн хамгийн том асуудал бол өөрсдөө. Бидний би гэх үзэл нь гомдоллох, урам хугарах, эрх мэдлээ баталгаажуулахыг хүсэх, атаа жөтөө гэх мэт асуудлуудыг авчирдаг.

"Бурхан биднийг эдгээж, биднийг чөлөөлөхийг хүсдэг. Гэхдээ энэ нь маш их өөрчлөлт буюу мөн чанараа бүрэн шинэчлэх шаардлагатай байдаг тул бид бүхэлдээ Түүнд бууж өгөх хэрэгтэй болдог. Тэрээр нигүүлслээрээ дамжуулан бидэнд өгөхийг хүсдэг агуу их ивээл ерөөлийг бидний өмнө тавьсан. Тэр биднээс өөрсдийгөө Түүнд өгөхийг уриалдаг. Ингэснээр Тэр бидний дотор хүслийнхээ дагуу ажиллаж чадна. Нүглийн боолчлолоос чөлөөлөгдөж, Бурханы хөвгүүдийн алдар сууг хуваалцах эсэх нь бидний сонголт хэвээр байна."[15]

Би гэсэн үзэл дотроо амьдрах нь нүглийн боолчлолын амьдрал билээ. Харин Христтэй хамт амьдрах нь Бурханы хүүхдүүдийн гайхамшигтай эрх чөлөөт амьдрал юм. Ваарчин зөвхөн түүний гарт байгаа шаврыг л хэлбэржүүлж чадна. Тиймээс бидний бууж өгөх үйл явц туйлын чухал юм.

Бид бууж өгснийхөө дараа л Христийн дотор ордог. Бид Түүний дотор байх аваас аврал үүрд мөнх үргэлжлэх болно. Харин Есүс дахин ирсний дараа энэ байдал цоо шинэ хэмжээс дотор үргэлжлэх болно.

Библийн дуулгавартай байдал

Библийн дуулгавартай байдал нь үйлсээрээ зөвтгөгдөх эсвэл гавьяа байгуулахын аль нь ч биш. Энэ бол миний Бурханд итгэх итгэл, миний бууж өгсөн явдал, миний аврал, миний Христтэй харилцах харилцааны логик үр дүн юм. Ариун Сүнсээр дүүрч, шинээр төрсөн Христэд итгэгчийн Библийн дагуух дуулгавартай байдал гэдэг нь Бурханыг хайрлах хайраа үйлсээр илэрхийлж буй явдал юм. Ариун Сүнсний хүчээр дуулгавартай байх нь баяр хөөрийг өгдөг.

"Жинхэнэ дуулгавартай байдал нь зүрх сэтгэлээс гардаг. Энэ бол Христтэй хамт зүрх сэтгэлээсээ хийх зүйл юм. Хэрэв бид зөвшөөрөх аваас Тэрээр бидний хүсэл бодол, зорилгод Өөрийгөө танилцуулна, харин бид зүрх сэтгэл, оюун бодлоо Түүний хүсэлд нийцүүлдэг. Тэгээд бидний хүсэл бодол цэвэршин ариусаж, Түүнд үйлчлэх үйлчлэлээсээ хамгийн дээд таашаалыг хүртэх болно."[16]

---

15 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 43, 44.

16 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 668.

Бид өөрсдийн хүчин чармайлтаар дуулгавартай байж чадахгүй гэдгээ ойлгох ёстой. Эзэн Израилийн ард түмний талаар дараах зүйлийг хэлжээ: "Тэд Бурханы ариун байдал, Бурханы хуулийг дуулгавартай дагах, зүрх сэтгэлийнхээ хэт их нүгэлтэй байдал, өөрсдийн чадваргүй байдлынхаа талаар үнэн зөв ойлголтгүй байсан."[17]

Бид Бурханы зарлигуудыг өөрсдийн хүчээр дагаж чадахгүй. Дуулгавартай байдлын нууц нь Ариун Сүнсээр дамжуулан Есүс бидний дотор байх явдал юм. Хэрэв бид Есүсийг үнэхээр хайрлаж, Түүнд итгэдэг бол, мөн Тэрээр Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор амьдардаг бол дуулгавартай байдал нь асар их баяр хөөрийг авчирдаг. Есүс бидний дотор байхад, бидний зүрх сэтгэлд Түүний хууль байгаа нь батлагддаг. Энэ хууль бол эрх чөлөөний хууль болох Арван Хууль юм (Иак. 2:12).

17 Элен. Уайт, *Эцэг Өвгөд ба Эш Үзүүлэгчид* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2005), х. 371

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Итгэлийн дуулгавартай байдал гэж юу вэ? Үүнийг хэрхэн ойлгож болох вэ?*

   _____

2. *Би хэзээ хэрхэн аврагддаг вэ? Энэ аврал нь өөрчлөгдөшгүй юу?*

   _____

   _____

3. *Бидний хийдэг эсвэл хийдэггүй зүйлстэй холбоотой Библийн итгэлээс гарах үр дагавар юу вэ?*

   _____

4. *Бурхан биднээс ямар нэгэн зүйл хүсэн хүлээж байдаг уу? Хүний үйлс авралтай холбоотой ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?*

   _____

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Аврал болон дуулгавартай байдлыг илүү гүн ойлгохын төлөө*
  2. *Бурхантай харилцах харилцааны баяр баясгалангийн төлөө*
  3. *Библи дэх авралын баталгааны төлөө*
  4. *Үйлсээр илэрхийлэгддэг Бурханы хайрлах хайрын төлөө*
  5. *Бурханы хайр ба ариун байдлыг зөв ойлгохын төлөө*

"Миний доторх Есүс"-ээр
дамжуулан дуулгавартай байдал
хэрхэн хэрэгждэг вэ?
Бурхан хунийг Өөртэйгөө
хамтрах хамааралтайгаар бүтээсэн

Хурим дээрх дуулгавартай байдлын гайхамшиг

Есүс Кана дахь хуримын үеэр анхны гайхамшгаа үйлдсэн түүхийг бид бүгд мэднэ. Тэрээр усыг дарс (бидний нэрлэдгээр усан үзмийн шүүс) болгон хувиргасан. Тэнд юу болов?

Есүсийн ээж Мариа дарс дууссаныг сонсоод Есүст хэлсэн. Гэхдээ Есүс түүний бодож байсан шиг хариу өгөөгүй. Гэсэн хэдий ч ээж нь Есүсийг энэ тохиолдолд ямар нэг байдлаар тусална гэж бодоод, үйлчлэгчдэд: *"Түүний [Есүсийн] та нарт хэлсэн бүхнийг хий"* (Иохан 2:5) гэж хэлэв. Мариа тийнхүү үйлчлэгчдийн Есүст итгэх итгэлийг нэмэгдүүлж өгсөн юм.

Есүс хариуд нь, ""Торхнуудыг усаар дүүргэ" гэж айлдсанд тэд торхнуудыг амсарт нь хүртэл дүүргэв. Дараа нь Есүс *"Одоо утгаад найрын ахлагчид аваачиж өг" гэсэнд, тэд аваачиж өгөв"* (эшлэл 7,8).

Энэ түүхээс онцлох зүйл гэвэл: Үйлчлэгчид Есүст итгэл үнэмшилтэй болсон тул Түүний тушаалыг биелүүлэхээр шийдсэн. Өөрөөр хэлбэл, Есүсийн хүссэн зүйлийг хийснээр тэдний хүсэл болоод шийдвэр нь дуулгавартай байдлын алхмууд байсан юм. Есүс тэдний дуулгавартай байдлаар дамжуулан усыг амттай ундаа болгон хувиргасан. Тэрээр анхныхаа гайхамшгийг ийнхүү үйлджээ.

Хувь хүний ямар алхмууд хийгдсэн бэ?

- Мариа заавар зөвлөгөөгөөрөө дамжуулан үйлчлэгчдийн Есүст итгэх итгэлийг өсгөсөн.
- Зарц нар Есүсийн хэлсэн зүйлийг хийснээрээ итгэж байгаагаа харуулсан.
- Мариа ч, үйлчлэгчид ч усыг дарс болгон хувиргаагүй. Зөвхөн Есүс ганцаараа энэ гайхамшгийг үйлдсэн билээ.

Гэхдээ эдгээр алхмуудгүйгээр энэ гайхамшиг бий болох байсан болов уу? Бид өөрсдийн хүсэл, сонголтоо Түүний мэдэлд өгч, дуулгавартай байх алхмаар Есүст итгэж найдах нь чухал юм. Тэгснээр Есүс, зөвхөн Есүс тэрхүү гайхамшгийг үйлдэх болно. Тэр бидний дуулгавартай байдлаар дамжуулан гайхамшгийг үйлддэг. Итгэлийн дуулгавартай байдал нь ингэж ажилладаг юм. Есүс бидэнд аврал, ариусал, зөвтгөл ба мэргэн ухааныг өгдөг (1 Коринт 1:30). Түүний хүслийг дагах шийдвэр болон дуулгавартай байдалд бэлтгэх алхмууд нь дуулгавартай байдлын гайхамшгийг нээх үүд хаалга юм.

Бурхан хүн хоёрын хамтын ажиллагаа

Элен Уайт энэхүү дуулгавартай байх алхмуудыг Даниелын амьдралд хэрхэн хэрэгжсэнийг ийнхүү тайлбарлажээ: Бурхан Даниел болон түүний нөхдийг "Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн" төлөө тэдний дотор ажиллаж байхад, харин тэд өөрсдийнхөө авралын төлөө ажиллаж байсан юм (Филлиппой 2:13). Энэ үйл явдал нь бурханлаг зарчимтай хэрхэн хамтран ажиллахыг харуулсан бөгөөд үүнгүйгээр жинхэнэ амжилтанд хүрэх боломжгүй юм. Хүний хүчин чармайлт нь бурханлаг хүчгүйгээр юунд ч хүрэхгүй; мөн хүний хүчин чармайлтгүйгээр бурханлаг хүч нь үр дүнгүй байдаг. Бурханы нигүүлслийг өөрийн болгохын тулд бид өөрсдийн хийх ёстой зүйлийг хийх хэрэгтэй. Түүний нигүүлсэл бидний дотор ажиллахаар өгөгдсөн боловч, бидний хүчин чармайлтыг хэзээ ч орлож чадахгүй. ...

Мөн Түүний Сүнсийг агуулснаар Тэрээр жинхэнэ үнэн зорилго, эрхэм шийдвэр бүрийг тань хүчирхэгжүүлэх болно. Дуулгавартай байдлын замаар явдаг хүмүүс олон саад бэрхшээлтэй тулгарах болно. ... Гэхдээ Түүний хүч чадлаар тэд бүх сорилтыг даван туулж, бэрхшээл бүрийн цаана гарч чадна.[1]

"Бурханлаг хүч нь хүний хүчин чармайлттай хамтрах байдлаар бүтээгдсэн."[2] Марк Финли хэлэхдээ "Бурхантай хамтран ажиллах нь маш их баяр баяслыг авчирдаг" гэжээ.

Бид ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Есүс ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

1. Бид өөрсдөө Есүст итгэх итгэлээ хөгжүүлэх эсэхээ шийддэг. Тэрээр бидний дотор хүсэл эрмэлзлэлийг бий болгодог ба тийнхүү бид юу хийх ёстойгоо ойлгодог. Гэхдээ Тэр бидний шийдвэрийг хүлээж байдаг.

1 Элен Уайт, *Эш Үзүүлэгчид ба Хаад,* х. 486, 487.

2 Элен Уайт, *Та Нар Хүчийг Авна,* 1 сарын 2, х. 10.

2. Бурханы хүслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргах нь бидний үүрэг юм. Бурхан бидний зан чанар, хүслийг бүрэн хүндэтгэдэг тул бид шийдвэрээ гаргасны дараа Тэр хөндлөнгөөс оролцох боломжтой болно.
3. Есүст итгэж байгаагаа илэрхий харуулж, дуулгавартай байдлын алхмаараа илэрхийлэх нь бидний үүрэг билээ. Энэхүү дуулгавартай байдлын алхмууд нь хэм хэмжээгээрээ их ялгаатай байж болно.
4. Бурхан хамгийн чухал хэсгийг ганцаараа хийдэг бөгөөд биднийг итгэл найдвараа өсгөж, бэлтгэлээ хангахад дэмжлэг үзүүлдэг. Өөрсдийн хүчээр шийдвэр гарган дуулгавартай байх гэж хичээх эсвэл Бурханы хүчээр эдгээрийг хийх гэж оролдох нь хоорондоо асар их ялгаатай болохыг бид мартаж болохгүй. Есүс бидний дотор Ариун Сүнсээр дамжуулан орших үед бидний хийх ёстой зүйл Бурханы хүчээр хийгддэг. Тийнхүү жижиг ч бай, том ч бай ямар нэгэн зүйлд дуулгавартай байх нь баяр хөөр болдог.[3]

Асуултууд

Дуулгавартай байдлыг хэн боломжтой болгодог талаар өөр өөр үзэл бодлууд байдаг. Зарим хүмүүсийн хувьд дуулгавартай байх нь бурханлаг хүч ба хүний хамтын ажиллагааны үр дүнд бий болдог гэж үздэг. Зарим нь Бурхан буюу Христ үүнийг дангаараа хийдэг гэж үздэг. Тэгвэл дуулгавартай байдал хэрхэн хэрэгждэг вэ?

Есүсийн цаг үед олон хүн үнэнийг мэдэхэд л хангалттай гэж итгэдэг байв. *Ye Yeийн Хүслэн* номонд "Христийн үеийн хүмүүсийн оюун ухааныг хамгийн ихээр хуурч байсан явдал нь зөвхөн үнэнийг хүлээн зөвшөөрөх нь зөвт байдал гэсэн үзэл байлаа" гэж бичсэн байна.[4]

Бурхан биднээс Түүний хүслийг хүлцэнгүйгээр хүлээж аваасай гэж хүлээдэггүй, харин биднийг хариу үйлдэл үзүүлэхийг хүсдэг. Энэ нь бид Христийг зүрх сэтгэлдээ байлгаснаар эерэг шийдвэр гаргаж, түүнийгээ хэрэгжүүлдэг гэсэн үг юм. "Хүн хуяг дуулга өмсөж, итгэлийн сайн тэмцлээр тэмцэхээр сонгогдсон. Тэрээр Бурханы өөрт нь тавьсан зорилгод хүрэхээр сонгогдсон. .... Тэрээр үргэлж итгэлтэй байхаар сонгогдсон."[5] "Ялалтын агуу их ажилд хүн маш бага үүрэг гүйцэтгэдэг эсвэл юу ч хийх хэрэггүй гэсэн санааг хэн ч бүү яриасай. Учир нь Бурхан хүний хамтралгүйгээр түүний төлөө юу ч хийдэггүй. ... Хүн эхнээсээ эцсээ хүртэл Бурхантай

3 Марк Финли, *Шийдвэрүүд: Хүмүүсийг Ятгах нь* (Мөнгөн хавар, MD: Долоо дахь өдрийн Адвентистуудын ерөнхий чуулган, 1984).

4 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 309.

5 Элен Уайт, *Сайн Мэдээний Ажилчид болон Үйлчлэлийн Гэрчлэлүүд,* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2003), х. 454.

хамтарч ажиллах ёстой. ... Христтэй хамтран ажиллана гэдэг нь ялалт гэсэн үг. ....

"Энэ агуу ялалтын ажилд хүний хийх өчүүхэн ч зүйл байхгүй гэсэн санаа бодлыг бусдадаа хэзээ ч бүү төрүүлээрэй. Харин оронд нь хүнийг Бурхантай хамтрахад нь зааж сургаарай."[6]

Бидний шийдвэр болон бэлтгэлийн алхмууд ямар үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрөх үед дуулгавартай байдал нь Бурхан, хүн хоёрын хамтын ажиллагаа болох нь тодорхой ойлгогддог. Гэхдээ бэлтгэлийн алхмууд нь Христ бидний дотор Ариун Сүнсээр дамжуулан орших үед Бурханы хүчээр хийгддэг билээ.

Миний бодлоор Бурхан хүнийг бүрэн хүндэтгэдэг учраас хүний зөвшөөрөлгүйгээр үйлддэггүй гэдэг нь зөв үзэл бодол. Хүн зөвшөөрч байгаагаа дуулгавартай алхмаар харуулдаг. Тэгэхээр Бурхан гол үүргийг гүйцэтгэж байгаа нь тодорхой харагдаж байна.

Бид энэ үйл явцын бүх үе шат бүрийг судалж, Бурхантай хамтарсан хүмүүсийн жишээг харах хэрэгтэй. Бид цөл дэх Израиль ба Амалекчуудын хооронд хийсэн тулалдаанд Бурхан болон хүмүүсийн хамтын ажиллагааны тод жишээг олж харж болно (Ег. Гар. 17:8-16-г үзнэ үү). Иошуа цэргүүдтэйгээ тулалдаж байв, харин Мосе ард нь Аарон, Хур нарын дэмжлэгтэйгээр залбирал үйлдсэнээр ялалт байгуулсан юм.

Өөр өөр дуулгавартай байдлын алхмууд

Есүсийн ээж Мариа

Тэнгэр элч Габриел Мариад хандан Есүсийн төрөх талаар мэдүүлэх үед, Мариа Бурханы хүслийг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн. Тэр эмэгтэй: *"Хэлсэн үгсийн тань дагуу надад биелэх болтугай"* (Лук 1:38) хэмээн хариулдаг. Тэрнээс хойш Мариагийн хувьд Бурхан ажлаа хийхийг нь хүлээхээс өөр хийх зүйл байсангүй. Тухайн үедээ Мариа зөвшөөрөхгүй байж болох байсан. Бурханы хүслийг хүлээн зөвшөөрсөн энэ үйл явц нь түүний амьдралд ихээхэн өөрчлөлтийг авчирсан ба хүний өнцгөөс харахад эрсдэл нь өндөр байв. Бидний харж байгаачлан Мариа бүрэн бууж өгсөн амьдралаар амьдарсан юм.

Арван уяман өвчтөн

Есүс дээр ирсэн уяман өвчтөнгүүд ийнхүү хашгирсан: *"Тэд дуугаа өндөрсгөн -Есүс, Эзэнтэн, биднийг өршөөгөөч! гэв. Есүс тэднийг харуутаа, Яв, өөрсдийгөө тахилч нарт үзүүл гэжээ. Тэд явах зуураа цэвэршсэн байлаа"* (Лук 17:13,14).

---

6 Элен. Уайт, (Revival and Beyond) (Payson, AZ: Leaves-of-Autumn Books, 1972), pp. 38, 39.

Эдгээр эрчүүд явах шийдвэр гаргаснаараа итгэл найдвар болон шийдвэрээ харуулсан. Есүс тэднийг хайж яваагүй. Тэгвэл тэд явснаараа эдгэрсэн үү? Мэдээж үгүй! Харин тэд итгэн дуулгавартай байсан учраас Есүс тэднийг эдгээсэн. Тэд эдгэрэлд ямар ч оролцоогүй байсан. Гэсэн хэдий ч тэдний итгэл үнэмшил, дуулгавартай алхмууд нь Есүсийн хийх гайхамшгийн үүд хаалгыг нээж өгсөн юм. Зөвхөн Есүс гайхамшгийг үйлдсэн билээ.

Нааманы эдгэрэл

Нааман уяман өвчнөөс хэрхэн эдгэрсэнийг санаж байна уу? Елишагаар дамжуулан өгсөн Бурханы зааврууд гэвэл: *"Явж, Иорданд долоон удаа угаа. Тэгвэл чиний бие махбод дахин сэргэж, цэвэр болно"* (2 Хаад 5:10). Нааман энэ зааврыг сонсоод уурласан. Харин зарцдаа ятгуулсаны дараа л түүнд үүнийг хийх хангалттай итгэл төрсөн билээ. Бурхан Нааманыг Иордан руу очиж, усанд булхах үед нь эдгээгээгүй. Нааман долоо дахь удаагаа усанд булхсаны дараа л уяман өвчнөөсөө цэвэршдэг. Долоон удаа усанд булхах нь түүнийг эдгээсэн үү? Үгүй! Харин Түүний дуулгавартай байдал нь түүнийг эдгээсэн юм. Багахан итгэлийнхээ улмаас хийсэн тэдгээр алхмуудаас болж Бурхан Нааманыг эдгээсэн байв. Бурханд итгэх багахан итгэл болон дуулгавартай алхмууд нь Бурханыг гайхамшиг үйлдэхэд хүргэснийг бид харж байна. Нааман энэ гайхамшигт ямар ч хамаагүй. Гэхдээ түүний хийсэн алхмуудгүйгээр юу ч тохиолдохгүй байсан юм.

Руди, Мариа Ана хоёр

Дэлхийн II дайны дараа Адвентист сүмд дөнгөж баптисм хүртсэн нэгэн залуухан хос Герман улсын Бад Айблинг хотын ойролцоо жижигхэн хотод амьдарч байв. Мариа Ана анхны хүүхдээ хүлээж байсан бөгөөд эрүүл мэндийн шалтгаанаар сургуулийнхаа багшийн ажлаа орхих шаардлагатай болжээ.

Руди ажил олох зорилгоор хэдэн долоо хоногийн турш өдөр бүр Мюнхен хот уруу явсан боловч үр дүнгүй байлаа. Тэдний хадгаламж ердөө зургаан "Марк" (тухайн үеийн Германы мөнгөн тэмдэгт) болтлоо хорогдсон байв. Нэмж дурдахад тэд Бурханы мөнгийг хадгалдаг дугтуйтай байжээ. Дугтуйнд тэдний аравны нэг өргөл байв. Тэд юу хийх ёстой вэ?

Мариа Ана тэр үед, "Руди, бидний мөнгө бүгд дуусахад бид Бурханы мөнгийг ашиглах сорилтонд орох болно. Тиймээс үүнийг гэртээ байлгахгүй байх нь дээр. Маргааш Мюнхен рүү галт тэргээр явахдаа мөнгөө аваад чуулганы санхүүчид өг" гэжээ. Руди хэлснээр нь үйлдэж, тэр мөнгийг санхүүчид аваачиж өгөв. Санхүүч Рудигээс тэр хоёрын амьдрал хэр байгааг нь асуухад тэрээр нөхцөл байдлаа тайлбарлан хэлжээ.

Тэгтэл санхүүч түүнд "Түр хүлээгээрэй" гэж хэлээд утсаар ярив. Дараа нь тэр "Бид танд ажил оллоо. Энэ хаягаар очоод ноён Бауэрийг сураглаарай" гэв. Хагас цагийн дараа Руди ажилд оржээ. Залуу хос санхүүгийн хувьд хоосорсон ч гэсэн аравны нэгээ өргөсөн юм. Тэд дуулгавартай үйлдлээрээ итгэлээ илэрхийлсэн бөгөөд Бурхан тэр даруйд нь хариулсан байна.[7]

Гуам арал дээрх аялал жуулчлалын компани

Гуам арал дээр томоохон аялал жуулчлалын компанийг эзэмшиж байсан хос Христэд итгэгч болжээ. Эхнэр нь эхлээд баптисм хүртсэн бөгөөд дараа нь 2004 оны 1-р сард нөхөр нь баптисм хүртэв. Тэд компанийхаа зүгээс Шаббат өдрийг ёслол төгөлдөр сахихын тулд маш их залбиран бэлтгэжээ. Зочид буудлуудтай хийсэн Шаббат өдрийн бүх үйлчилгээгээ тэд цуцалсан байлаа.

Нөхөр нь энэ арга хэмжээний шалтгааныг аялал жуулчлалын агентлаг, аяллын газар, зочид буудал, борлуулалтын агентуудад учирлан тайлбарлажээ. Олон харилцагч нь энэ хосыг бизнесээ бусад аялал жуулчлалын компаниудад өгөх болох нь дээ хэмээн хариулжээ. Түүнчлэн компаний ажилтнууд ажлаа алдана гэхээс айж байлаа. Энэ шийдвэр нь компаний хувьд яг л үхлийн ял мэт байв.

Тэрээр ингэж ярьсан юм: Компаниа хаасан анхны Шаббатыг би санаж байна. Баасан гарагийн орой бид захиалга хүлээн авахын тулд автомат хариулагчийг ажиллуусан юм. Бидний хаасан анхны Шаббат өдөр цаг агаар хачирхалтайгаар гэнэт өөрчлөгдөж бүх өдрийн турш аадар бороо оров. Тэгээд дараагийн зургаан сарын турш цаг агаар Баасан гарагт маш сайхан байснаа Шаббатад маш их бороо орж Ням гарагт буцаад сайхан болдог яг энэ хэмнэлээрээ үргэлжилсэн юм. Бурхан биднийг халамжлан харж үзсэн.[8]

Гайхамшиг тохиоход энэ хосын оролцоо бол Бурханд итгэх итгэл болон бэлтгэл алхмууд байсан юм. "Хүний хүсэл Бурханы хүсэлтэй давхцах үед бүхнээс хүчтэй болдог гэдгийг санаарай. Түүний тушаалын дагуу хийгдсэн бүхэн Түүний хүчээр хийгддэг. Түүний бүх хүсэлт биднийг чадваржуулж байдаг."[9] Бурхан бидний итгэлийн дуулгавартай байдал болох итгэлээрээ амьдарч, Түүнд бууж өгөх амьдрал дээр агуу их ивээлийг буулгадаг.

7 Мария Ана Хиршманн, I Changed Gods (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 1968), p. 156.

8 Стив Каспербауэр, Gott ist treu (Браунау / Австри: Зохиогчийн эрхээр хамгаалагдсан, 2013). Үүний талаарх бүрэн бичвэрийг Герман хэл дээрх MISSIONSBRIEF (номлолын захиас) 2014 оны 3/4-р сарын 40-р дугаар дээр нийтлэв.

9 Элен Уайт, *Христийн Гол Хичээлүүд,* х. 333.

Дуулгавартай байдал нь яагаад бидний сайн сайхны төлөө байдаг вэ?

Дуулгавартай байх нь бидний хувьд хамгийн сайн арга зам бөгөөд Бурхан Өөрөө үүнийг зохиосон. Иеремиа 7:23 *"Миний дуу хоолойг дагагтун. Тэгээд Би та нарын Бурхан болж, та нар Миний хүмүүс болно. Та нар сайн байхын тулд Миний та нарт тушаасан бүх замаар алхах болно."* Ямар ч эмч хүн аливаа эмчилгээг зөвхөн мэрийлттэйгээр хэрэгжүүлсэн тохиолдолд эдгэрнэ гэдгийг батлан хэлдэг. Хэрэв бид эдгэрэхийг хүсч байвал эмчийн зааврыг дагаж мөрдөх ёстой гэсэн үг. Зааврыг нь сайн дагаж мөрдөөгүй тохиолдолд хамгийн сайн эмч байсан ч тусалж чадахгүй. Дуулгавартай байдал нь зөвхөн бидний итгэл болоод бууж өгсний үр дагавар байгаад зогсохгүй бидний эрх ашгийн төлөөх зүйл юм. Учир нь Бурханы бүх зарлиг бидний сайн сайхны төлөө өгөгдсөн билээ.

Цөлд байсан гуулин могойд юу тохиолдсон бэ (Тооллого 21:4–9-г үзнэ үү)? Хүмүүс Бурханы хар гэж тушаасан могойг хараад эдгэрч байв. Толгойгоо эргүүлэх үйлдэл нь тэднийг эдгээсэн үү? Мэдээж үгүй. Тэд могойг харснаараа Бурханд итгэх итгэлээ харуулсан тул эдгэрсэн. Зөвхөн Бурхан тэднийг эдгээсэн юм. Дуулгавартай байдал нь тэдний сайн сайхны төлөө байв.

Үүний нэгэн адил, *"Итгэлээр Ноа хараахан харагдаагүй байсан зүйлсийн талаар сэрэмжлүүлэл аваад гэр бүлийнхээ авралын төлөө хөвөгч авдрыг сүсэглэн бэлдсэн"* (Еврей 11:7). Ноагийн барьсан хөвөгч авдар бол түүний Бурханд итгэх итгэлийн үр дүн байсан бөгөөд тэрээр агуу итгэлтэй гэдгээ харуулсан. Тэрээр бүхий л хөрөнгө, цаг заваа энэ хөвөгч авдрыг барихад зарцуулсан бөгөөд тэр үүндээ огтхон ч харамсаагүй. Энэ дуулгавартай байдал нь түүний сайн сайхны төлөө байгаагүй гэж үү? Тэр урьдаас мэдээгүй байсан ч итгэл найдвараар амьдарч байв. Нэг зүйл тодорхой байгаа нь хөвөгч авдрыг барих ажил нь Бурханы хүч болон удирдамжаар хийгдсэн юм.

Нэг талтай бодол

Харамсалтай нь өнөөдөр Бурханы тушаалуудыг маш туйлширсан байдлаар харж байна. Бурханы хуулийг зөвхөн дагаж мөрдөх ёстой хатуу хууль журам талаас нь ойлгодог болжээ. Гэтэл Бурханы тушаалууд нь юуны түрүүнд бидний хувьд амлалт байдаг. Түүнчлэн Бурханд итгэн хайрын харилцаагаар холбогдсон тохиолдолд Түүний хууль нь бидний амьдралд Түүний юу хийж чадахыг харуулдаг билээ.

Бурханы тушаалууд бол ивээл ерөөлийн хууль юм. Дуулгавартай байх гэдэг нь өдөр тутмынхаа асуудлыг шийдэх хүч болон мэргэн ухаанаар

дамжуулан ирдэг сэтгэлгээ юм. Дуулгавартай байхыг энэ өнцгөөс харж чадвал бид айдсаа арилган баяр баясгалан гэж харна.

Дуулгавартай байдал бол Бурханаас ирдэг бэлэг

Есүс бидний дотор дуулгавартай байдлыг бий болгосон нь Түүний бэлэг юм. Хэрэв бид дуулгавартай байдлыг бэлэг гэж харвал дараах хоёр аюулаас зугтаж чадна: (1) "Хуурамч нигүүлслийн" төөрөгдөл болон (2) хуулийг ягштал дагах сорилт.

"Хямдхан нигүүлсэл" гэдэг нь хүн Есүсийг хүлээн авснаар аврагдсан, тийнхүү дуулгавартай байх шаардлагагүй гэж үзэхийг хэлнэ. Нэгэнт Түүний хуулийг бид биелүүлж чаддаггүй тул хууль хүчингүй болсон гэж тэд хэлдэг. Энэ бол махан биеийн итгэгчдийн итгэл юм. Гэхдээ Бурханы хүчээр бид дуулгавартай байж чадна.

Хоёрдугаарт, Бурханы хаанчлалыг өөрийн хүчин чармайлтаар олж авахыг оролдох нь урхи төдийгүй хэт нухацтай хандвал хүнд дарамт болдог. Энэ бол хуулийн урхидалт юм.

Бидний хүсэл шийдвэрээс улбаалан Есүс бидний дотор дуулгавартай байдлыг бий болгоход, дуулгавартай байдал нь чухал болохыг бид ойлгодог. Түүнчлэн дуулгавартай байдал нь зүгээр л бидний магтууштай зан чанар биш харин Бурханаас бидэнд өгсөн бэлэг гэдгийг ухаардаг.[10]

Дуулгавартай байдал нь бидний аврал болон Бурхантай харилцах харилцаанаас үүдэн гарах ёстой үр дүн буюу үр жимс бөгөөд энэ нь авралын урьдчилсан шаардлага биш юм. Аливаа хүн Есүс дээр ямар ч шаардлага хангалгүйгээр зүгээр л байгаагаараа очиж болно. Гэхдээ хэн ч байгаагаараа үлддэггүй. Хулгайч хүн итгээд аврагдлаа гэхэд тэр хүн хүмүүсээс үргэлжлүүлэн хулгай хийж болно гэж үзэх үү?

Илүү дээр Нэгэнд бид өөрсдийгөө болон өөрсдийн асуудлаа өгөх нь

Бурханы удирдамжинд өөрсдийгөө болон өөрсдийн санааширч байгаа зүйлсээ даатгах нь чухал билээ. Харин бид өөрсдийгөө хэт чухалд тооцож болохгүй. Энэ нь бидний амьдралын бүх талбарт хамаарна. Бид Агуу Бурханы гарт бүх зүйлээ даатгаж болох байтал ямар нэгэн зүйлээ авч үлдэх нь хэрэгтэй юу? Тэгэх нь ухаалаг хэрэг мөн үү?

Хэрэв бид Бурханаар бүхий л хэрэгцээгээ хангуулж, халамжлуулж, дайснаасаа хамгаалуулж, хамгийн сайн замаар явахыг хүсвэл Түүний дуу хоолойг дагаж, Түүний сонгосон замаар явах нь ухаалаг хэрэг юм. *"Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн*

10 *Шаббат Хичээл,* 2011 оны 3 сарын 31

бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно" (Сургаалт үгс 3:5,6).

Өнөөгийн бид энэ зөвлөгөөг маш сайн ойлгодог. Олон жолоо барьдаг хүмүүс зам заагч системийг ашигладаг. Бид энэ системд итгэж найддаг. Гэхдээ итгэж найдна гэхээр оюун бодлоо идэвхгүй болгоно гэсэн үг биш. Бид идэвхтэй байх хэрэгтэй бөгөөд бас жолоогоо барих ёстой. Замд явахдаа бид бүх замыг санах ойдоо багтаасан "Чиглүүлэгчтэй" холбогдож, тийнхүү биднийг түгжрэлтэй үед тойруу замаар явсан ч, хурдан явсан ч, удаан явсан ч хааш эргэхийг минь хэлж өгдөг. Бурханы нигүүлслээр бид амьдралынхаа туршид бурханлаг "Заагч системээр" чиглүүлэгддэг. Тиймээс бид бүхий л зүрх сэтгэлээрээ гайхамшигт диваажингийн Удирдагчид найдах нь чухал юм. Тэрээр биднийг зөв чиглүүлнэ гэж амласан. Мөн Тэрээр үүнийг нэр төрөөрөө батлан даасан билээ. *"Тэр миний сэтгэлийг сэргээдэг. Тэр Өөрийнхөө нэрийн төлөө Зөвийн замаар намайг хөтөлдөг"* (Дуулал 23:3). Тэгэхээр дуулгавартай байх нь бидний хүслээс бүрэн хамаарч байна.

Бурханлаг хууль буюу байгалийн хууль болон сүнслэг хуулийг дагах нь хүн бүрт эерэг үр дүнг авчирдаг. Итгэгч бус хүмүүс хүртэл мөн адил энэхүү бурханлаг хуулиудыг дагах аваас сайн үр дүн мэдрэх болно. Би үүнийг ердийн ивээл гэж нэрлэдэг. Харин сүнслэг хуулийг дагавал илүү их зүйл, бүр гайхамшиг хүртэл тохиолдож болно. Үүнийг би ер бусын ивээл гэж нэрлэдэг.

Итгэл болон дуулгавартай байдал нь бие биенийгээ баяжуулдаг. Иаков 2:22 дээрээс бид дараах зүйлсийг уншдаг: *"Итгэл нь түүний үйлстэй хамт ажиллаж байсныг, итгэл нь үйлсээр гүйцэд болсныг чи харж байна уу?"* Бурханд итгэх итгэл нь дуулгавартай байдлыг дэмждэг. Мөн дуулгавартай байдал нь Бурханд итгэх итгэлийг дэмждэг.

Деннис Смитийн эшлэлийг дахин хэлье: "Хэн нэгэн Ариун Сүнсээр дамжуулан Бурхантай дотно харилцаатай байхад дуулгавартай байдал нь зүрх сэтгэлээс зөнгөөрөө гардаг."[11]

Бид дуулгавартай байдлыг зөв ойлгоход Бурханы хуулийн талаарх Дуулал 19 болон 119-р бүлэг гайхалтай санааг өгдөг. Энэ хэсэгт аврал болон Бурханы хууль хамтдаа оршдог болохыг харуулдаг. Аврагдсан хүн Бурханы хуулийг үнэлдэг бөгөөд Ариун Сүнсээр дамжуулан Есүстэй хамт амьдрах үедээ баяр хөөртэйгөөр дуулгавартай байдаг. Дуулал 119-р бүлгийн санааг махан биеийн итгэгч хүн ойлгохгүй гэдэгт би итгэлтэй байна. Магадгүй тэд үүнийг хэтэрхий санаа гэж үзэх байх. Харин нөгөө талд буюу сүнслэг итгэгч хүн магтан дуучийн бичсэн зүйлийг ойлгож чадна.

11 Деннис Смит, *40 Өдөр:* Дахин ирэлтэд бэлтгэх залбирал ба мөргөл (R&H 2009) х. 21, 22

"Бид Бурханы илгээсэн гэрэл дотор өдөр бүр алхаж, мөн Түүний шаардлагуудыг дуулгавартай дагах хүсэлтэй байх аваас бидний мэдлэг туршлага өргөжиж, Есүс Христийн дотор төлөвшсөн эрэгтэй эмэгтэй хүмүүс болж өсдөг."[12]

Бурхан хэр их дуулгавартай байдлыг хүсэмжилдэг вэ?

Есүс намайг хэр хэмжээнд дуулгавартай байгаасай гэж хүсдэг вэ? Бага зэрэг үү, их хэмжээнд үү эсвэл бүрэн дүүрнээр үү?

Гэтлэл 4:24-26 дээрх Мосегийн амьдралаас маш тодорхой жишээ харагддаг. Мосе Медианы цөлд байхдаа Израиль хүмүүсийг Египетээс гаргах тушаал авдаг. "Тийнхүү Мосе Медианы цөлөөс Египет рүү явах замдаа Бурханы аймшигтай дургүйцэлтэй тулгардаг. Түүнд тэнгэр элч үзэгдэж түүнийг устгаж ч магадгүй талаар хэлдэг. Өөр ямар ч тайлбар өгөгдсөнгүй, тэгтэл Мосе Бурханы нэг шаардлагыг хайхраагүй орхисон гэдгээ санажээ. Тэрээр бага хүүгийнхээ хөвч хөндөх ёсыг эхнэрийнхээ итгэл үнэмшлээс болоод хийгээгүй байв. Тэгээд нэн даруй жаал хүүгийнхээ хөвчийг хөнджээ." ... Тийнхүү тэнгэр элч түүнд цааш явахыг нь зөвшөөрдөг. Мосе зорилгоо биелүүлэхийн тулд Фараон дээр очсоноор өөрийгөө маш аюултай нөхцөл байдалд оруулж байв. Түүний амьдрал зөвхөн ариун тэнгэр элчүүдийн гарт байлаа. Хэрэв тэр шаардлагыг үл хайхарсан бол амь нас нь эрсдэлд орж, Бурханы тэнгэр элчүүдээр хамгаалуулж чадахгүй байсан юм."[13]

Энэ үйл явдлаас сурч болох сургамжийг *Эцэг Өвгөд ба Эш Үзүүлэгчид* номонд үргэлжлүүлэн бичжээ: "Христийн дахин ирэлтээс өмнө тохиох хүнд хэцүү цаг үед зөвт хүмүүс тэнгэр элч нарын хамгаалалтад байх бөгөөд харин Бурханы хуулийг зөрчигчдөд ямар ч хамгаалалт байхгүй байх болно. Бурханлаг зарчмын нэгийг нь л зөрчихөд тэнгэр элч нарын хамгаалалтаас гардаг.[14]

Бурханы бүх хууль тушаалыг сахих нь бидний аюулгүй байдал, аз жаргал, сайн сайхны төлөө юм. Адам, Ева хоёр энгийн нэг нүглээс болж Еден цэцэрлэгийг орхих ёстой болсон. Энэ бол хэр их дуулгавартай байх ёстой вэ гэдэг асуултанд өгсөн хангалттай тодорхой хариулт гэж би бодож байна. Христ бидний дотор дуулгавартай байдлыг бий болгож, энэ нь бидний хийх дуртай зүйл болдог. Энэ бүхнийг бодоход Бурхан бүх зүйлд дуулгавартай байхыг биднээс хүсдэг. Есүс дэлхий дээр хүн байхдаа үйлдсэн шигээ бидний дотор Бурханы хүслийг гүйцэлдүүлэхийг хүсдэг. Хүн

12 Элен Уайт, *Залуучуудад Хүргэх Мэдээ,* х. 15, 16.

13 Элен Уайт, *Эцэг Өвгөд ба Эш Үзүүлэгчид,* х. 255, 256.

14 Дээрх номтой адил., х. 256.

байхдаа гаргадаг байсан Түүний хандлага бол: *"Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, Түүний хайр дотор байдгийн адил, та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно"* (Иохан 15:10).

Цаашилбал, хэрэв бүрэн дүүрэн дуулгавартай байдал нь энэ дэлхийн болоод ирээдүйн мөнхийн амьдралд бүрэн аз жаргал авч ирдэг юм бол дуулгавартай байдал багасах нь ивээлээ алдахад хүргэнэ гэдэг нь тодорхой юм. Бурханы хаанчлалд буй хэн бүхэн баяр хөөртэйгөөр Бурханыг даган хүндэтгэх учиртай. Тийнхүү хайр ба эв зохицол нь бүх бүтээлд байх болно.

Сүүлийн үгс

Иеремиа 7:23 дээр энэ сэдвийг бүхэлд нь дүгнэсэн байна. Израильчуудыг Египетээс гарах үед эдгээр үгс өгөгдсөн: *"Миний дуу хоолойг дагагтун. Тэгээд Би та нарын Бурхан болж, та нар Миний хүмүүс болно. Та нар сайн байхын тулд Миний та нарт тушаасан бүх замаар алхах болно."*

Эзэн бидэнд үнэхээр нандин амлалтыг энд өгчээ. Түүний үгийг дагавал юу гэж амласан бэ? *"Би та нарын Бурхан байж, та нар Миний хүмүүс болно"* гэсэн. Биднийг өөрсдийнхөө сайн сайхны төлөө Түүний бүхий л замаар явах хэрэгтэй гэдгийг Тэрээр нэмж хэлдэг. Бид энэ эшлэлийг дуулгавартай зүрх сэтгэлээс гарах залбирлын амлалт байдлаар ашиглаж болно.

Элч Иоханд юу тохиолдсон бэ?

Бид Есүсийн дагалдагч Иоханы амьдралаас итгэлийн дуулгавартай байдлын гайхалтай үр дүнг хардаг. *Христэд Хүрэх Зам* номоос бид дараах зүйлсийг уншдаг: "Өдрөөс өдөрт тэрээр Багшийгаа хайрлах хайрынхаа улмаас өөрийгөө онцлохоо больж, зүрх сэтгэл нь Христэд татагдаж байв. Түүний өс хонзон санасан, ууртай түргэн зан чанар Христийн өөрчлөгч хүчинд бууж өгчээ. Ариун Сүнсний сэргээх нөлөө түүний зүрх сэтгэлийг шинэчилжээ. Христийн хайрын хүч зан чанарын өөрчлөлтийг авчирчээ. Энэ бол Христтэй нэгдсэний үр дүн гэдэг нь тодорхой юм. Христ зүрх сэтгэлд орох үед хүний мөн чанар бүхлээрээ өөрчлөгдөн шинэчлэгддэг. Христийн Сүнс ба хайр нь зүрх сэтгэлийг зөөллөж, сүнсийг номхруулж, бодол санаа болон хүслүүдийг маань Бурхан уруу, диваажин өөд хөтөлдөг."[15]

"Бурханы үгийг дагадаг хүн бүр Эзэний баяр хөөр, амар тайван болон Түүний хүч чадлыг эзэмшдэг байхаар Эзэн тогтоосон."[16] Бүх итгэгч

15 Элен Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 73.

16 Элен Уайт, In Heavenly Places (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 1999), p. 53.

итгэлийн дуулгавартай байдлын агуу баяр хөөрийг мэдрээсэй хэмээн би хүсч, залбирч байна. Ариун Сүнс болон Христээр дамжуулан итгэлийн дуулгавартай байдлын агуу ялалтыг Эзэн Бурхан бидэнд хайрлах болтугай. *"Харин Бурханы хүслийг үйлдэгч нь мөнхөд оршмой"* (1 Иохан 2:17).

"Харин ЭЗЭНий хайр энэрэл Түүнээс эмээгчдийн дээр мөнхөөс мөнхөд болоод Түүний зөв шударга байдал үр хүүхдүүдийн үр хүүхдүүдэд хүрдэг. Энэ нь Түүний гэрээг сахигчдад, Түүний заавруудыг биелүүлэхээр санагчдад юм" (Дуулал 103:17,18).

Бид дуулгавартай байдлын агуу алхмын талаар сонсохыг хүсч байна.

Ариун Сүнс оргосон ялтанг шорон руугаа буцаж очихыг ятгажээ. Би Адвентист гэр бүлд төрсөн ба 19 настайдаа усан баталгаа хүртсэн билээ. Гэвч би 2016 онд хүн амины хэргээр 43 жилийн ял авсан. Одоо би 5 дахь жилдээ ялаа эдэлж байна. Надад 2017 оны 3 сард шоронгоос оргох боломж гарсан юм. Эхний Шаббат өдрийн дараа нэг эмэгтэй надад *"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* номыг харуулав. Тийнхүү Даваа гаргт нь би тэр номыг Адвентист номын дэлгүүрээс худалдаж авлаа. Би тэр долоо хоногтоо номыг уншиж дуусгасандаа өөрийгөө гайхав. Амьдралынхаа туршид би дотоод сэтгэлдээ Ариун Сүнсгүй хоосон байдлыг мэдэрч байснаа ойлгов. Тэгээд би бүхий л амьдралаа Есүст зориулсан юм. Би 2018 оны 10-р сард эргээд шорон уруугаа буцав. Намайг оргосны төлөө ялласангүй. Хамгийн сайхан нь гэвэл би одоо ял эдлэхдээ Агуу Бурханы өмнө байгаа билээ. Би хамгийн агуу шүүгчид давж заалдсан. Энэ номыг уншсаны дараа би маш их өөрчлөгдөж, үнэхээр ивээгдсэн: Бурханы хувьд ямар ч найдваргүй нөхцөл байдал гэж байдаггүй. Би одоо залбирлын үйлчлэлийн удирдагч болсон. Бараваги шоронгийн хоригдлуудад тэр номыг тарааж өгсөн. Маш олон хоригдол номыг уншсанаараа өөрчлөгдсөн билээ. Би Эзэн Есүс Христэд үйлчилж байгаадаа маш их баяртай байна. Энэ ном бидний хувьд жинхэнэ ивээл болсон юм."[17]

17 Гэрчлэл # 91 at www.steps-to-personal-revival.info - Experiences

Залбирал: “Аваа Та хязгааргүй мэргэн ухаан, агуу хүч болон гайхамшигтай хайр ивээлээрээ биднийг хамгийн сайн сайхан амьдруулахын тулд биднийг бүрэн чиглүүлсэнд талархаж байна. Та бидний төлөө бүх зүйлийг сайхан бүтээсэн. Би үүний төлөө Таныг магтаж байна, бас талархмаар байна. Таны арга замуудад бүрэн найдахад минь туслаач. Бүх зүйлд дуулгавартайгаар мөн бүрэн бууж өгсөн сэтгэлээр Таныг дагахад минь туслаач. Амен.

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Бидний дотор бурханлаг ажил явагдахын тулд бидний зүгээс юу хийх ёстой вэ?*

   _____

   _____

2. *Үнэнийг зүгээр л хүлээн зөвшөөрөх болон итгэлтэй байхын хооронд ямар ялгаа байдаг вэ?*

   _____

   _____

3. *Хэзээ бид хүлээн зөвшөөрөх нь чухал байдаг вэ?*

   _____

4. *Дуулгавартай байдал нь яагаад бидэнд агуу их ивээл болдог вэ?*

   _____

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Бурханлаг ажилд өөрсдийнхөө оролцох үүргийг илүү их мэдэхийн төлөө*
  2. *Жинхэнэ итгэл болон зүгээр хүлээн зөвшөөрөх хоёрыг ялгахын төлөө*
  3. *Итгэлийн дуулгавартай байдал болон ирэх ивээлүүдийн төлөө*
  4. *Бурханы удирдамж болон Түүний зарчмуудад бүрэн итгэхийн төлөө*

ЕСҮСЭЭС ИРДЭГ СЭТГЭЛ ТАТАМ ИТГЭЛ

Итгэгчид нэгдмэл байдалд хэрхэн хүрэх вэ?
Ямар зүйл бидний итгэлийг бусдад болон гэр бүлд маань сонирхолтой болгодог вэ?
Бидний дотор гарсан ямар өөрчлөлт бидний гэрч болгодог вэ?
Сунслэг сэргэлт нь сайн мэдээ түгээхэд хэрхэн нөлөөлдөг вэ?

Миний 40 өдрийн залбирлын хамтрагч нэг удаа ингэж хэлсэн юм: "Би сэтгэл татам итгэлтэй болохыг маш их хүсдэг. Тэгснээр миний хүүхдүүд бас Христийг дагах болно."

Валест амьдардаг Мари Жонес хэмээх нэгэн охин долоо хоногт нэг удаа хол байдаг гэрийнхэндээ очиж хамт Библи судалдаг байлаа. Үүнийг 10-15 нас хүртлээ хийжээ. Тэрээр зүрх сэтгэлээсээ Библид хайртай байв. Тийнхүү өөртөө Библи худалдаж авахын тулд тэрээр олон төрлийн ажил хийж, зургаан жилийн турш зоос бүрийг хадгалжээ.

Мари арван зургаа хүрээд Библиэ худалдаж авахын тулд сүмийн пастортой уулзахаар хорин таван милл газрыг хөл нүцгэн алхжээ. Гэтэл пасторт хоёр Библи байгаа боловч өөр хүмүүст өгөхөөр амласан байгаа гэж хэлэв. Мари цурхиран уйллаа. Пастор түүнээс яагаад уйлж байгааг асуув. Тэгтэл тэрээр зургаан жилийн турш Библи худалдаж авахын тулд хэрхэн мөнгө цуглуулсан тухайгаа ярив. Пастор татгалзахын аргагүй байдалд орж, Библиэ түүнд өглөө. Тэрээр баяр хөөрөөр дүүрэн гэр лүүгээ буцжээ.

Охины хувьд Библи сэтгэл татам байсан уу? Эсвэл итгэл бишрэл нь сэтгэл татам байсан уу?

Дашрамд дурдахад, энэ үйл явдал 1800 онд болсон юм. Энэ явдал пасторын сэтгэлийг маш ихээр хөдөлгөсөн тул дэлхийн анхны Британи болон Гадаад Библийн нийгэмлэгийг байгуулах алхмыг хийлгэжээ. Хожим нь өөр олон Библийн нийгэмлэг байгуулагдсан. Энэ бүхэн жаахан охин

Библийг маш ихээр хайрлаж, нэгийг авахын тулд амьдралаа зориулснаас үүдэлтэй юм. Сэтгэл татам итгэл нөлөө бүхий байдаг.[1]

"Сэтгэл татам" гэдэг үгийн утга учир

Толь бичигт сэтгэл татам гэдэг үгийг шохоорхом, сонирхол төрүүлмээр, хайрламаар мөн хүсмээр гэж тодорхойлжээ. Ийм итгэл бишрэлтэй байхыг хэн хүсэхгүй байх вэ? Энэ талаар үнэхээр их боддог хүн сэтгэл татам, шохоорхом, итгэлтэй байхыг хүсэх болно гэдэгт би итгэж байна.

Ийм итгэлийг би хэрхэн хүсэх вэ? Ийм итгэл ямар харагдах ёстой вэ?

- Энэ нь амьдралд бат бөх, найдвартай суурийг санал болгодог байх ёстой.
- Алдаа дутагдал, худал зүйл дээр биш үнэн дээр суурилсан байх ёстой.
- Энэ нь хүний сургаалтай холилдоогүй, харин мэргэн ухаантай хайрын Бурханы илчлэлт дээр суурилсан байх ёстой ба тийнхүү бидний сайн сайхны төлөө үйлчлэх учиртай.
- Энэ нь бүхэлдээ үнэмшилтэй бөгөөд маш их баяр хөөрийг авчирдаг байх ёстой.
- Энэ нь бидний амьдралд тодорхой давуу талыг авчрах ёстой.
- Энэ нь өвчин, зовлон шаналал, үхэл гэх мэт хүнд нөхцөл байдалд намайг дэмжих чадвартай байх ёстой.
- Энэ нь мөнхийн найдварыг илэрхийлэх ёстой.

Эдгээр бүх зүйл нь бидний дотор тохиолддог зүйлтэй холбоотой байдаг. Гэхдээ сэтгэл татам итгэл нь цаашид илүү их нөлөө үзүүлэх ёстой. Залбирлын хамтрагч маань, "Хүүхдүүдээ Христийг дагадаг байлгахын тулд би сэтгэл татам итгэлийг хүсдэг" гэж хэлсэн юм.

- Сэтгэл татам итгэл нь бидний хайртай хүмүүс болон бусад хүмүүсийн сонирхлыг татаж, тийм итгэлтэй болохыг хүсэхэд хүргэх ёстой.

Сэтгэл татам итгэл гэж юу гэсэн үг вэ?

Сэтгэл татам итгэл гэдэг нь сүнслэг итгэл бишрэл буюу Ариун Сүнсээр дамжуулан Есүс Христтэй хамт амьдрах амьдрал юм. Бид дараах Библийн эшлэлийг оюун бодолдоо хадгалах хэрэгтэй: *"Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, бүх*

1 Википедиагаас авав, "Мари Жонес"

ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай" (Ефес 3:16,17,19).

Эдгээр эшлэлүүдэд Бурханы Сүнс биднийг хүчирхэгжүүлдэг. Мөн Христ бидний дотор амьдарсанаар бидний доторх хайрын мөн чанар дэлгэрэх болно гэж хэлжээ. Энэ нь биднийг боолчлолоос маань чөлөөлдөг. Тэгээд бид Бурханы хүүхдүүд байх агуу эрх чөлөөг мэдэрнэ.

Есүс хэлжээ: *"Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй"* (Иохан 14:6). Есүс миний зүрх сэтгэлд Ариун Сүнсээр дамжуулан байх үед Тэрээр Эцэгт хүрэх зам маань, үнэнд хүрэх удирдамж маань болдог. Тэр бол амьдралын хамгийн өндөр чанарт хүрэх арга зам юм.

Сэтгэл татам итгэлийг Есүс хэрхэн тодорхойлсон бэ?

Есүс ямар ч хүний өгч чадахгүй бүрэн дүүрэн байдлын талаар ярьсан. Энэ байдал нь дотоод сэтгэлийн амар амгалан, жинхэнэ баяр хөөрийг бий болгодог, учир нь хайр ба амар тайвны Бурхан зүрх сэтгэлд оршин суудаг юм. Энэ байдал нь гадаад нөхцөл байдлаас хамаарахгүй; харин Бурханы хүч чадалд хүүхэд мэт итгэх итгэлээс шалтгаалдаг. Паул Есүсийн дагалдагчдад хандан дараах эшлэлийг бичжээ: *"Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай"* (Ефес 3:19).

Есүс бидний зүрх сэтгэлд байх нь бидэнд хэрэгтэй зүйл юм. *"Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог. Түүн дотор та нар төгс болгогдсон. Тэр бол бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн нь мөн"* (Колоссай 2:9,10). Энэ бол амьдралдаа хүрч болох хамгийн дээд оргил билээ. Энэ бол Бурхан агуу хайраасаа бидэнд өгөхийг хүсдэг зүйл юм.

Иаковын худаг дээр байсан эмэгтэй энэ зүйлийг мэдэрсэн. Есүс энэ хүсэл хэрэгцээний биелэлтийг ойлгуулахын тулд өдөр тутмын амьдралаас жишээ авсан байдаг. Тэр үед ундны ус нь хүний хамгийн чухал, үнэ цэнэтэй зүйлийн нэг байв. Бид Есүсээр дамжуулан *"Мөнх амь хүртэл оргилох булаг"* дээр очдог (Иохан 4:14), бид тэр булгийн уснаас уувал хүсэл маань хангагдах болно.

Хүн бүр аз жаргалыг хүсдэг. Гэхдээ үнэн хэрэгтээ тэд Бурхантай харилцах хувийн харилцааг эрэлхийлж байгаа гэдгийг мэддэггүй юм, учир нь Номлогчийн үгс 3:11-д хэлснээр *"Тэр [Бурхан] тэдний зүрх сэтгэлд үүрд мөнхийг суулгажээ."* Бурхантай дотно харилцаагүй хүний зүрх сэтгэл хоосон байдаг. Үүний үр дүнд хүмүүс байнга улам ихийг хүсэн эрэлхийлсээр байдаг.

Есүс биднийг Өөрт нь итгэж найдаасай гэж хүсдэг. Түүнд итгэж найдсан хүний үр ашиг тодорхой байдаг, учир нь *"Надад итгэдэг*

хүний дотроос амийн усны гол урсах болно" (Иохан 7:38). Тэд бялхам амьдралаар амьдарч, сэтгэл татам байх ба тэдний нөлөөлөх хүч нь бусдыг хүчирхэгжүүлдэг.

Сэтгэл татам итгэл нь энэ дэлхий дээрх бүрэн дүүрэн, бялхам амьдрал уруу, мөн цаашлаад мөнх амьдралын илүү агуу, төсөөлшгүй амьдрал уруу хөтөлдөг.

Бурханы Үгэнд миний итгэл бусдын сэтгэлийг татдаг гэдгийг харуулдаг

Иохан 17:20–23 дээрх Есүсийн залбирлыг уншицгаая: *"Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна. Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Таны Надад өгсөн сүр жавхланг Би тэдэнд өгсөн билээ. Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэн, Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно."*

Есүс бүх цаг үеийн туршид амьдрах шавь нарынхаа нэгдмэл байдлын төлөө залбирсан. Ингэснээрээ Тэр миний бас таны төлөө залбирч байсан гэсэн үг. Есүс зөвхөн биднийг нэг нэгэндээ тусалж, харилцаа холбооноосоо сайн сайхныг мэдэрч байгаасай гэж залбираагүй. Тэрээр бас шавь нарынх нь нэгдмэл байдал дэлхийн бусад хүмүүсийг татаасай гэж залбирсан юм: *"Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно гэж хэллээ"* (Иохан 13:34,35). Шавь нарын нэгдмэл байдлаас дэлхий дараах гурван чухал зүйлийг мэдэж, мөн итгэх болно гэдгийг Есүс хэлсэн юм.

Дэлхий биднээс юуг анзаардаг вэ?

1. Итгэгчдийн дунд буюу сүмд орших хайр халамжийг хараад дэлхийн хүмүүс тэднийг Есүсийн шавь нар болохыг мэддэг. Энэ нь дэлхий биднийг харж байдаг гэсэн үг. Дагалдагчдын харилцаанд байдаг хайрын зан чанар нь Есүстэй харилцаа тогтоосны үр дүн болохыг дэлхийн хүмүүс ойлгодог. ("Үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно.")
2. Есүсийн шавь нар нэгдмэл байснаар дэлхийн хүмүүс Есүсийг Бурханы төлөөлөгч гэдэгт итгэдэг. ("Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ.") Энэ дэлхийн хүмүүс Есүст

итгэгчдийн хайрын харилцаанаас Есүс бол Бурханаар илгээгдсэн Аврагч гэдгийг ойлгодог.

3. Гайхалтай нь дэлхийн хүмүүс итгэгчдийн хайрын зан чанараас Бурхан тэднийг хайрладаг гэдгийг олж хардаг. ("Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно.")

Дүгнэлт, Есүсийн дагалдагчдын нэгдмэл байдлаар хүмүүс 1. Есүстэй харилцах харилцааг олж харах болно. 2. Бурхан Есүсийг илгээсэн гэдгийг мэдэх болно. 3. Бурхан тэдэнд хайртай гэдгийг мэдэх болно. Сүнсээр дүүрсэн, нэг нэгнээ гэсэн сэтгэлтэй итгэгчдийн улмаас Есүс дэлхий даяар танигдана. Есүс энэ нөлөөг зөвхөн сүнслэг итгэгчээр дамжуулан үйлдэж чадна.

Хүмүүс яагаад дагалдагчдын хайрын харилцаанаас Бурханы талаар ямар нэгэн юм сурдаг вэ?

Хүн бүр нэг нэгнээсээ ялгаатай байдаг. Бидний авьяас чадварууд ялгаатай: Эрчүүд эмэгтэйчүүд, хөгшин, залуу зэргээс шалтгаална. Бид ихэвчлэн өөр өөр боловсрол, соёл иргэншил, өссөн орчинтой байдаг. Бид бас ялгаатай зан чанар, үзэл бодол, туулсан амьдралтай билээ. Эдгээр ялгаанууд нь хүмүүс хоорондын харилцаанд ихэвчлэн дарамт үүсгэдэг. Энэ нь бас өрсөлдөөн тэмцэлдээн рүү чиглүүлдэг. Ийм учраас хүмүүс эв нэгдэлтэй, тус дэмтэй, хайр оршсон бүлэг хүмүүсийг гайхширч, мөн татагддаг ажээ.

Би Германы Мюнхен хотод пастор хийж байхдаа хамт бизнес эрхэлдэг байсан найзтайгаа уулзахаар хажуугийн жижигхэн хот уруу явсан юм. Тэр найз маань нэгэн өнөр өтгөн Адвентист гэр бүл амьдардаг гудамжинд байдаг байлаа. Намайг Адвентист гэдгийг мэддэг учраас найз маань надад "15-20 хүн хамтдаа нэг гэрт ямар ч зөрчил маргаангүйгээр эв нэгдэлтэй амьдардаг тэр гэр бүлийг гудамжныхан тэр даяараа гайхдаг" гэж хэлэв. Хөршүүд нь ямар нэгэн зүйл буюу сэтгэл татам итгэл бишрэлийг анзаарсан байлаа.

Хожим нь Германы нэгэн жижиг сүмийн гишүүн болсон Валтер Шланд өөр нэг жишээ ярив: Христэд итгэгч болохоосоо өмнө бид Румын уруу нүүхийг хүсэж, тийнхүү үерт автсан мужид очиж таарлаа. Бид дахиад 75 милл явах ёстой байсан боловч цааш явж чадсангүй. Тэгээд бид зам асуулаа. Тохиолдлоор бид Адвентист хүнтэй таарч тэрээр биднийг пастор Бирогийн гэр лүү дагуулж явсан юм. Тэдний гэр бүл биднийг гэртээ хонохыг урьсан бөгөөд бид талархалтайгаар зөвшөөрлөө. Энэ гэр бүлтэй хамт байх хугацаандаа би Христэд амьдралаараа бүүн өгч,

Адвентист болохоор шийдсэн цаг мөч байв. Энэ гэр бүл бие биетэйгээ их эв найртай, амар тайван орчинг бүрдүүлсэн, элдэг зөөлөн байсан ба гэр бүлийн мөргөл хийдэг байсан юм. Энэ нь миний сэтгэлийг ихэд хөдөлгөв. Би энэ байдлыг бас гэр бүлдээ мэдрэхийг хүссэн юм.[2] Энэ бол сэтгэл татам итгэл билээ.

Би Германы Регенсбург хотод амьдардаг байхдаа тодорхой бүлэг хүмүүс дээр олон удаа зочилдог байлаа. Харин тэдгээр гэр бүлүүдэд үргэлж дарамт шахалт болон зөрчил дүүрэн байдаг байсныг би анзаарсан юм. Харин тийм байдлаас ялгаатай, хайраар дүүрэн зүрх сэтгэлтэй хүмүүсийн гэрт зочилж, энэ бүхнийг мэдрэх нь хавьгүй илүү тааламжтай байдаг.

Сэтгэл татам итгэл нь яагаад зөвхөн Бурханы Үгнээс ирдэг вэ?

Сэтгэл татам итгэл нь зөвхөн Бурханы Үг болох Шинэ Гэрээ болон Хуучин Гэрээн дээр суурилсан байдаг.

Есүс, *"Бичвэрт хэлсэнчлэн надад итгэгчийн дотроос"* гэж хэлэхдээ Хуучин Гэрээг хэлж байсан, учир нь тэр үед зөвхөн нэг Бичвэр байсан (Иохан 7:38). Тэрээр Иохан 17:14 дээр Эцэгийнхээ талаар ярихдаа үүнийг илүү тодорхой болгодог: *"Би Таны үгийг тэдэнд өгсөн."* Мөн 17-р эшлэлд: *"Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн"* гэж онцолдог.

Дэлхий дээрх бүх шашин хүмүүсийн бодож олсон бурханд хүрэх эсвэл бурхдад хүрэх зам байдаг. Харин хүмүүсийн бодож олоогүй буюу Бурханы Өөрөө илчилсэн цорын ганц итгэл бишрэл бол Библийн итгэл юм. Бурхан Өөрөө хайр бөгөөд Түүнд хязгааргүй мэргэн ухаан, чадварууд байдаг ба Тэрээр бүх зүйлийг бидний сайн сайхны төлөө бүтээсэн. Тийм учраас Библийн итгэл бишрэл хамгийн сэтгэл татам итгэл юм. Үнэндээ энэ бол дэлхий дээрх цорын ганц сэтгэл татам итгэл билээ. Энэ нь биднээс Библийг зөвөөр ойлгож, Сүнсний хүчээр түүнийгээ үйлдэж амьдрахыг шаарддаг. Арван онгон эмэгтэйн түүхээс харвал сүмийн бараг талд нь ийм итгэл байдаггүй.

Бид Есүст итгэх итгэлээр дамжуулан баяр хөөр амар тайвныг мэдэрч, сүнслэг цангаагаа тайлдаг. Бидний Бурхан Өөрийнхөө хайрыг бусдад харагдахуйцаар бидний амьдралд ил байгаасай гэж хүсдэг. Энэ байдал нь бидний итгэлийг тэдэнд сэтгэл татам болгодог.

2 BWgung, news magazine from the Seventh-day Adventists in Baden-Württemberg (Germany), Nr. 6/2012, S. 24.

Дагалдагчид эв нэгдэлтэй байх нь хэрхэн боломжтой вэ?

Гэрлэлт болон гэр бүл нэг байдаг шиг сүм болон үйлчлэлд нэгдмэл байх хэрэгтэй. Есүс ингэж хэлжээ: *"Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Таны Надад өгсөн сүр жавхланг Би тэдэнд өгсөн билээ"* (Иохан 17:22).

Есүс бидэнд юу өгсөн бэ? Сүр жавхлан!

Энэ нь юу гэсэн үг вэ? Сүр жавхлан гэдэг үг нь Библид олон янзаар ашиглагдаг. Нэгдүгээрт, энэ үг нь Бурханы агуу болон гайхамшигтай байдлыг илэрхийлэгдэхэд ашиглагдсан байдаг. Хоёрдугаарт, бүтээлийн алдар гэдэгт ашиглагдсан байна. Гуравдугаарт, Бурханы гайхалтай хайрын мөн чанар гэдгээр ашиглагдсан. Бид Мосегийн Бурханд хэлсэн үгсийг Гэтлэл 33:18,19-с харж болно. *"Алдраа надад үзүүлээч, гуйж байна"* гэхэд Эзэн хариуд нь *"Би бүх сайн сайхнаа өмнүүр чинь өнгөрүүлэх болно"* гэдэг.

Бурханы сүр жавхлан бол хайр, сайн сайхнаар илэрдэг Түүний зан чанар юм. Сайн сайхан байдал нь үйлдлээрээ хайранд тусалж байдаг. Энэ нь Есүс биднийг нэгдмэл байлгахын тулд бидэнд Бурханы сүр жавхланг өгсөн гэж хэлснийг ойлгоход тусалдаг. Нэгдмэл байх хамгийн чухал нөхцөл бол итгэлцэл болон хүндлэлтэй хосолсон хайр юм. Сайн мэдээ түгээх Бурханы арга зам бол биднээр дамжуулан хүн төрөлхтнийг хайрлах явдал. Үүнийг бид агапе хайр гэж нэрлэдэг бөгөөд энэ нь Бурханы хайр юм. Энэ хайрыг л Бурхан биднээр дамжуулан хуваалцахыг хүсдэг.

Ариун Сүнс буусны дараа эртний сүмд гайхалтай зүйлс тохиолдсон байдаг: *"Ийнхүү залбирч байтал тэдний цугларан байсан газар нь доргин чичирхийлэв. Тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үгийг зоригтойгоор ярьж эхлэв. Итгэсэн тэдгээр хүмүүс нэг зүрх, сэтгэлтэй байсан бөгөөд тэдний хэн нь ч өөртөө байгаагаа минийх гэдэггүй, харин тэдний бүх юм нь нийтийнх байв. Элч нар Эзэн Есүс [Христийн] амилсныг агуу хүчээр гэрчилж байсан бөгөөд тэдний бүгдийн дээр бялхам их нигүүлсэл байсан болой"* (Үйлс 4:31–33).

Эв нэгдэл бол нэгхэн төрлийн зүйл биш

Эв нэгдэл гэдэг нь оюун санаа, зорилго, мөн чанарын нэгдмэл байдал юм. Хэдий тийм ч гэсэн хүн нэг бүрийн хувийн онцлог зан чанарыг хадгалан үлддэг буюу бидний хувийн зан чанар үгүй болдоггүй гэсэн үг. Эв нэгдэл бол өөр өөр зан чанартай ялгаатай хүмүүсийн нэгдэл юм. Ялгаатай хүмүүс нэгдмэл байдаг нь үнэхээр гайхшрал төрүүлэм билээ.

Элен Уайт хэлэхдээ: "Бурхан Өөрийн Хүүгээ дэлхийд илгээсний хамгийн хүчтэй гэрчлэл бол сүмийг бүрдүүлдэг янз бүрийн байр суурьтай

хүмүүсийн нэгдэл, зохицол юм. ... Христэд итгэгч хүмүүсийн итгэл нь тэдний амьдралд ариусгах нөлөө үзүүлдэг эсэхийг итгэгч бус хүмүүс ажиглан харж байдаг."[3] Мөн өөр нэг хэсэгт ийнхүү бичжээ: "(дагалдагчдын) зан чанарын өөрчлөлт нь дэлхий ертөнцөд гэрчлэл болдог."[4]

Эв нэгдэлд хэрхэн хүрэх вэ?

Дагалдагчдын нэгдмэл байдал нь Ариун Сүнсээр дамжуулан тэдний дотор оршигч Христийн нөлөөгөөр бий болдог.

Есүс дараах зүйлсийг хэлжээ:

Иохан 17:21: *"Ингэснээр тэд бас бидний дотор нэг байх юм."*

Иохан 17:23: *"Би тэдний дотор мөн та нар Миний дотор байна."*

Иохан 15:4: *"Миний дотор байгтун, Би чиний дотор байна."*

Харин элч Паул ингэж хэлжээ.

Колоссай 1:27: *"Алдрын найдвар болох Христ таны дотор байна."*

Галат 2:20: *"Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна."*

Ийм маягаар Христ таны дотор мөн миний дотор байгаа үед нэгдмэл байдал боломжтой болдог. Харин бид Ариун Сүнсээр дүүрэхгүй бол ийм зүйл боломжгүй юм. Тиймээс бид бие биедээ "Сайхан" хандах учиртай. Элен Уайт ингэж бичжээ: "Бид бүгд нэг бодол, нэг зорилготой байхыг хичээнгүйлэн эрэлхийлэх ёстой. Зөвхөн Ариун Сүнсний баптисм биднийг ийм байдалд хүргэж чадна. Бүгдээрээ зүрх сэтгэлдээ Ариун Сүнсийг хүлээн авахад бэлдэж, бидний дунд агуу үйлс биелэгдэхийн төлөө өөрсдийгөө үгүйсгэцгээе. ... "[5]

Өөр нэг хэсэгт ийнхүү бичжээ: "Бурханы хүмүүс Сүнсэн дотор нэгдэхэд Еврей үндэстний нүгэл болж байсан бүх фарисай үзэл, өөрийгөө зөвтгөх байдал зүрх сэтгэлээс зайлуулагдах болно. Христийн зан чанар нь Түүний биеийг бүрдүүлэгч бүх хүний дээр байх болно, тийнхүү Түүний хүмүүс шинэ дарс хийх боломжтой шинэ лонх болж, доторх дарс нь шилийг хагалахгүй. Үеүдийн туршид нууцлагдмал байсан нууцыг Бурхан мэдүүлэх болно. Тэрээр *'харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн'* (Колоссай 1:27)."[6]

---

3 Элен Уайт, *Элч Нарын Үйлс,* х. 549, 550

4 Элен Уайт, *Эш Үзүүлэгчид ба Хаад,* х. 233.

5 Элен Уайт, *Та Нар Хүчийг Авна,* 11-р сарын 5; х. 318.

6 Элен Уайт, *Сонгомол Мэдээнүүд,* 1-р ном, х. 386.

Тэд эв нэгдлийг олсон нь

Бид эв нэгдэлгүй мэдрэмжийг дүүргийнхээ өөр нэг сүмээс мэдэрсэн юм. Өмнө нь хариуцаж байсан хүн бидэнд "Та хоёр энэ сүмийг авч явахад маш их зориг хэрэгтэй. Энэ сүм бол жинхэнэ минжүүлсэн талбай л гэсэн үг" гэж хэллээ. Бид тэр даруйдаа л сүмээс хүнд дарамттай байдлыг мэдэрсэн юм. Сүмд хэрүүл, хагарал, гоморхол, уучлал байхгүй нөхцөлтэй байв. Хяналтгүй сэтгэл хөдлөл, уур уцаар, хувиа хичээх байдал нь сүмийг харанхуйлан хучсан байв. Сүмийн гишүүд үл уучлах аалзны тор шиг байдалд орооцолдож, түүнийгээ яаж шийдэхээ мэдэхгүй байгааг харахад гунигтай байлаа. Эсийн бүлэг байгуулаад бүлгээрээ *"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* номыг судлахаар тараан өгөв. Бүлгийн гишүүд эерэг байж номыг талархалтайгаар хүлээн авлаа.

Энд ч бас бүлгийн гишүүд 10 өдрийн залбирал хийж, тус тусдаа мацаг барин залбирцгааж байлаа. (Деннис Смит: *Ариун Сүнсний баптисмийг хүртэх 10 өдрийн залбирал ба мөргөл*) Эцэст нь энэ цуглааныг сүм даяараа хийх хүсэлтэй болов. Эсийн бүлгийн хүмүүс маань бүр өглөөний 4 цагт мөргөл хийх болов. Эхэндээ цөөхөн хүн ирдэг байсан боловч, яваандаа их олон хүн ирж, тэнд гайхалтай амар амгалан, сүнслэг орчин үүсэн бий боллоо. Бурхан тэнд ажлаа хийж байлаа. Бурхан ийм маягаар тухайн сүмийг хийхэд хэцүү байсан зүйлд нь гайхалтайгаар бэлдсэн: чин сэтгэлийн уучлалын алхам.

Эцэстээ хана нурж, хүмүүс нэг нэгнээсээ уучлалт гуйв. Зарим нь хоорондоо хэрэлдсэн хүмүүс дээрээ очиж бие биенээсээ уучлалт гуйгаад нэг нэгнийгээ тэврэв. Тэдний нулимс асгарч, гунигтай царайнууд нь аз жаргалтай болж, зүрх сэтгэлд нь хайр эргэн ирж байлаа. Ийм зүйл болохыг харж бас мэдрэх нь үргэлж сайхан байдаг. Зөвхөн Бурхан хүмүүсийг Ариун Сүнсээр дамжуулан удирдан чиглүүлж чаддаг. Минжүүлсэн талбайд хүртэл найдвар бий. Пастор Ф. Х. болон түүний эхнэр, #85b

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Сэтгэл татам гэдэг нь юу гэсэн үг вэ? Сэтгэл татам итгэл гэж юу вэ?*

_____

_____

2. *Библийн хаанаас бид сэтгэл татам итгэлийн талаар олж унших вэ?*

_____

3. *Энэ төрлийн итгэл нь бодит амьдралд хэрхэн харагддаг вэ?*

_____

_____

4. *Итгэгчид эв нэгдэлтэй байгааг хараад хүмүүс юу олж мэддэг вэ?*

_____

_____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Бидэнд ивээл болдог сэтгэл татам итгэл нь бусдад мөн адил ивээл болохын төлөө*
  2. *Өдөр тутмын амьдралынхаа хаана нь сэтгэл татам итгэл байхгүй байгааг харахын төлөө*
  3. *Энэ гайхамшигтай итгэлд зориулан илүү их орон зай гаргахад туслах Бурханы хүч болоод удирдамжийн төлөө*
  4. *Таны итгэл бусад хүмүүсийг Бурханы ажилд нээлттэй байхад нөлөөлөхийн төлөө*
  5. *Христ бидний дотор амьдарч, мөн үргэлж тод харагдахын төлөө*

Бидний доторх ямар өөрчлөлтүүд бидэнийг гэрч болгодог вэ?

Христ миний дотор хэрхэн оршдог вэ?

Энэ талаарх тайлбарыг Ефес 3:16,17 дээрээс харж болно: *"Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилна ..."* Өмнө нь бид Христ бидний дотор Ариун Сүнсээр дамжуулан оршдог гэдгийг судалсан. Бидний доторх хүн "Өдрөөс өдөрт шинэчлэгдэж" (2 Кор. 4:16) эхэлсэн учраас өглөө бүр Есүст буун өгч, Лук 11:13 дээрх Ариун Сүнсээрээ дүүргэж өгнө гэсэн амлалтыг итгэлээрээ гуйн залбирах нь маш чухал юм.[1] Хүн бүрийн Христтэй нэгдмэл байдал нь жинхэнэ дагалдагч болоход чиглүүлдэг. Тэгэхээр Христийн дотор байх нь нэгдмэл байдлын үндэс суурь юм.

"Энэхүү нэгдмэл байдал нь Христэд итгэгчдийн дотор амьдарснаар тэдэнд өгдөг бэлэг билээ. ... Тиймээс нэгдмэл байдал нь хүн нэг бүрээс эхэлдэг."[2]

Есүс бидний дотор амьдарснаар бидэнд ямар нөлөө үзүүлдэг вэ?

Есүс бидний дотор байснаар дараах гол гурван нөлөөг бидэнд үзүүлдэг: Сүнсний үр жимс, Сүнсний бэлэг авьяас, гэрчлэх чадвар.

Нэгдмэл байдлыг амжилттай болгоход Сүнсний үр жимс болон бэлэг авьяас нэн шаардлагатай байдаг. Харин энэ хоёр нөхцөл нь гурав дахь нөхцөл болох Христийн тухай гэрчлэхэд чухал ач холбогдолтой. Бид дагалдагч болохын хувьд нэгдмэл байж, мөн гэрчлэлтэй байхад хувь хүн

1 Лук 11:13: "Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхөө мэддэг юм бол, тэгэх тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйдаг хүмүүст Ариун Сүнс өгөх нь дамжиггүй гэв."

2 Библи Судлалын Шаббат Хичээл, 2012 он 11 сарын 21

тус бүр өөрчлөгдөх шаардлагатай. Ийм үр дүн нь аврагдаагүй хүмүүсийг татаж, биднийг гэрчлэл болгон ашиглах Эзэний хүсэл юм. Бид гэрчлэлээрээ дамжуулан Есүсийн хамтрагчид болдог. Учир нь Тэрээр *"Алдагдсаныг олж, аврахаар ирсэн"* Лук 9:10.

Бүгдээрээ эдгээр гурван нөхцөлийг илүү дэлгэрэнгүй авч үзье:

1. Сүнсний үр жимс. *"Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал"* (Галат 5:22). Эдгээр бүх чанар бидний өдөр тутмын амьдралд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр нь гэрлэлт, гэр бүл, дагалдагчдын бүлэг, сүм болон үйлчлэлийн нэгдмэл байдлын чухал нөхцөл шаардлага юм.

Бидний дотор Бурханы мөн чанарыг бий болгоход нөлөөлдөг чухал нэг үр жимсний талаар Паул хэлсэн байдаг. Ефес 3:17 дээр *"Итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурилна"* гэж бичжээ. Түүний ярьж буй үр жимс бол хайр юм. Грекээр үүнийг агапе гэдэг. Энэ хайр бол Бурханы мөн чанар юм. Энэ нь хүн болон Бурханы төлөө хамгийн сайныг эрэлхийлж байдаг хувиа үл хичээсэн хайр юм. Бурханы хайрын үр жимсийг Эва вон Тайл-Винклер ийнхүү тайлбарладаг:

- Баяр хөөр бол баясаж буй хайр
- Амар амгалан бол амарч буй хайр
- Тэвчээр бол тэтгэж дэмнэж буй хайр
- Дөлгөөн байдал бол гэрэлтсэн хайр
- Сайхан сэтгэл бол тусалж буй хайр
- Итгэл бол найдаж буй хайр
- Номхон даруу байдал бол айдасгүй хайр
- Цэвэр ариун байдал бол ариун хайр

Сүнснээс өгөгддөг эдгээр шинж чанарууд бол хайр гэдэг нь тодорхой байна. Тийм учраас энэ эшлэлд үр жимсийг олон тоон биш ганц тооны нөхцөл дээр бичжээ. Элен Уайт эдгээр зан чанарын талаар ийн хэлжээ: Зан чанарын өөрчлөлт бол Христ таны дотор оршин байгааг дэлхийд харуулах гэрчлэл юм."[3]

2. Сүнсний бэлэг авьяас. Христ бидний дотор байснаар гардаг өөр нэг чухал нөлөөлөл бол Сүнсний бэлэг юм. Бурхан бидэнд олон төрлийн авьяасыг өгсөн. 1 Коринт 12 бүлэгт Паул сүмийн хүмүүсийг биеийн эрхтэнүүдтэй адилтган зүйрлэсэн байдаг. Биед олон төрлийн эрхтэн байдаг. Эрхтэн бүр сайн ажиллаж байх нь эрүүл саруул амьдралд чухал нөлөөтэй. Бид төрөл бүрийн авьяас чадвараараа бие биедээ үйлчлэх нь бидний үүрэг гэдгийг үүгээр харуулдаг. Энэ нь гэр бүл, жижиг бүлэг болон сүмийн амжилтад их үр нөлөөтэй. Хүн бүр өөр өөр үүрэг

3 Элен Уайт, *Эш Үзүүлэгчид ба Хаад,* х. 233.

даалгавартай. Бурхан бидэнд ялгаатай чадваруудыг өгдөг.

Шинэ Гэрээнд бичигдсэн бэлэг авьяасуудын жагсаалт нь бүрэн биш юм. Эртний сүмүүдэд маш олон бэлэг авьяас өгөгдсөн байсан: Мөн орчин үеийн сүмүүдэд ч өөр олон бэлэг авьяас бий.

Үгийн бэлгүүд	**Гайхамшгийн бэлгүүд**	**Үйлчлэлийн бэлгүүд**
Мэргэн ухаанаар ярих *1 Кор. 12:8*	(гайхамшигт) Итгэлийн бэлэг *1 Кор. 12:9*	Удирдах бэлэг авьяас *Ром 12:8; 1 Кор. 12:28*
Мэдлэгийн бэлэг *1 Кор. 12:8*	Эдгээх бэлгүүд *1 Кор. 12:9,28*	Ерөнхий үйлчлэлийн бэлэг *Ром 12:7*
Эш үзүүллэгийн бэлэг *1 Кор. 12:10,28; Ром 12:7*	Хэлээр ярих *1 Кор. 12:10,28*	Туслах бэлэг *1 Кор. 12:28*
Заах бэлэг *1 Кор. 12:10,28; Ром 12:7; Еф. 4:11*	Хэлийг тайлбарлах бэлэг *1 Кор.12:10,30*	Өгөх бэлэг авьяас *Ром 12:8*
Сайн мэдээний бэлэг *Ефес 4:11*	Сүнснүүдийг ялгах бэлэг *1 Кор. 12:10*	Энэрэл нигүүлслийн бэлэг *Ром 12:8*
Элчийн бэлэг *1 Кор. 12:28; Ефес 4:11*	Гайхамшигт хүчний бэлгүүд *1 Кор. 12:10,28*	Зочломтгой байдлын бэлэг *1 Петр 4:9*
Ятгах бэлэг *Ром 12:28*		Пасторын үйлчлэл хийх бэлэг *Ефес 4:11*

Johannes Mager, Auf den Spuren des Heiligen Geistes (Lüneburg: Advent-Verlag, 1999), S. 121.

Сүнсний үр жимс болон Сүнсний бэлэг авьяас нь бидний мөн чанар, үйлдэл, бодол, мэдрэмж, хэл яриагаар илрэн харагддаг. Ийм зүйл зөвхөн нэг арга замаар биеллээ олдог. Бид Ариун Сүнсээр дүүрэх ёстой.

Ариун Сүнсэн дотор амьдрахын гол тал нь Бурханд өдөр бүр бүрэн бууж өгч, Ариун Сүнсээр дүүрэхийн төлөө итгэлтэйгээр залбирах явдал юм. Ийм залбирлын жишээг *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номын 4-р бүлгээс харж болно. Ийм төрлийн залбирал ямар үр нөлөөтэй байсан талаар уншигчид өөрсдийн туршлагыг надад хуваалцсан билээ. Олон итгэгч ах эгч дүүс маань *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* номонд гарч

буй энэхүү жишээ залбирлаар өдөр бүр хамтдаа залбирсан. Би бас нэг найзтайгаа хамт энэ залбирлыг таван сарын хугацаанд залбирсан. Зөвхөн хувь хүн өөрчлөгдөөд зогсохгүй бидний гэрийнхэн, бусадтай харилцах харилцаа, гэр бүлүүд, сүнслэг байдал, сүм чуулган гээд бүх зүйл эерэгээр өөрчлөгддөг. Эдгээр өөрчлөлтүүд аажмаар чимээгүйхэн бий болдог. Бурханы энэхүү цэвэршүүлэх үйл явцыг дараа нь бид хараад их гайхдаг. Эдгээр өөрчлөлтүүд нь Бурханы оршихуйг илүү ихээр мэдрүүлж, амьдралыг илүү амар тайван болгодог."

Ариун Сүнсээр дамжуулан "Христ бидний дотор" байснаар эв нэгдэлтэй байдалд ямар эерэг үр нөлөө үзүүлдгийг та харж байна уу?

Нэгэн эмэгтэй надад дараах зүйлсийг хэлсэн юм: Бурханд таалагдсан сайн амьдрал уруу хөтлөх зам нь ийм байна гэдгийг би үргэлж төсөөлж байсан, гэхдээ энэ замд олон саад бэрхшээл учирсан билээ. Миний мөрөөдөл эцэст нь нэг биелсэн. Тэгээд энэ бол зөвхөн эхлэл![4] Энэ эмэгтэй сэтгэл татам итгэлийг олжээ.

3. Есүсийг гэрчлэх. *"Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно."* (Үйлс1:8) Есүс дагалдагчдад хандан та нар Миний гэрч байхын тулд Ариун Сүнсээр хүчирхэгжинэ гэжээ.

Ариун Сүнсээр дүүрэн байх үедээ бид сүнслэг сэргэлт, өөрчлөлтийг мэдрэх болно. **Сэргэлт гэж юу вэ?** Деннис Смит үүнийг ийн тайлбарлав: "Энэ бол итгэгч хүний амьдрал Есүсийн дотор өөрчлөгдөх цаг хугацаа юм. Авралын баяр хөөр түүний зүрх сэтгэлийг дүүргэж, бусдыг аврах хүсэл зүрхэнд нь шатаж эхэлдэг. Сүнслэг сэргэлтийг авсан итгэгч хүмүүс бид бусдыг аврахыг маш их хүсдэг."[5]

Элен Уайт ийн хэлжээ: "Бурханы Сүнсний оршихуй байхгүйгээр ямар ч зүрх сэтгэл өөрчлөгдөхгүй, ямар ч нүгэлтэн Христ дээр ирэхгүй. Христийн шавь нар Түүнтэй холбоотой байх үед, мөн тэдэнд Сүнсний бэлгүүд байх үед, тэдний хамгийн сул дорой, үл тоомсорлогдсон нэгэн ч бусдад Бурханыг таниулах хүч нөлөөтэй байх болно. Бурхан тэднийг дэлхий ертөнцөд хамгийн их нөлөө үзүүлэх хүмүүс болгодог."[6]

Алдарт сайн мэдээ түгээгч, сэргэлтийн номлогч Р. А. Торрей нэгэн гайхалтай гэрчлэлийг хуваалцжээ. Маш чадварлаг нэгэн эмэгтэй пастор авралын талаар нэг эрэгтэйтэй хоёр цагийн турш ярилцсан боловч ямар ч үр дүнд хүрсэнгүй. Тиймээс номлогч Торрейгээс тэр эрэгтэйтэй ярилцахыг

4 2012 оны 12 сарын 18-нд Хэлмут Хаубэйлд ирсэн имэйл

5 Деннис Смит: *40 Өдөр:* Бурхантай харилцах харилцаагаа сэргээх мөргөл болон залбирал" 6 дахь өдөр, х. 24

6 Элен Уайт, *Та Нар Хүчийг Олно,* 10 сарын 25; х. 307.

хүсчээ. Арван минутын дараа тэр эр эрэг шийдвэр гаргажээ. Номлогч Торрей эмэгтэй пасторын ашигласан Библийн эшлэлүүдийг ашигласан тул эмэгтэй пастортэ хэлэх үг олдсонгүй. Торрей энэ явдлыг ийнхүү тайлбарлав: "Эмэгтэй ямар ч үр дүн гаргаагүй юм чинь надад ч бас ийм зүйл тохиолдох вий гэдгээс би айсан юм. Тиймээс би Бурханаас Ариун Сүнсийг гуйн энэ ажлыг хийхийг хүссэн. Тийнхүү Тэр ажлаа хийсэн юм."[7]

Сүнслэг сэргэлт нь сайн мэдээний ажлыг үр дүнд хүргэдэг

"Ариун Сүнсийг хүлээн авах хүртлээ сайн мэдээг тараах хүч хүлээн авч чадахгүй. Хүмүүс Ариун Сүнсийг хүлээн авах хүртлээ Бурхан тэднээр дамжуулан юу хийж чадахыг ойлгохгүй."[8] Бидний зан чанар, хайр дотор эв нэгдэлтэй байгааг хараад бусад хүмүүс бидэнд татагддаг байхаар Бурхан төлөвлөсөн. Энэ нь бидний хүүхэд залуус, гэр бүлийн гишүүд, хамаатан садан, танил, хөрш, хамт ажиллагчид, найз нөхөд, танихгүй хүмүүст хамаатай. Хүмүүс бидний итгэлийн нөлөөнд автдаг гэсэн үг. Харин Бурхан хүмүүсийг бидэн рүү чиглүүлж чаддаг.

Дараах үгс нь бидний зан байдал бусдад ямар хүчтэй нөлөө үзүүлдэг болохыг харуулдаг. "Хэрэв бид Бурханы өмнө даруу байж, элдэг зөөлөн, өрөвч сэтгэлтэй байх аваас ганцхан хүн зуу зуун хүнийг үнэн рүү авчрах болно"[9] гэжээ. Энд Ариун Сүнс зайлшгүй хэрэгтэй. Элен Уайт пасторуудын анхаарлыг дараах зүйлсэд хандуулдаг: "Тэд [сүмийн гишүүд] Ариун Сүнсний тусламжгүйгээр Бурханы ариун үгийн агуу үнэнийг ойлгож чадахгүй. Бурханы хүч болох Ариун Сүнс тэдний хүсэлт шаардлага, хүлээн авалтыг хүлээж байдаг."[10]

Сүнслэг сэргэлтийг хэрхэн хадгалах вэ?

Мичиган мужийн Батл Грийк хотод байдаг Адвентист байгууллагуудад 1893 онд сэргэлт болжээ. Бурхан Элен Уайтад энэ явдлын талаар ойлголт өгсөн байна: "Хэрэв олон хүн гэгээрч, тэдэнд өгөгдсөн зүйлийг бусдад илчлэх зорилгоор ажиллавал Бурхан тэдэнд илүү их гэрлийг тусгаж, илүү их хүч чадлыг өгөх болно."[11]

---

7 R. A. Torrey, Der Heilige Geist (Frankfurt/Main: 1966), S. 37, 38; a short summary.

8 Элен Уайт, *Та Нар Хүчийг Олно,* 10-р сарын 4; х. 286.

9 Элен Уайт, *Сүмүүдэд Өгөх Гэрчлэл* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2002),9: х.189

10 Элен Уайт, *Пастор болон Сайн Мэдээний Ажилчдад Өгөх Гэрчлэл,* х. 175.

11 Элен Уайт, *Сонгомол Мэдээнүүд,* 1-р ном; х. 129.

Бид сайн мэдээг түгээснээр илүү их гэрэл, их хүч чадлыг олж авдаг. Бид бусад хүмүүст санаа тавин халамж үзүүлснээр өөрсдийн маань амьдралд үнэ цэнэтэй үр дагавар бий болдог. Иймээс 40 өдрийн мөргөлд оролцоогүй хүмүүст оролцохыг уриалах нь туйлын чухал юм.[12]

Сайн мэдээг хаанаас эхлэх хэрэгтэй вэ?

Есүс дагалдагчдадаа ажлаа хаанаас эхлэхийг хэлж өгсөн: Тэд хаана байгаа газраасаа эхлэх хэрэгтэй. Бидний хувьд энэ нь гэрээсээ буюу биднийг мэддэг хүмүүстэй газраас эхлэх хэрэгтэй гэсэн үг. Есүс яагаад ингэж төлөвлөсөн бэ? Хэрэв бид зохих ёсны хайрын хандлагатай зан чанарыг үзүүлэх аваас биднийг мэддэг хүмүүс хүлээн зөвшөөрөх болно. Бидний амнаас гарах үг болон амьдрал маань хоорондоо таарах ёстой. Хэрэв бид үнэхээр Ариун Сүнсээр дүүрэн байдаг бол энэ нь гэр бүлийнхэнд харагдах болно.

Есүсийн шинэ тушаалд ямар чухал зүйл байдаг вэ?

Иохан 13:34, 35 дээр Есүс ийн хэлжээ: *"Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно."*

Сүнсээр дүүрэн амьдрал нь цаашлаад Сүнсний чухал үр жимс болох даруу дөлгөөн байдлыг авчирдаг. Даруу дөлгөөн байдал нь Есүсийн оюуны төлөв байдал бөгөөд энэ нь эв эетэй байхад нэн шаардлагатай. Есүс дагалдагчдынхаа хөлийг угаасны дараа энэ шинэ тушаалыг өгсөн. Хөл угаах ёслол нь даруу дөлгөөн байдлын илэрхийлэл юм.

Даруу дөлгөөн байдал нь хүний төрөлх чанар биш юм. Тиймээс бид Мика 6:8 дээрх шиг амлалтуудыг барин даруу дөлгөөн байдлыг Бурханаас өдөр бүр гуйх хэрэгтэй.

Сүнсээр дүүрсэн хүнд даруу төлөв байдал нь маш чухал шинж чанар боловч үүнийг хүмүүс тэр болгон авч хэлэлцдэггүй билээ. Есүс шинэ тушаалдаа *"Би та нарыг хайрласан шиг бие биенээ хайрлах тухай"* хэлсэн. Есүс биднийг бурханлаг хайраар хайрладаг. Бид энэ төрлийн хайрыг АГАПЕ буюу грекээр бурханлаг хайр гэж нэрлэдэг. Бид зөвхөн Ариун Сүнсээр дүүрсэн үедээ л энэ хайрыг агуулж чаддаг. Паул ийн бичжээ: *"... Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг"* (Ром 5:5). "Бурханы хамгийн

12 Деннис Смит, *40 Өдөр:* 1 болон 2-р ном, Оршил. Сайн мэдээг хаанаас эхлэх хэрэгтэй вэ?

дээдээр хайрлах хайр, мөн хувиа үл хичээн бие биенээ хайрлах хайр нь Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн хамгийн сайхан бэлэг юм. Энэ хайр нь сэтгэл хөдлөл биш харин бурханлаг зарчим, тогтвортой хүч юм. Ариусгагдаагүй зүрх сэтгэлээс энэ хайр гарах боломжгүй билээ. Зөвхөн Есүс оршдог зүрх сэтгэлээс л гарна."[13]

Тиймээс бидний зүрх сэтгэлийн "Сэнтийд" Есүс заларсан үед л даруу дөлгөөн байдал бий болно. Бид амьдралынхаа бүхий л зүйлийг Түүгээр удирдуулан зохицуулахыг зөвшөөрдөг үү? Бид Түүнд амьдралаа бүрэн даатгасан уу? Бид үүнийг өдөр бүр баталгаажуулдаг уу?

Миний хувьд ямар байна вэ?

Надад сэтгэл татам итгэл байна уу? Есүс Ариун Сүнсээр дамжуулан миний зүрх сэтгэл дотор амьдардаг уу? Хэрэв тийм бол би анхаарал тавьж, энэхүү сэтгэл татам итгэлдээ өсөх хэрэгтэй. Хэрэв надад хараахан сэтгэл татам итгэл байхгүй байгаа бол энэ чухал асуулттай нүүр тулах ёстой.

Энэхүү сэтгэл татам итгэлийг олж авахад туслах (энэ итгэл байхгүй байгаа хүмүүст), мөн энэ итгэлээ өсгөхөд (энэ итггэл байгаа хүмүүст) тус болох аргуудыг миний бичсэн *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* болон Деннис Смитийн бичсэн *40 Өдөр - Эзэний Дахин Ирэлтэд Бэлтгэх Мөргөл ба Залбирал* номоос уншиж болно. Энэ хоёр ном үнэ цэнэтэй санаануудаараа нэг нэгнийгээ гүйцээдэг. Би бүхий л зүрх сэтгэлээрээ энэ хоёр номыг уншихыг санал болгож байна. Тиймээ, бүр олон удаа унших хэрэгтэй.

Ариун Сүнсээр дутмаг байдал нь бусад хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?

Есүс Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор оршихгүй байваас бид махан биеийн итгэгчид юм. (1 Кор. 3:1–3; Ром 8:1–17; Гал. 5:16-г харна уу). Бид тийм байдалд байвал аврагдахгүй (Ром 8:9). Бид өөрсдийн буюу хүний хүч чадал, чадвараар амьдарч байна гэсэн үг. Үр дүнд нь бидний гэр бүл, үр хүүхдүүд бас махан биеийн итгэгчид болж, харамсалтай үр дагаварт унах боломжтой.[14] Бурханы хайр зөвхөн Ариун Сүнсээр дамжин бидний зүрх сэтгэлд орших боломжтой гэдгийг санаарай. Элен Уайтын хэлснээр: "Христийн сэтгэл татам хайрыг хэзээ ч мэдрээгүй хүмүүс бусдыг амийн ундарга руу хөтөлж чадахгүй. Зүрх сэтгэлд орших Түүний хайр нь агуу хүч бөгөөд биднийг хүмүүстэй харилцахдаа Түүнийг элдэгээр гэрчлэх

13 Элен Уайт, *Элч Нарын Үйлс,* х. 551.

14 Хелмут Хаубэйл, *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам,* х. 36, 74, 76.

байдал уруу хөтлөх ба тэдгээр хүмүүсийн амьдралыг дээш хандуулдаг."[15]

Есүс Ариун Сүнсээр дамжуулан бидний дотор орших үед бид аяндаа Бурханы тухай гэрчлэх хүсэлтэй болдог. *"Учир нь зүрхний бялхалаас ам ярьдаг"* (Матай 12:34).

Сэтгэл татам итгэл хэр үнэ цэнэтэй вэ?

Итгэл үнэмшлээсээ татгалзахаас илүүтэйгээр хавчлага, эд хөрөнгөө алдах эсвэл амь насаа алдахыг илүүд үзсэн Христэд итгэгчдийн амьдралыг харваас бид энэхүү сэтгэл татам итгэл ямар үнэ цэнэтэй болохыг ойлгож болно. Тэднийг эдгээр гашуун зовлонг даван туулахад юу ийм хүчтэй болгосон бэ? Тэд Бурханы сүнсээр дүүрэн байсныг бид ойлгож байгаа ч, тухайн үедээ тамлагдан зовж байгаа зовлон шаналал хэр их байсныг бид хэлж чадахгүй.

Хасс, Иером хоёрын нас барсан явдлыг бичиж үлдээсэн папын тайлан бидэнд чухал тайлбарыг өгдөг. Хэрэв хэн нэгэн хүн шатвал тэрээр орилж хашгирдаг. Харин энэ хоёр хүн магтан дуу дуулж байсан. Ийм байдал зөвхөн Бурханы тусламжтайгаар боломжтой юм. Тэд зовлон тарчлалыг үл хайхран жинхэнэ баяр хөөртэй байжээ. "Түүний Сүнс хаанчилж байгаа газарт амар амгалан оршин байдаг. Мөн баяр баясгалан байх болно."[16]

XVIII зууны үед Францад амьдарч байсан Дюрантын гэр бүл бол гайхалтай жишээ юм. Дюрантын гэр бүл Библийн дагуух итгэлээсээ болж сүмдээ хавчигдаж байв. Эцэг нь өршөөгдөхөөсөө өмнө арван дөрвөн жил шоронд суужээ. Эх нь шоронд нас баржээ. Номлогч хүү Пьер нь цаазаар авахуулсан. Охин Мэри нь бусад эмэгтэйчүүдийн хамт цайзад хоригджээ. Хэрэв тэр итгэлээсээ татгалзвал түүнийг суллах байв. Гэвч тэр тэгсэнгүй. 1768 онд тэрээр гучин найман жилийн хорих ял эдэлсний дараа суллагдсан байна. Мэри Дюрантын хувьд Библийн итгэл үнэмшил нь бууж өгч боломгүй сэтгэл татам итгэл байв.[17]

Агуу миссионерүүдийн нөлөө

Даниел болон түүний найзууд өөр хоолны дэглэмтэй байхыг хүсэх үедээ үүсч болох аюулыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байв. Тэгээд Бурхан юу хийсэн бэ? Тэр тэдний дуулгавартай байдлыг ивээсэн. Тэд бусдаас илүү царайлаг, эрүүл саруул, илүү ухаантай байв. Тэд өндөр албан тушаалд томилогдсон. Даниелын найзууд галт зууханд орсныг мөн Даниел арслангийн нүхэнд шөнийг өнгөрүүлсэн тухай түүхийг бид мэднэ. Тэдний

15 Элен Уайт, *Элч Нарын Үйлс,* х. 550, 551.

16 Элен Уайт, *Ye Yeийн Хүслэн,* х. 153.

17 Википедиагаас авав. "Мэри Дюрант"

итгэл бишрэл аминаас нь илүү чухал байв. Тэгээд үр дүн нь ямар байсан бэ? Жинхэнэ Бурханы тухай тэдний гэрчлэлийг дэлхийн хоёр том гүрэн үг болон үйлдлээс нь харсан. Тэдний үлгэр жишээч байдал нь Бурханы ажилд асар том нөлөө үзүүлсэн юм.

Египетэд байсан Иосефт төстэй зүйл тохиолдсон. Тэр завхайрахаас татгалзсан юм. Потифарын эхнэрийн гүтгэлгээс болж тэрээр шоронд хоригдов. Гэвч Бурхан түүний үнэнч байдлыг ашиглан эзэнт гүрэн даяар жинхэнэ Бурханыг мэдүүлсэн билээ.

Нааманы гэрт зарцлагдаж байсан жаахан охиныг санаж байна уу? Охин үг, үйлдлээрээ гэрчилсэн учраас цэргийн жанжин эдгэрэхэд хүрсэн. Тэр жанжин баяр хөөртэйгөөр амьд Бурханыг дагаад зогсохгүй мөнөөх жаахан охиныг эрх чөлөөтэй болгож, олон бэлэг сэлтийн хамт гэрт нь хүргэж өгсөн гэдэгт би итгэлтэй байна.

Матай 13:44–46 дээр Есүс тариан талбайгаас эрдэнэс олсон хүний тухай өгүүлдэг. Энэ эрдэнэс нь маш үнэ цэнэтэй байсан тул тэрээр өөрийн эзэмшлийн бүх зүйлийг зарж, талбайг худалдаж авдаг. Тэрээр тэнгэрийн хаант улсын төлөө бүх зүйлээ өгчээ. Үүнийг би сэтгэл татам итгэл гэж хэлнэ. Энэ итгэл хичнээн үнэ цэнэтэй болохыг харж байна уу?

Дүгнэлт

Элен Уайт ийн хэлдэг: "Есүсийн дотор байгаа хүмүүс аз жаргалтай, баяр хөөртэй байх болно."[18] Сэтгэл татам итгэл нь бидэнд баяр хөөртэй, эрч хүчтэй, ялгуусан, аз жаргалтай амьдралыг, Бурханы хаанчлалд орох итгэл найдварыг өгдөг. Хэцүү цаг үед, харанхуй хөндийгөөр туулсан ч Бурханы оршихуй дотор бидний итгэл улам л сэтгэл татам байх болно.

Сэтгэл татам итгэлээр бид нэгдмэл байдлаа нэмэгдүүлж чадна. Ингэснээр бусад хүмүүст бидний итгэл илүү ихээр таалагдах болно. Нэгдмэл байдлын ач холбогдлыг бүрэн дүүрэн ойлгоход Бурхан бидэнд туслах болтугай! Тэрээр Ариун Сүнсний хүчээр дамжуулан биднийг Христтэй адилхан болгон өсгөж, мөн бидний хайртай хүмүүс болон бусад хүмүүсийн анхаарлыг татахад туслах болтугай.

"Эзэний баяр хөөр чиний хүч юм" (Нехемиа 8:10). **"Хэрэв бид Христийг төлөөлдөг бол Түүний үйлчлэлийг үнэхээр сэтгэл татам байлгах ёстой."**[19]

---

18 Элен Г. Уайт, *Сүмүүдэд Өгөх Гэрчлэлүүд,* (Nampa, ID: Pacific Press Publishing Association, 2002),

19 Элен Г. Уайт, *Христэд Хүрэх Зам,* х. 116.

Залбирал: “Тэнгэрлэг Эцэг минь, Есүсийг дагах нь хамгийн сэтгэл хөдлөм амьдралыг авчирдагт би чин сэтгэлээсээ талархаж байна. Амьдралынхаа туршид Есүстэй дотно харилцаа холбоотой байхад минь туслаач. Хайртай хүмүүсээ болон бусад хүмүүсийг Есүс рүү чиглүүлэхийн тулд миний амьдралыг ашиглаач. Амен.”

Таны Бодол ба Ярилцах Сэдвүүд

1. *Христ бидний дотор байснаар ямар өөрчлөлт гардаг вэ?*

   _____

2. *Сүнсний үр жимс гэж юу вэ?*

   _____

3. *Сүнсний ямар бэлгүүд байдаг вэ?*

   _____

4. *Сэргэлт шинэчлэлт бидний амьдралд ямар нөлөө үзүүлдэг вэ? Энэ нь бидний эргэн тойронд хэрхэн нөлөөлдөг вэ? Түүнчлэн биднийг хэрхэн өдөөдөг вэ?*

   _____

5. *Бурханд итгэх энгийн итгэлээр дамжуулан агуу зүйлс тохиолдож болох Библийн ямар жишээнүүд байдаг вэ?*

   _____

Залбирлын цаг

- *Залбирлын хамтрагчтайгаа холбогдож, сэдвээ ярилцаарай.*
- *Залбирлын хамтрагчтайгаа хамтдаа залбираарай:*
  1. *Таны дотор Сүнсний үр жимс байнга ургахын төлөө*
  2. *Сүнсний бэлгээ таньж мэдээд зохих ёсоор нь ашиглах чадварын төлөө*
  3. *Таны дотор орших Христийг гэрчлэх баяр хөөр болон чин зоригийн төлөө. Амьдрал, үг, үйлдлээрээ гэрчлэх нь өөрийн хүч чадлаас бус харин сэтгэл татам итгэлээс гардаг зүйл билээ.*
  4. *Бурханы үгийг судалж, эрүүл саруул, мэргэн ухааны баяр хөөрийг мэдрэхийн төлөө*

ГЭРЧЛЭЛ

Бурханд бууж өгсний дараа гарсан өөрчлөлтийн тэмдэглэл

Би 2014 оны эхээр өөрөөсөө "Есүс надад нэг л өдөр: "Би чамайг таних билүү?" гэж хэлбэл яах вэ? Би мунхаг онгон охидын нэг юм болов уу?" хэмээн асууж байв. Энэ бодол намайг тэвчихийн аргагүй болгож байлаа, учир нь би Бурханаас мөнхийн амь авахыг хүсч байсан юм. Гэхдээ би амьдралынхаа янз бүрийн асуудлаас болж үргэлж зөв замаар явж чаддаггүй байсан учраас гэм бурууТай мэдрэмж надаас салдаггүй байлаа.

Аз болоход, надад *Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам* болон *Есүсийн Дотор Байгтун* хэмээх номуудыг унших боломж олдсон юм. Номуудыг анх удаа уншсаны дараа миний амьдралд ямар нэгэн зүйл өөрчлөгдөх ёстойг ойлгов. Бүх зүйлийг сайтар ойлгохын тулд би товхимлуудыг хэд хэдэн удаа уншлаа. Мөн хэдхэн сарын өмнө би нэг сүнслэг итгэгч эмэгтэйн гэрчлэлийг сонссон юм.

Жилийн эхэнд би "Махан биеийн" итгэгч байсан тул Есүс намайг "Би чамайг танихгүй" гэж хэлэх байсан, тиймээс би үхэх тавилантай байсан гэдгээ одоо сайн ойлгож байна.

Харин би Есүст бүрэн бууж өгснөөр Бурхан миний амьдралыг ердөө нэгхэн сарын хугацаанд бүрэн өөрчилж чадсан юм.

Одоо би өглөөний 4:30-д босож, Бурханы үгийг судалдаг. Би өөрийн хүчээр ийм зүйлийг хийж чадахгүй байсан, миний хувьд унтах нь илүү чухал байх байсан. Түүнчлэн залбирахдаа би өөрөөр буюу Сүнсээр дүүрсэн хүн шиг залбирдаг болсон. Би өдөр бүр залбирахдаа Эзэн надаар тухайн өдөр юу хийлгэхийг хүсч байгааг асуудаг. Бурхан ч хариулдаг. Би бас Ариун Сүнсийг зүрх сэтгэлдээ урин оруулж, ажлаа хийхийг өдөр бүр хүсдэг. Тэгснээр миний бодол санаа цэгцэрч, би илүү "Эмэгтэйлэг" хувцасладаг болсон.

Түүнээс гадна би байнга идэхээ больсон. Миний хувьд байнга хоол идэх зуршлаа өөрийн хүчээр зогсоох боломжгүй байв. Би өдөр тутмын хэрэгцээ шаардлагаа илүү амар тайвнаар зохицуулж сурсан ба стресс миний ходоодыг зангируулахаа больсон. Нөхөр маань миний өөрчлөлтийг гурван долоо хоногийн дараа анзаарч, "Чи өмнөх шигээ хэл амтай байхаа больсон байна" гэж хэлсэн юм.

Библи судалж байхад минь урьд өмнө хэзээ ч бодогдож байгаагүй олон асуулт гарч ирдэг болов. Одоо би илүү гүнзгий судлахыг хүсч байна. Өмнө нь Ариун Сүнс надад хааяа нэг гэрчлэл ярих боломж өгдөг байсан бол одоо харин ийм зүйл өдөр бүр тохиолддог. Би ярих зүйлээ бэлтгэх шаардлагагүй болсон. Бурхан надад хэлэх зөв үгийг минь өгдөг. Заримдаа би нүгэл үйлддэг ч, Бурхан надад тухайн нүглийг харах

тодорхой мэдлэгийг өгдөг. Би гэмээ гэмшиж, өөрийн замаа өөрчилж чадна.

Би Есүсгүйгээр юу ч хийж чадахгүй, миний алхам тутамд Христийн оршихуй хэрэгтэй гэдгийг ойлгосон. Би бас бардамналын (би хичнээн сайн юм бэ, би юмыг ямар сайн хийж чаддаг юм бэ) эсрэг зүйл бол даруу байдал гэдгийг ухаарсан. Даруу байдал нь биднийг Есүсгүйгээр ямар ч сайн зүйл хийж чадахгүй гэдгийг ойлгуулдаг.

Бурхан надад кофе уухаа болих хүчийг өгсөн. Өмнө нь би үүнийг төсөөлдөг ч үгүй байлаа. Учир нь кофе уухаа болих үед толгой минь таван өдрийн турш аймшигтай өвддөг байв. Энэ бол хүнд хэлбэрийн шинж тэмдэг юм. Харин энэ удаа би ямар үр дагавар гарах талаар огт бодсонгүй. Би дахин ийм зүйл хийхийг хүсэхгүй байгаагаа л мэдэж байв. Өнөөдөр би кофе уух хүсэлгүй болсон.

Надад бас мах идэх дуршил маш их байсан. Манай гэр бүлийнхэн бүгд мах идэхээс хэзээ ч татгалздаггүй байв. Харин өнөөдөр миний хувьд энэ асуудал хялбар болсон. Мах идэх хүсэл маань байхгүй болжээ. Амьдралд минь эргэлт авчирсан зүйл бол мөнхийн амьдралыг маш ихээр хүсэж, Аврагч Христ Есүсээс өөр юу ч чухал зүйл биш гэдгийг ухаарсан явдал юм.

Езекиел 36:26, 27 дээр үнэнийг хэлсэн байдаг: Есүс бидэнд шинэ зүрх, шинэ сүнсийг өгөх болно. Тэрээр биднийг Өөрийнх нь зарлигуудыг сахидаг хүмүүс болгохыг хүсдэг. Хэдэн арван жилийн турш би янз бүрийн асуудалтай тулгарч байсан нь дэмий хоосон зүйл байжээ. Би тэдгээр асуудлыг өөрийн хүчээр ялж чадахгүй байсан байна. Есүс надаар дамжуулан Өөрийн хүслийг гүйцэлдүүлэхийг хүсдэг. Түүнд зөвхөн миний зөвшөөрөл хэрэгтэй байжээ.

Элен Уайтын хэлснээр, хуулийг сахих замаар тэнгэрт хүрэхийг хичээдэг хүн боломжгүйг үйлдэж байна. Энэ бол яг миний гучин таван жилийн турш хийж байсан зүйл юм. Би оюун санаандаа Бурханы тушаалуудтай санал нийлдэг байсан боловч биелүүлж чаддаггүй байв. Зөвхөн Есүс л үүнийг миний дотор үйлдэж чадна. Тэр бидэнд сайн сайхан, эрүүл зүйлсийг хүсэх хүслийг өгдөг бөгөөд хор хөнөөлтэй зүйлсийг хүсэх хүслийг биднээс арилгадаг.

Өнөөдөр би Ром 8:14-г баталж чадна: *"Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм."* Энэ эшлэлийн дагуу бид өдөр бүр, цаг тутам, Ариун Сүнсийг гүйн залбирч, бидний дотор ажиллахыг хүсэх ёстой. Учир нь чөтгөр унтдаггүй юм.

Есүс Матай 10:37 дээр ингэж хэлжээ: *"Эцгийгээ, эсвэл эхийгээ Надаас илүү хайрладаг хүн Миний хувьд зохистой нэгэн биш юм. Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрладаг хүн ч Миний хувьд зохистой нэгэн бишээ."* Энэ зүйлийг би боломжгүй гэж үргэлж боддог байв. Харин одоо

би Есүс миний зүрх сэтгэлд байгаа тохиолдолд орчлон ертөнцийн агуу Бурхан миний дотор ажиллаж мөн надаар дамжуулан үр хүүхдүүд, гэр бүлийнхэнд минь надаас илүү анхаарал халамж тавьж чадна гэдгийг мэдэж авсан. Зөвхөн Бурхан бүхнийг чадагч, бүхнийг мэдэгч билээ. Би одоо итгэлтэйгээр амьдралаа өдөр бүр Түүний гарт даатгадаг ба тэр Өөрийн төлөвлөгөө болон мэргэн ухааны дагуу бүх зүйлийг зөв хийх болно. М.М

ХАВСРАЛТ

Цаашид судлах зөвлөмж

Чухал санамж: Энэ товхимлыг хэд хэдэн удаа уншина уу. Судалгаанаас үзвэл амьдралд хэрэгтэй чухал сэдвийг сайн ойлгохын тулд зургаагаас арван удаа унших хэрэгтэй гэдгийг нотолсон байна. Туршаад үзээрэй. Үр дүн нь таныг итгүүлэх болно. Би өмнө нь зохих нэг номыг дахин дахин уншсанаар амьдралдаа анх удаа Ариун Сүнсээр дүүрэхийг мэдэрсэн юм. Надад бас олон хүн Есүс дотор Ариун Сүнсээр дүүрэн амьдралаар өсөж байгаадаа талархаж урамшсан сэтгэлээ илэрхийлж байсан. Тэр хүмүүс бараг бүгдээрээ энэ номыг олон удаа уншсан хүмүүс билээ.

Сүнсээр дүүрэн амьдралын шинэ мэдрэмжүүд

Бидний Эзэн Есүс ингэж хэлжээ: "'Надад итгэдэг хүн "Түүний дотроос амийн усны булаг урсах болно" гэж Сударт хэлсэнчлэн байх болно гэв. Есүст итгэсэн хүмүүсийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ" (Иохан 7:38,39).

Би та бүхнээс хүсэх хүсэлт байна: Хэрэв та Есүст бууж өгөн Ариун Сүнсээр амьдарсан туршлага байгаа бол өөрийн товч гэрчлэлийг над уруу (Хелмут Хаубэйл) явуулбал үнэхээр талархах болно. Бидний хувьд гэрчлэлүүдийг www.steps-to-personal-revival.info сайтны testimonies хэсэгт, мөн сонин хэвлэлд нийтлэх нь үнэхээр үнэ цэнэтэй зүйл юм. Дүрмийн дагуу бид зөвхөн нэрний эхний үсгийг тавьдаг. Таны гэрчлэл бусад хүмүүсийг удахгүй ирэх Аврагч Есүс Христэд итгэх итгэлдээ Сүнсээр дүүрэн алхахад, мөн итгэлээр өсөхөд хүчирхэгжүүлэх болно гэдгийг санаарай.

Холбоо барих:

Helmut Haubeil
RosenheimerstraЯe 49
D-83043 Bad Aibling / Upper Bavaria
Email: helmut@haubeil.net
Утас: + 49- (0) 8061-4900 712
Хүлээж авах хэл: Герман эсвэл Англи



ХУВИЙН СҮНСЛЭГ СЭРГЭЛТИЙН АЛХАМ

Ариун Сүнсээр дүүрэн байх нь

Бидний Эзэн Өөрөө энэ тушаалыг өгсөн:[1] Өөрсдийгөө тасралтгүй, дахин дахин сүнсээр дүүрэн байлга![2]

1 Элен Уайт, Ерөөлийн Улан Дээрх Сургаал, MB 20.3

2 Johannes Mager, Auf den Spuren des Heiligen Geistes (Lьneburg, 1999), p. 101

Захиалга – Мэдээллийн хуудас 2

УДИРДАГЧДАД ЗОРИУЛСАН ӨМНӨХ ҮГС

ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

БҮЛЭГ 1: ЕСҮСИЙН ХАМГИЙН НАНДИН БЭЛЭГ

Есүс Ариун Сүнсний талаар юу гэж сургадаг вэ?
Есүсийн хүчирхэг мэдээ танд танил санагдаж байна уу?

БҮЛЭГ 2: БИДНИЙ АСУУДЛЫН ЦӨМ НЬ ЮУ ВЭ?

Бидний асуудалд сүнслэг шалтгаан бий юу?
Энэхүү шалтгаан нь Ариун Сүнс дутагдсанаас бий болсон уу?

БҮЛЭГ 3: БИДНИЙ АСУУДЛУУД ШИЙДЭГДЭЖ БОЛОХООР УУ?

Бид хэрхэн аз жаргалтай, хүчирхэг Христэд итгэгчид байж чадах вэ?
Ариун Сүнс хэрхэн бидний амьдралыг дүүргэдэг вэ?

БҮЛЭГ 4: БИД ЯМАР ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ ХҮСЭН ХҮЛЭЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Ариун Сүнсээр дүүргэгдсэн амьдралаар амьдрах нь бидэнд ямар давуу талтай вэ?
Хэрэв бид Ариун Сүнсийг хүсэн залбирахгүй бол юу алдах вэ?

БҮЛЭГ 5: АМЬДРАЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА

Бурханы надад зориулсан шийдлийг амьдралдаа хэрхэн мэдэрч мөн хийж гүйцэтгэх вэ?
Ариун Сүнсээр дүүрэхийн тулд хэрхэн залбирах вэ?

БҮЛЭГ 6: БИДНИЙ ӨМНӨ ЯМАР ГЭРЧЛЭЛ БАЙГАА ВЭ?

Өөрийн туршлагууд мөн чуулган сүмүүдийн туршлага

БҮЛЭГ 7: ҮҮНИЙГЭЭ БУСАДТАЙ ХУВААЛЦАХ НЬ

Бусдад өгсөн баяр хөөр нь бидэнд буцаж ирдэг. (Герман сургаалт үг)
"Бялхсан амьдралыг" мэдрүүлэхийн тулд бид тэдэнд хэрхэн туслах вэ?
Энэ мэдээг хэрхэн дамжуулах вэ? Ямар арга замууд байна вэ?

Би одоогоор Калифоринд хоёр сүм ахлан ажиллаж байна. Би анх пастор Двайт Нелсоны долоо хоног бүрийн подкастыг сонсож байхдаа таны номтой танилцсан юм. Энэ нь анхнаасаа л миний сэтгэлийг маш их хөдөлгөсөн. Би өмнө нь Ариун Сүнсний талаар өөр зүйлсийг сонсож байсан боловч, хэзээ ч ингэж анхаарал хандуулж байгаагүй. Бурхан ямар нэгэн шалтгаанаар олон хүнд Ариун Сүнсээр дамжуулан хүрэхийн тулд яг энэ цагийг сонгосон гэдэгт би баттай итгэж байна. Таны хүчин чармайлтаар үүнийг олсондоо би үнэхээр их баяртай байна.

Би танд нэг зүйлийг батлан хэлье. Яг эхний бүлэгт бидэнд энгийн аргаар боловч маш хүчирхэг үнэнийг танилцуулдаг, эхлээд бидний тархийг зогсоогоод тэгээд дахин бодоход хүргэдэг. Олон дахин унших үйл явц бол үнэхээр үр дүнтэй шүү. Энэ номын талаар миний ярилцсан, зөвлөлдсөн, мөн номлосон хүмүүст Ариун Сүнсний сэдэв илүү сонирхолтой болж байсан юм. Энэ талаар бид анх удаа сонсож байгаа мэт байдаг байлаа. Би үүнийг өөрөөсөө мэдэрсэн юм. Би эхний бүлгийн утга санаанаас гурван номлол бэлдэх хүртлээ салж чадахгүй байсан. Үүнийг би хэрхэн илүү сайн тайлбарлахаа мэдэхгүй байна, ямар ч байсан би энэ номыг уншихаа зогсоож чадахгүй байсан ба үр дүн нь сүмүүдэд маань мэдрэгдсэн. Би энэ мэдээний дуу хоолой болсон ба дүүрэгт маань өнгөрсөн жил мэдэгдэхүйц өсөлт гарсан юм. Энэ бүхэн гишүүдийг маань хүчирхэгжүүлж буй Ариун Сүнс болон Бурхантай холбоотой. Ирэх жил илүү олон хүн ирнэ гэдэгт бид итгэж найдаж байна. Д.Р. 2018 оны 1 сар.

Андрюс Их Сургуулийн Мемориал сүмийн ахлах пастор Двайт Нелсоны хэлснээр энэ бяцхан ном *[Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам]* "Миний доторхыг өөрчилсөн. Танд адилхан зүйл тохиолдохыг би хүсч байна."

Тэрээр цуврал гурван номлол номлосон:
"Тэг хязгаар болон шинэ өөрчлөлт: Хэрхэн Ариун Сүнсээр баптисм хүртэх вэ?"
Тэрээр номлолдоо *"Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам"* номоос эш татан уг номыг хүмүүст санал болгосон юм. Энэ явдлаас болж олон мянган хүн тус номыг татан авж, мөн захиалсан.

Түүний хувийн гэрчлэл болон гурван номлолыг:
www.steps-to-personal-revival.info сайтнаас харж болно.

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

Есусийн Доктор Байгтун

Үүнийг хэрхэн хийх вэ?

Хэлмут Хаубэйл нь пастор бөгөөд бизнесмен хүн юм. Тэрээр тээврийн компанид төлөөлөгчөөр амжилттай ажилласны дараагаар 37 насандаа Бурханы дуудлагад хариулж, үйлчлэлийн ажлыг 16 жил хийж байна. Дараа нь тэр Германы Бад Айблингийн Адвентист асрах газрын захирлаар ажиллажээ. Тэрээр тэтгэвэртээ гарсан хэдий ч орон нутгийн болон олон улсын хэд хэдэн төслийг хариуцан ажилладаг. Үүнд: Төв Ази, Энэтхэг, Германы газар нутагт сүм үүсгэн байгуулах төсөл, “Missionbrief” хэмээх сүмийн сэтгүүл болон сүнслэг сэргэлтийн ном хэвлэлийг эрхлэн гаргадаг. Тэрээр өөрийгөө *“Хувийн Сүнслэг Сэргэлтийн Алхам”* номын зохиогч гэж боддоггүй, харин Бурханы гарт ашиглагдсан багаж гэж үздэг. Www.steps-to-personal-revival.info сайтын Development хэсэгт дарснаар та гайхалтай гэрчлэлүүдийг унших боломжтой.

Хэн Миний доктор байж, Би мөн түүний доктор байна,
тэр их жимс гаргана.
Учир нь Надаас ангид та нар юу ч
хийж чадахгүй.

Уриалга

Туршлагаас харахад эдгээр чухал үнэнийг өдөр бүр судлахдаа хоёр хүн хамтарч хийвээс илүү их ивээгдэж байгаа нь батлагдсан. Хосууд хамтдаа хийж байгаа тохиолдолд хоёр дахин ивээгдэнэ! (Бусад хүмүүстэй утас эсвэл Skype-аар холбогдож болох юм). Түүнчлэн өдөр бүр эсвэл долоо хоног тутам бүлгээрээ ярилцаж, залбирах нь ихээхэн үр нөлөөтэй.